



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ*

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**НЭГДСЭН ХУРАЛДААН**



**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-77

---

<i>1.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.11.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	11-69
<i>2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	69-77

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 20-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 42 гишүүн хүрэлцэн ирж, 55.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.*

*Томилолттой: Ж.Батсуурь, Д.Бат-Эрдэнэ, Д.Цогтбаатар;*

*Чөлөөтэй: Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Л.Оюун-Эрдэнэ;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Э.Батиугар, Д.Сарангэрэл;*

*Тасалсан: Б.Жавхлан;*

*Хоцорсон: Ш.Адьяа – 2 цаг 15 минут, Т.Аубакир – 3 цаг 51 минут, С.Батболд – 2 цаг 08 минут, Б.Баярсайхан – 33 минут, С.Ганбаатар – 22 минут, Д.Ганбат – 13 минут, Ж.Мөнхбат – 1 цаг 53 минут, С.Одонтуяа – 31 минут, Ц.Сэргэлэн – 49 минут, Г.Тэмүүлэн – 13 минут.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 77 жилийн өмнө 1945 оны 10 дугаар сарын 20-ны энэ өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолын төлөөх бүх ард түмний санал хураалтыг явуулсан түүхэн өдрийн мэндчилгээг дэвшүүлэв. /алга ташив/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн, М.Оюунчимэг нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн, М.Оюунчимэг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

***Нэг.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.11.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Д.Төрболд, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа, “Трансперенси интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүн Л.Төр-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Зөвлөхүүдийн албаны зөвлөх

Ч.Батбямба, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Г.Амартүвшин, Б.Пүрэвдорж, Б.Энх-Амгалан, Б.Баярсайхан, Ц.Сандаг-Очир, Н.Алтанхуяг, С.Чинзориг, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр, Ж.Чинбүрэн, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Н.Энхболд, Ц.Мөнх-Оргил, Ц.Туваан, Ш.Раднаасэд нарын тавьсан асуулгад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, “Трансперенси интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүн Л.Төр-Од нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан 12 цаг 28 минутаас 13 цаг 34 минут хүртэл хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Энхбаяр, Б.Батгөмөр нар үг хэлэв.

*Үдийн завсарлагын цаг болсон тул хуралдаан 13 цаг 34 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 08 минутад эхлэв.*

*Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 18

Бүгд: 44

59.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Д.Төрболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

**Бусад.**Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын урилгаар “Хан Хэнтий” цогцолбор сургуулийн багш нар, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Х.Булгантуяа, Ж.Чинбүрэн нарын урилгаар Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн урилгаар Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан нарын урилгаар Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, С.Одонтуяа

нарын урилгаар Ерөнхий боловсролын “Оюуны ундраа” сургуулийн ахлах ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Т.Аюурсайхан, Ж.Сүхбаатар нарын урилгаар Чингэлтэй дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, сувилагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Х.Нямбаатар нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Л.Оюун-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ нарын урилгаар Хэнтий аймгийн музейн ажилчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 4 цаг 12 минут үргэлжилж, 76 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 88.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 50 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 04  
минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц өвчтэй, чөлөөтэй 7, ирэх ёстой 69 гишүүнээс 42 гишүүн ирж, 55.3 хувьтай ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Худалдаа, аж үйлдэрийн танхимын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнө өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Цэрэнпилийн Даваасүрэн, Мөнхөөгийн Оюунчимэг нараас бичгүүд ирүүлсэн байна.

Үндэслэлүүдээ Пүрэвдорж гишүүн тодорхой дурдсан байна. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгэхээр 2019 оноос хойш би Монгол Улсын 21 аймгийн хамгийн том сумуудаар явж иргэдтэй уулзалт хийж байгаа. Сая 19 дэх аймаг дээр нь буюу Дундговь аймгийн Эрдэнэдалай сум дээр иргэдтэй уулзалт хийсэн.

Энэ уулзалт хийж байхад иргэд маш олон саналуудыг хэлж байна. Тэгээд сумын Засаг дарга Б.Лхагвамандал гэдэг залуу тойргийн хоёр гишүүн С.Батболд гишүүн, Г.Мөнхцэцэг гишүүн нар энэ Эрдэнэдалай сум дээр ирж ажиллаач ээ. Иргэддээ харагдаач ээ гэж гуйж байна лээ.

**Г.Занданшатар:** Б.Пүрэвдорж гишүүн чуулганд хэлэлцэх асуудалтай холбоотой.

**Б.Пүрэвдорж:** Би энэ иргэдийн. Би хамгийн сүүлд нь хэлнэ.

Иргэдийн асуулт дээр гол гарч байгаа зүйл бол энэ мах, махан бүтээгдэхүүнийг мал авдаг хүн байхгүй боллоо. Малын үнэ 40 хувь уналаа. Энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ гэдэг ийм асуудлыг ярьж байна. Н.Бат-Эрдэнэ гэдэг залуу.

Тэгээд өчигдөр Махны холбооны хурал хуралдаад Н.Батсуурь гээд Төрийн нарийн бичгийн даргаар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгээр даргаар ажиллаж байсан хүнийг маш туршлагатай, малын эрүүл мэнд, махны технологи энэ тэрийг маш сайн мэддэг энэ туршлагатай кадрыг Махны холбооны гүйцэтгэх захирлаар томилсон.

Тэгээд ер нь энэ квотын асуудал Х.Болорчулуун гишүүн ээ, маш их асуудал болоод байна. Одоо үхрийн махны квотын асуудал танай яам дээр чинь зарлахгүй хэдэн сар боллоо. Тэгээд маш хурдтай энэ экспортод махаа гаргаад буцаж мөнгөө оруулж ирээд түүгээрээ мал худалдаж авах энэ процессыг маш хурдан хиймээр байна.

Өчигдөр махны компаниуд юу ярьж байна вэ гэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хэдхэн компанид үхрийн махны

квот өгөх байх. Тэр квотыг нь бид мянган орчим төгрөгөөр л нөгөө компаниудаасаа энэ авлигынх нь мөнгийг төлнө дөө гэсэн ийм яриа хийж байна.

Нэг килограмм махан дээр мянган төгрөг гэдэг чинь 150 килограмм үхэр дээр чинь 150 мянган төгрөгийг тэр малчны хотоос гарахад нь малчдаас хулгайлж байна гэсэн үг байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл тэр компаниуд чинь захирлууд нь 10, 20 компанид үхрийн махны зөвшөөрөл, квот өгдөг. Тэгэнгүүт нь бусад компаниуд нь нөгөө компаниудаасаа мянган төгрөг төлж авдаг. Тэр компанийн захирал чинь тэр харманаасаа мөнгөө гаргаж өгөхгүй шүү дээ. Хаанаас мөнгөө авдаг юм бэ гэхээр малчдын хотхоноос килограмм тутамд нь мянган төгрөг татаад л авдаг байхгүй юу.

Тэгэхээр чинь нэг үхэр дээр 150 мянган төгрөгийг л нэг малчны хотхоноос гарахад л энэ квотын авлигал хээл хахуульд явж байна гэсэн үг байхгүй юу даа.

Тийм учраас дөнгөж та Их Хурлын гишүүн, одоо дөнгөж сайд болсон. Анхны квотын асуудал ярих гэж байна. Бусад мал дээр квотгүй болгож өгсөн танд баярлаж байгаа.

Одоо энэ үхрийн махныхаа квотыг боль оо. Энэ жилийн хувьд тугал нийтдээ. Би одоохон хэлээд өгье. Нийт 875 мянган тугал энэ жил төл мал авсан байна. Түүний дөнгөж 10-хан хувийг гаргахад л 10 мянга орчим тонн, 12, 13 мянган тонн үхрийн мах экспортлох боломжтой болох юм.

Тэгээд ийм их мал энэ Монгол Улсад байгаад байна. Энэ жил 24 сая толгой мал. Бид социализмын үед байсан толгой малыгаа энэ жил зөвхөн төлөөр л авч байна шүү дээ.

Тэгээд энэ байгаль орчинд маш их хүндрэлтэй. Дээрээс нь ингээд бэлчээрийн хомсдол бий болчихсон. Малынх нь үнэ байхгүй. Дээрээс нь тэр нөгөө квотоос болоод Эмээлтийн хэл ам, хэрүүл тэмцлээс болоод бүх экспорт зогсчихсон. Махны компаниуд дээр нийтдээ 300 орчим тэрбум төгрөгийн мах, хоёр жилийн мах хадгалагдсан. Ингээд ийм нөхцөл байдалтай байж байна.

Тийм учраас энэ квотынхоо асуудлыг цэгцлээд тэр үхрийн мах дээрээ боль оо. Энэ л 3 сая толгой үхэртэй байж байхдаа махан дээр квот

тавьсан. Одоо 6 сая дөхүүлээд үхэртэй болж байна. Квот тавих ямар шаардлага байгаа юм бэ? Энэ экспортод махаа гаргахгүй бол энэ малчдын чинь амьдрал сүйрч дууслаа шүү дээ.

40 хувиар малынх нь үнэ уначихлаа. Махны үйлдвэрүүд мөнгөгүй болохоор ченжүүд мөнгө байхгүй. Ченжүүд мөнгөгүй болохоор тэр Эрдэнэдалайд очиж мал авдаг хүн байхгүй болчихоод байна.

**Г.Занданшатар:** Байнгын хороон дээр эхлээд. Өнөөдрийн хэлэлцэх асуудалд Байнгын хороодоороо хэлэлцэж байж.

Асуулга тавь, асуулт тавь. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Та бүгдийн өглөөний амгаланг эрье.

Би хэлэлцэх асуудалтай холбогдуулаад хоёр зүйлийг тавих гэж байгаа юм. Нэг нь нэмэх, хойшлуулах.

Би микрофон тасалдаг учраас **LIVE** хийгээд ярьж байгаа юм.

Нэг дэх асуудал нь, Үндсэн хуулийн цэцтэй холбогдолтой асуудал байгаа. Би Үндсэн хуулийн цэцийн хууль зөрчсөн шийдвэр гаргасан гишүүдийг Үндсэн хуулийн заалтын дагуу буцаан татах ийм саналыг Их Хуралд тавьсан.

Нөгөөдөх нь, би Их Улсын Их Хурлын гишүүний хувьд цэцэд хүсэлт гаргасан. Энэ хоёр асуудлыг Их Хурлаар хэлэлцэх ёстой. Байнгын хороодоор ярих ёстой.

Тэгээд болохгүй байгаа бол наад Байнгын хороогоор яриад л хариу өг.

Их Хурлын дарга маань өөрөө үүнийгээ дараад суучихсан. Баянхонгортог загнуулж ирснээсээ хойш. Тэгээд одоо яагаад байгаа юм. Мэдэхгүй. Ингээд нөгөө цэцийн гишүүдийг дэмжээд.

Ер нь цэцийн гишүүн ч бай Үндсэн хууль зөрчдөг байж болохгүй ээ. Үндсэн хууль зөрчсөн асуудлыг Их Хурал шийдэх ёстой. Хуулийн ямар нэг зөрчил байвал хуулийг нь өөрчилж байгаад шийдэх эрх Их Хуралд байгаа. Үндсэн хуульдаа халдсан улсуудыг төрөөс цэвэрлэдэг байх ёстой.



Үүнийг дарж сууж болохгүй. Үүнийг би байнга хэлнэ.

Хоёр дахь асуудал нь, энэ хэлэлцүүлгийн явцаас тэр төсөв дагаж орж ирсэн Хөгжлийн банкны дахин санхүүжилтийн бонд, баталгаа гаргах тогтоолыг хасах хэрэгтэй.

Энэ Хөгжлийн банкиг үе үеийн улс төрчид дампууруулсан. Ардчилсан намын үед МҮДН-хэн /Монголын Үндэсний Дэвшлийн Нам/ Худалдаа, хөгжлийн банктай нийлж байгаад л байхгүй болгосон.

Манай үед 2017 онд одоо энэ Сангийн сайд Б.Жавхлан 11 гишүүнтэй хамт жижиглэн мөлжих хуулийн төслийг Хөгжлийн банкны хуульд оруулсан. Ингээд манай дарга, сайд нар сонгуулийнхаа менежерийг тавьж эхэлсэн. Тавьж эхэлсэн. ТУЗ-ийн дарга, зээлийн захирал, зээлийн хэлтсийн захирал. Одоо жишээлбэл Ч.Мөнхбаяр гээд манай Б.Жавхлангийн их сургуулийн ангийн найз нь зээлийн газрын захирал. Тэр Уянга нь бас хамт сурч байсан. “**Ди Би Эм лизинг**”-ийн захирал Г.Пүрэвсүрэнг бас.

Чингис банкинд эд нар 49 тэрбум төгрөгийг байршуулсан. Тэгээд байхгүй болгосон. Баахан компаниуд зээл авсан. Ийм байхад одоо үүнийг таслан зогсоохгүй байж болохгүй. Сангийн сайд нь ингэж болохгүй.

Сангийн сайд нь үүгээр зогсохгүй байгаа шүү. ЖДҮ, Хөгжлийн банк, Бичил санхүүгийн хөгжлийн сан гээд Монголбанкинд байгаа сангаас хүртэл “**Jet Finance**” гээд банк бус санхүүгийн байгууллагаараа 900 тэрбумаар 3 удаа зээл авсан байгаа байхгүй юу. Жилийн 6 хувийн хүүтэй.

Ийм байж болох юм уу. Одоо энэ түр хорооны дарга Б.Энхбаяр үүнийг сайн сонсож аваарай.

Энэ шалгалтыг энэ улсуудаас эхлэх ёстой шүү. Бид 23 компанийг Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар өгсөн байгаа. Өгсөн байгаа. Дээр нь нэмэгдэнэ.

Тэр ноолуур, алтны компаниуд нэмэгдэнэ. Ингээд үүнийг шалгасны дараа тэр Хөгжлийн банкны зээлийн асуудлыг төр төлөх үү, үгүй юу гэж. Төр төлчихөөр яах юм. Дараа нь Хөгжлийн банкиг байна шүү дээ, экспортын банк болгоод л тэгээд л тэр зээлийн төлөгдөөгүй

үлдэгдлийг дампууруулаад л ингээд л хаях гэж байна шүү дээ. Ийм зохисгүй юм байж болохгүй ээ.

Тийм учраас энэ тогтоолын төслийг татаж авах ийм шаардлагыг Засгийн газарт хүргүүлэх хэрэгтэй. Болохгүй. Татвар төлөгчдийн мөнгөөр төлж болохгүй.

Одоо тэгээд тэр шалгалтын явцад харж байхад тэр улс төрчдийн компаниуд нь зээлээ төлдөггүй. Зээлээ төлдөггүй. Хэдэн арван тэрбумаар нь авчихаад төлөөгүй компаниуд ч байгаа. Одоо бид нар 23-н шалга гэсэн компанийн хувь заяа ямар байгааг мэдэхгүй байна. Авлигатай тэмцэх газар дээр байгаа.

Тэрийг одоо энэ Б.Энхбаяраар ахлуулсан энэ түр хороо л шахаж шаардаж байж шалгуулах хэрэгтэй. Ингэж байж дараагийнх зогсоно. Төрийн банк юу болж байгааг бүү мэд.

Ард түмэндээ өгч байна гээд л баахан хувьцаа зараад л байж байгаа шүү дээ. Тийм үү. Тэрийг ард түмэн авах уу? Энэ үнэ өссөн үед. Стратегийн зээлдэгч гэдэг дотор нь бас л улс төрчид нь цогц яваа шүү дээ.

Тэгээд ингээд Хөгжлийн банк, ЖДҮ, Бичил зээлийн сан, Төрийн банк. Ингээд бүгдийг нь мөлждөг байж болохгүй шүү дээ.

Тийм учраас үүнийг таслан зогсоохын тулд тэр тогтоолыг татаад Хөгжлийн банкиг шалгаж байгаад түр хороо эндээс эхлэх хэрэгтэй. Үүнийг маш сайн нягтлах хэрэгтэй. Хэрвээ Авлигатай тэмцэх газар улс төрийн хүчин мөхөстөөд байгаа бол үүнийг нь Их Хурал шийдэж өгөх.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Энэ төсөвтэй холбогдож орсон асуудлыг Төсвийн байнгын хороон дээр хэлэлцээд хэлэлцэх, хэлэлцэхгүйгээр нь хэлэлцээд буцааж болох. Төсвийн Байнгын хорооны бүрэн эрхийн асуудал. Бүрэн эрхийнхээ хүрээнд энэ асуудлаа хэлэлцэн шийдвэрлэх хэрэгтэй.

Өнөөдөр хэлэлцэх асуудлын дараалалд байхгүй.

Ер нь Улсын Их Хурлаас Хөгжлийн банкны Хяналт шалгалтын түр хороог байгуулсан. Төсвийг нь шийдэж өгөх хэрэгтэй байгаа. Энэ холбогдох чиглэлээр Ж.Сүхбаатар

гишүүн ч гэсэн их сайн ажилласан. Одоо Б.Энхбаяр гишүүн ч гэсэн холбогдох асуудлуудыг тавьж байгаа. Тэгээд энэ хүрээндээ энэ асуудал хэлэлцэгдэнэ. Хэлэлцэгдээд явж байгаа асуудал. Үүнийг чинь Их Хурал анхнаас нь бүр анхаараад Хянан шалгалтын түр хороо хоёр ч удаа байгуулаад, ажлын хэсэг байгуулаад манай Б.Батгөмөр гишүүн, Б.Бат-Эрдэнэ гишүүд нар идэвхтэй оролцсон.

Хоёрдугаарт нь, Ц.Даваасүрэн гишүүн ээ. Үндсэн хуулийн цэцийн холбоотой асуудлыг та бид хоёр ярилцах юм бол хоёулаа шууд Үндсэн хууль зөрчсөн болж байгаа юм.

Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон бол түүнийг гишүүнээс нь эргүүлэн татах тухай. Цэцийн гишүүн гэмт хэргийг үйлдсэн болохыг шүүх тогтоосон бол цэцийн шийдвэр анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эргүүлэн татаж болно гэсэн.

Таны гаргаад байгаа асуудал бол Үндсэн хуулийн цэцэд санал гаргахтай холбоотой асуудлаар. Үүнийг тухайн үед нь танд би хариу өгч байсан.

Улсын Их Хурлын Тамгын газар лавлагаа гаргасан. Ингэх юм бол хууль зөрчинө. Үндсэн хууль зөрчинө. Харин хуулиа санаачлаад явах бүрэн эрхтэй. Энэ хүрээндээ хуулиа санаачлаад Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг өөрчилж, шинэчилж журмын тухай хуулийг өөрчилж шинэчил гэж хэлээд байгаа шүү дээ.

Энэ хүрээндээ гишүүдийн бүрэн эрхийн асуудал. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая.

Энэ Улсын Их Хуралд сууж байгаа бүх гишүүдийн сонгогдсон иргэдтэй холбоотой асуудлыг энд хөндөж байгаа юм. Энэ асуудал нь юу юм гэхээр сая Улсын Их Хурал 2023 оны төсвөөр олон нийтийн хэлэлцүүлэг хийж, **D-Parliament** дээр иргэдийн саналыг авсанд иргэд үнэхээр талархаж хандаж байна.

Одоо 68 мянган иргэд зочилж, 15 мянган орчим иргэд **D-Parliament** дээр саналаа ирүүлсэн гэж мэдээлэл өгсөн. Үүнээс гадна **D-Parliament**-д орж чадахгүй байгаа 500 гаруй иргэд надад

ингээд бүр гарын үсэгтэй, хаана амьдардаг хаягтайгаа, утастайгаа ийм саналаа ирүүлсэн юм.

Тэгээд энэ саналын гол нь юу вэ гэхээр энэ төсөв 2023 онд олон нийтийн санал авч байгаа бол бидний саналыг тусгах нэг чухал зүйл байна гэж байгаа юм.

Энэ нь Засгийн газрын нөгөө 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журмын дагуу нөгөө нийслэл, аймаг, сум гээд 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын иргэдийн шөнийн тарифын хөнгөлөлт энэ 2023 оны төсөв дээр Эрчим хүчний сайдын багцад тусгагдаагүй орж ирсэн асуудал иргэдийн нэлээд шүүмжлэл дагуулж байна л даа.

Тийм учраас иргэдээс ийм хүсэлт ирээд байна. Яг энэ 2022 оны.

Гишүүд ээ, энэ их чухал асуудал хөндөж байгаа учраас та нар маань жаахан чимээгүй байвал баярлах байна.

Би тэгээд Төсвийн байнгын хороон дарга, төсвийн ажлын хэсгийнхэн маань энд бүр анхаарал хандуулах чухал байгаа.

Энэ 2022 оны судалгааг аваад үзэхэд нийслэл Улаанбаатар хотод 125 мянган айл өрх, аймаг орон нутгийн буюу 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газрыг аваад үзэхэд 48 мянга айл өрх энэ 2022 онд тэр шөнийн эрчим хүчний тарифт оройны 21 цагаас өглөөний 06 цагт хамрагдаж байсан. Энэ маш олон мянган айл өрхийг нэгдүгээрт эрчим хүчний хэмнэлтэй байх, яндангаа буулгаад утаа нь гарахгүй байх, нөгөө талаасаа өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүс шөнө энэ шөнийн хөнгөлөлтөөр бас нэлээд давуу талтай. Орлогоо ч хамгаалчихдаг, ажлын байраа ч хадгалчихдаг ийм зүйл байгаа.

Тэгтэл одоо энэ 2023 оны төсөв дээр энд тусгагдаагүй орж ирсэн байна л даа. Энэ 2017 оноос хойш ингээд аваад үзэхэд шөнийн хөнгөлөлт олон мянган иргэдэд, энэ 180-аад мянган айл өрх гээд үзэхэд манай хүн амын бараг 70, 80 хувь нь байгаа байхгүй юу. Гэр хороололд жишээ нь Улаанбаатар хот гээд үзэхэд 60, 70 хувь нь амьдарч байна. Аймаг орон нутаг, сумдын 10 мянгаас дээш хүн амтай суурин гээд аваад үзэхэд өнөөдөр бараг 90-ээд мянган айл өрх болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ бүх хүмүүсийн төрийн хэмнэлтийн хууль нэрээр энэ шөнийн эрчим хүчний тарифын хөнгөлөлтийг цуцалж болохгүй юм.

Өчигдөр олон нийтийн хэлэлцүүлэг дээр маш олон салбарын судлаач, шинжээчид ярьж байлаа шүү дээ. Төрийн хэмнэлтийн хууль оновчтой байх ёстой. Төрийн хэмнэлт харин ард иргэдэд энэ үнэ ханш энэ өндөр байгаа үед дарамт учруулж болохгүй. Хүнд суртал учруулж болохгүй. Төрийн энэ хэмнэлтийн одоо жишээлбэл эхний 100 тэрбум төгрөгийг юунд зарцуулах вэ. Тэр нь оновчтой байх. Тэр нь иргэдийн амьжиргааг дэмжсэн байх ёстой гэдгийг өчигдөр олон нийтийн хэлэлцүүлэг дээр олон хүмүүс хэлж байсан.

Гэтэл өнөөдөр ингээд шөнийн тариф хөнгөлөлтгүй гээд Эрчим хүчний сайдын багцаас 2023 оны төсөв дээр хасагдаад ороод ирчихсэн байна л даа.

Хэрвээ энэ хасагдсан чигээрээ явчихвал Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоол хүчингүй болно гэсэн үг. Хүчингүй болно гэдэг чинь энэ нөгөө агаар, хөрсний бохирдлыг бууруулахаар бидний авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр дүнгүй болох ийм нөхцөл байдал үүсэж байна л даа.

Одоо та нар маань харах байх. Өнгөрсөн хоёр дахь өдөр, гурав дахь өдөр гадаа нэмэх 12, 13 хэм дулаан байхад орой 16, 18 цагаас хойш утаа хэдийнээ гараад ирчихсэн. Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын тэндээс. Ганц гэр хороолол биш шүү дээ. Энэ утаа чинь бүр Зайсанд ч үнэртээд эхэлчихсэн байна шүү дээ. Гэтэл одоо хүйтний эрч чангарах болж байхад энэ эрчим хүчний шөнийн тарифын хөнгөлөлтийг нь бүр байхгүй болгочихвол одоо юу болох вэ.

Өчигдөр би Чингэлтэй дүүргийн гэр хорооллын 500-гаад айл өрхтэй уулзаж иргэдийн уулзалт хийлээ л дээ.

Тэгэхээр ярьж байна л даа. Одоо Эрчим хүчний сайд маань энд сууж байна. Одоо хэрэглэж байгаа түлшний чанар, үнэр 2018 онд хэрэглэж байгаа түлшний тэр чанар үнэрээс тэс өөр болчихоод байна. Энэ утаа бүр илүү болоод байна. Тэгээд Та бүхэн маань энд анхаарал хандуулаач ээ гээд ярьж байна.

Нөгөө талаасаа иргэд өөрсдөө санаачилга гаргаад 10-аас 30, 40 сая төгрөг гаргаад тэр шалаа дулаалаад, халаагуур аваад, хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлээд ингэчихсэн байхад үүнийг нь бид харин ч энд дэмжээд явах ёстой байхад аль болохоор иргэдийнхээ нуруун дээр ингээд дарамт учруулаад байх энэ хэмнэлт өөрөө байж болохгүй гэж иргэд өөрсдөө хэлж байна. Бид ч үүнийг энд сууж байгаа бүх гишүүд маань дэмжиж байгаа байх гэж би бодож байна.

Тийм учраас олон хүмүүс хэлж байна. Одоо энэ олон нийтийн санал, хэлэлцүүлгээр гарч байгаа саналуудыг бид төсөв хэлэлцэж байгаа үед тусгах учиртай. Мэдээж хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудлын Төсвийн байнгын хороонд төсвийн ажлын хэсэг маань анхааралдаа аваад явчих байх.

Тийм учраас Их Хурлын дарга болон Төсвийн Байнгын хорооны дарга, төсвийн ажлын хэсгийнхэн маань энэ олон мянган иргэдийн санал, хүсэлтийг тусгаад, тэр шинийн эрчим хүчний тариф дээр бүгдээрээ анхаарахгүй бол олон мянган иргэдэд хүндрэл болох нь байна шүү гэдгийг би хэлэхээр ингэж үг авсан юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай шууд холбоотой биш асуудлууд байна.

Эрхэм гишүүд ээ, 77 жилийн өмнө 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолын төлөөх бүх ард түмний санал хураалтыг явуулсан түүхтэй.

Энэ бол тухайн үеийн нийт ард түмний тал хувь нь бичиг үсэггүй байсан учраас санал хураалтад тусгаар тогтнолынхоо төлөөх санал хураалтыг гарын үсгээр болон баруун гарын эрхий хуруугаар дарж баталгаажуулсан түүхтэй.

Энэ бол тусгаар тогтнолын төлөөх санал хураалтын түүхэн өдөр өнөөдөр тохиож байна. Тэгээд энэ түүхэн өдрийн мэндчилгээг Та бүхэнд үргэн дэвшүүлье. /алга ташив/

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүнд мэндчилгээ дэвшүүлье.

10 дугаар сарын 18-нд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил Наваансодовын Цэнд, Баатарын Эвшинхүү нарын том хүү болж эхээс мэндэлжээ.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилдоо төрсөн өдрийн мэнд

хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо хэлэлцэх асуудалд орно.

*Нэг.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай  
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд  
/Засгийн газар 2021.11.11-ний өдөр өргөн мэдүүлсэн,  
хэлэлцэх эсэх/*

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэлэлцэнэ. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Х.Нямбаатар:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичгийн “Авлигагүй засаглал” зорилт, мөн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 92 дугаарт Монгол Улсын Засгийн газар Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тус тус гаргасан билээ.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орсноор гишүүн орны мэдээлэгч, илчлэгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүргийг хүлээж байгаа юм.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсыг

Авлигын төсөөллийн индексээр 111 дүгээр байрт жагсаж байгаад дараагийн хоёр жилийн хугацаанд хоёр оронтой тоонд оруулах зорилтыг дэвшүүлсэн билээ.

Монгол Улсын хувьд 2002 он болон 2016 онуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталж мөрдүүлсэн хэдий ч шүгэл үлээгч мэдээлэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Тодруулбал, “Трансперенси Интернешнл” байгууллагаас Ази, Номхон далайн бүс нутгийн 20 гаруй мянган хүмүүсийн дунд авлигын талаар судалгаа зохион байгуулж, авлигын эсрэг иргэд тэмцэх хамгийн үр дүнтэй алхам юу вэ гэсэн асуултад тэдний ихэнх нь буюу мэдээлэх буюу хахууль өгөхгүй байх гэж хариулсан байна.

Улмаар уг судалгаагаар яагаад мэдээлэх буюу шүгэл үлээх алхмыг хийгээгүй шалтгааныг тодруулахад үр дагавраас нь айдаг гэж хариулсан байна.

Дэлхийн 30 гаруй орон шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог нэвтрүүлээд байна. Тэдгээрийн зарим нь шүгэл үлээгчийг хамгаалах заалтуудыг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хуульд тусгаж өгсөн байдаг бол

зарим орны шүгэл үлээх харилцааг бие даасан хуулиар зохицуулж байна.

Шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан хуулийн зохицуулалтын хамрах хүрээ нь зарим оронд төрийн албан хаагчдаас гадна хувийн секторын ажилтнуудыг багтаасан байдаг. Тухайлбал, Англи, Франц, Норвег гэх улсуудад төрийн албаны болон хувийн секторын шүгэл үлээгчийг нэг хуулиар хамгаалсан байдаг бол зарим оронд Америкийн Нэгдсэн Улс, Австрали гэх мэт улс орнуудад тусдаа хуулиар хамгаалдаг байна.

Ийнхүү хамгаалах механизмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс бусад улсад буцаан авч чадсан хөрөнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг урамшуулал болгож шүгэл үлээгчид олгож байна. Тухайлбал, шүгэл үлээгчдэд Америкийн Нэгдсэн Улс дээр дурдсан мөнгөн хөрөнгийн 10-аас 30, Бүгд Найрамдах Солонгос Улсад 2 тэрбум тэрбум вон хүртэл буюу 4-өөс 20 хувь, Канад Улсад 5-аас 15 хувийн урамшууллыг олгож байна.

Шүгэл үлээгчийг хамгаалах чиглэлээр Америкийн Нэгдсэн Улс тэргүүлэх чиглэлтэй байна. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс нь 1776 оны тусгаар тогтнолын тунхаглалаа зарласнаас хойш 2 жилийн дараа буюу 1778 оны 07 дугаар сарын 30-ны өдөр Тэнгисийн цэргийн хүчин дэх хууль бус авлигын үйлдлийн эсрэг нийтийн ашиг сонирхлыг хамгаалж шүгэл үлээсэн шүгэл үлээгчдийг хамгаалах зорилгоор Америкийг үндэслэгчид санал нэгтгэйгээр хууль гаргаж байна гэсэн дэлхийн анхны Шүгэл үлээгчийн хууль гэж тооцогддог.

2010 онд Европын парламентын хурлаас баталсан шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах 1729 дүгээр тогтоолоор гишүүн орнуудыг өөрсдийн хууль тогтоомжийг шүгэл үлээгчийг хамгаалах талаас нь

дахин авч үзэж холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулахыг уриалсан.

Эдгээр орнуудаас Их Британи анх 1998 онд шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог нэвтрүүлсэн ба 2013 онд хамгаалах бодлогыг илүү тодорхой болгосноор өдгөө бусад улс орнуудаа шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоогоороо үлгэр жишээ болж байна.

Иймд дээрх бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг олон улсын жишигт нийцүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газраас Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн анхдагч хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд танилцуулж байна.

Хуулийн төслийн гол зохицуулалт буюу хуулийн үйлчлэх хүрээг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хэрэглэгчийн эрх ашиг, шударга өрсөлдөөний талаар байхаар тусгалаа.

Хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгасан байна. Үүнд,

Нэгдүгээрт, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүгэл үлээгчид хуулиар эрх олгох, дэмжих, хамгаалах, урамшуулах мөнгөн дүнгийн хэмжээг тогтоолоо.

Хоёр. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дордуулсан шинжтэй аливаа үйлдэл буюу шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээд бусдын өс хонзон, ялгаварлан гадуурхалт, хохирол учруулах, хохирол учруулж болзошгүй аливаа хэлбэрийн цээрлүүлэлт болон хувийн мэдээлэл, аюулгүй байдалд саад учрах

эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах харилцааг зохицуулахаар тусгалаа.

Гуравдугаарт, төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа авлига, ашиг сонирхлын талаар олж авсан мэдээллээр шүгэл үлээхэд төрийн болон албаны нууц, байгууллагын нөөц, хувь хүний нууцын мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийн хязгаарлалт хамаарахгүй буюу төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулсан гэж хуулийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар зохицуулж, зохицуулалтыг тусгалаа.

Дөрөв. Шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээж авах, холбогдох эрх бүхий байгууллага, тэдгээрийн эрх, үүрэг, мэдээлэл хүлээн авах, тусгай дотоод нэгж, мэдээллийг бүртгэх эрх бүхий байгууллагуудыг хоорондын дундын мэдээллийн сантай байхаар хуульчиллаа.

Тавдугаарт, Авлигатай тэмцэх газар шүгэл үлээсэн талаарх мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, олон нийтэд болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлдэг байхаар тусгалаа.

Зургаадугаарт, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандах, мэдээллийг хүлээн авсан хэвлэл мэдээллийн байгууллага шүгэл үлээсэн асуудлыг мэдээлсэн эх сурвалжаа нууцлах эрхтэй байх зэрэг асуудлуудыг тус тус зохицуулсан болно.

Олон улсын жишигт нийцүүлэн хуулийн үйлчлэх хуулийн төслийн онцлох зохицуулалт буюу шүгэл үлээгчийг нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхийг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх хүрээнд түүнд нөхөн төлбөр, мөнгөн урамшуулал олгохоор зохицуулсан бөгөөд мөнгөн урамшуулал олгох хэмжээ нь 100 мянган төгрөгөөс 1.5 тэрбум төгрөг хүртэл байхаар тогтоож, уг асуудлыг

шүгэл үлээгчид мөнгөн урамшуулал олгох асуудал хариуцсан үүрэг бүхий эрх бүхий байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн мөнгөн урамшууллын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэхээр тодорхой тусгалаа.

Түүнчлэн шүгэл үлээсний үр дүнд нийтийн ашиг сонирхлыг хохироосон гэмт хэргийг илрүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд харгалзан үзэх, ял хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцохоор нэмж тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэдэд эрх бүхий төрийн байгууллагаас түргэн шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг хянах, хүний эрх, эрх чөлөө, тэгш нөхцөл байдлыг хангах, урамшуулах, хамгаалах нэгдсэн тогтолцоотой болно.

Ингэснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, иргэдийн эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшилнэ гэж үзэж байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулсан болно.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Эхлээд зочид танилцуулъя. Дараа нь Ц.Мөнхцэцэг гишүүн хэлж байгаарай.

Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат нарын урилгаар “Хан Хэнтий” цогцолбор сургуулийн багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт багш нар Та бүхнийхээ сурган хүмүүжүүлэх, соён гэгээрүүлэх ажил үйлсэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо хуулийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

**Ц.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх, өргөдөл, гомдол гаргах, тайлбар өгөхийг шүгэл үлээх гэж томьёолон, нийтийн ашиг онолын төлөө шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах, шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дордуулсан шинжтэй аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг **D-Parliament.mn** цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлсэн хүнийг урамшуулах, мэдээллийг төлбөртэй авах хуулийн зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар болон Авлигатай тэмцэх газарт ирж байгаа мэдээллийн хэдэн хувийг гэмт хэргийн шинжтэй мэдээлэл эзэлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр төрийн нууцыг хамгаалах ажилтан, эрх бүхий этгээдийн танилцсан төрийн нууцад хамаарах мэдээлэл нь энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй байхаар тусгасан нь авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх гэсэн хуулийн үндсэн үзэл баримтлалтай зөрчилдөж байгаа эсэх, татвар төлөгчийн асуудлаар нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх асуудлыг хуулийн төслөөс хасах тухай Сангийн яамны саналын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан шүгэл үлээгчийг хуулийн хариуцлагад татахгүй байхаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд шүгэл үлээгч бусдыг гүтгэсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир шүгэл үлээгчийн эрхийг хамгаалж байгаа хэдий ч нөгөө талын эрх ашгийг хамгаалах асуудлыг хэрхэн зохицуулах, шүгэл үлээгч худал мэдээлэл гаргасан тохиолдолд түүнээс үүсэх сөрөг үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх талаар болон шүгэл үлээгчийн гаргасан мэдээллийн цаг хугацааг хэзээнээс тооцох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа хуулийн төсөлд шүгэл үлээгчид хамгаалалтын арга хэмжээ авахаар тусгасантай холбогдуулан хамгаалалтад авах хүний тоо, зардлын тооцоо, судалгаа байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж, хэлэлцүүлгийн шатанд төрийн албаны нууцтай холбоотой асуудлаар шүгэл үлээх боломжийг нээсэн зохицуулалтыг төсөлд нэмж тусгах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар “**Алсын хараа-2050**” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенц гэх мэт эрх зүйн баримт бичгүүдэд шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүргийг хүлээдэг учир хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй, мөн хэлэлцүүлгийн явцад шаардлагатай зохицуулалтуудыг төсөлд нэмж тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, хуулийн төслийг бусад хуультай уялдуулах, зөрчил хийдэлгүй батлахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж байгаа хэдий ч энэ харилцааг хуулиар зохицуулах цаг хугацааны хувьд эргэлзэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар шүгэл үлээгчийг хамгаалах хууль зүйн болон практик шаардлага байгааг онцолж, хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжин анхдагч хуулийн төсөл учраас хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад нэр томьёо, зохицуулалтын талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргаж байгаа саналуудыг тусгах боломжтой талаар тус тус санал хэлсэн болно.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын

хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 53.8 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Дамбийнямын Төрболд, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Доржсүрэнгийн Дуламсүрэн, Монгол Улсын ерөнхий зөвлөх Чулуунбаатарын Болортуяа, “Трансперенси интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүн Лхагважавын Төр-Од.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд бүртгүүлнэ үү.

Шатарбалын Раднаасэд гишүүнээр тасаллаа. Одоо асуулт асууя. Дамбын Батлут гишүүн асуулт асууна.



**Д.Батлут:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ бас асууж тодруулах зүйл байна. Аливаа асуудал хоёр талтай байдаг.

Тэгэхээр авлигын индексээр дэлхийд 111-т жагсаж байгаа улсын хувьд энэ төрлийн харилцааг зохицуулах хэрэгцээ шаардлага үүсгэсэн байгаа нь үнэн. Гэхдээ иргэд шүгэл үлээснээрээ мөнгө олж авах боломжтой гэж, энэ хуулийн төсөл дээр урамшуулал авна гэдэг ийм сэтгэл зүйгээр хандах нөхцөл байдал үүсэх вий дээ.

Энэ нь өөрөө хилсээр хүнийг гүтгэх, дургүй хүмүүсээ эргэж матах, мөрдүүлэх, шалгуулах, хүмүүсийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх ийм нөхцөл байдлыг үүсгэх талтай байна. Магадгүй энэ байдлаар явах юм бол нөгөө аймшиг гэж яригддаг 1930-аад оны нөхцөл байдал бас давтагдах ийм дүр зураг гарна гэж харж байна.

Тэгэхээр үүнийг хязгаарлах шалгууруудыг хэрхэн тогтоож өгсөн юм бэ? Энэ хуулийнхаа төсөлд. Энэ дээр нэг хариулт авъя.

Хуулийн төслийн 3.2.2-т Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууц мэдээлэл мэдсэн хүн шүгэл үлээж болохгүй. Энэ хууль үйлчлэхгүй байхаар тусгасан байна.

Тэгэхээр том хулгай, төрийн нууц гэсэн тамгатай цаасны ард явагддагийг хүмүүс ярьдаг юм шүү дээ. Тэгэхээр нийтийн эрх ашгийг хөндсөн мэдээллийн талаар шүгэл үлээсэн бол байгууллагын дотоод журам, нууц хадгалах үүрэг зэргээ зөрчсөн гэж үзэхгүй байх талаар эерэг зохицуулалтыг олон улсад хэрэглэдэг ийм

туршлага байгаа. Энэ зохицуулалтыг хасах, эсхүл өөрчлөх талаар төслийг боловсруулах явцад байгууллагуудаас ирүүлсэн санал байгаа юу гэдгийг ажлын хэсгээс асууя.

Энэ Шүгэл үлээгчийн хуульд мэдээллийг 6 байгууллагад л ирүүлэхээр хуульчилж зааж өгсөн байна. Тухайлах юм бол прокурор, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, гааль, Цагдаагийн ерөнхий газар зэрэг.

Тэгэхээр шүгэл үлээгчийн шүгэл үлээх сувгийг хуульд нэрлээд заачихаар энэ эрх бүхий газруудад хандахгүй бол шүгэл үлээсэн гэж үзэхгүйгээр болж байгаа юм байна л даа. Тэгээд энэ 6 байгууллагад ханддаг учир нь юу юм бол? Нээлттэй болгож болдоггүй юм уу? Аль болох нь шүгэл үлээх суваг нь нээлттэй байх тусмаа, олон төрлийн төрөл байх тусмаа зохицуулалтуудыг төрөл бүрээр хийх боломжууд гарна гэж харж байгаа.

Тэгэхээр ажлын хэсгээс энэ гурван асуулт дээр хариулт авъя. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль зүй дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг бид хуульчилж байгаа хоёр үндсэн зорилго байгаа.

Нэгдүгээрт, энэ төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн субъектүүдийн хууль бус үйлдэл, үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах ийм хамгийн том зорилго агуулж байгаа юм.

Хоёрдугаарт, бид шүгэл үлээгч шүгэл үлээж байгаа хүмүүсийнхээ эрх зүйн байдлыг хамгаалж, элдэв шахалт, хавчлага, дарамт шахалт, хардлага мөрдлөгөд оруулахгүй байх үүднээс эрх зүйн байдлыг нь тодорхой болгож хамгаалж өгч байгаа ийм хоёр үндсэн зорилготой.

Зүгээр бид өмнө нь Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцэж байхад ч тэр, бүлэг дээр ярьж байхад ч тэр нэг ийм асуудал байгаа юм. Энэ юуг хэлээд байна вэ гэвэл, ялангуяа манай 90-ээд оноос өмнөх хуучин нийгмийн үеийн матаасны тогтолцоог эргүүлж сэргээж байна гэдэг ийм болгоомж байгаад байна. Ялангуяа 90-ээд оноос өмнө амьдарч байсан ах, эгч нарт маань ийм комплексууд байгаад байна. Өөрөөр хэлбэл хуучин нийгмийн үед хүнийг үндэс угсаа, язгуур гарал, шашин шүтлэгээ нууж хаасан зүйлийг илчилж матдаг ийм тогтолцоонууд байсан. Үндэс угсаа, шашин шүтлэг, гарал үүслээр нь хэлмэгдүүлдэг тогтолцоо байсан.

Одоо бид 1992 оны шинэ Үндсэн хуулиараа 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, хүний эрхийн суурь тэр зарчмуудад нийцсэн эрх зүйн тогтолцоогоор явж байгаа. Марксист, Ленинист тэр эрх зүйн тогтолцооноос бид татгалзаад 32 жил болж байгаа.

Тэгэхээр хуучин тэр матаасны тогтолцоотой үүнийг адилтгаж болохгүй ээ. Энэ бол цэвэр олон нийтийн хяналт руу чиглүүлж байгаа. Жишээлэхэд, Эрдэнэт хотын Орхон аймгийн нэг баг дээр уул уурхай ухаж байгаа компани, цианит-натри ашиглаж байгаа талаарх мэдээллийг ойр хавийн иргэд нь мэдвэл түүнийгээ мэдээлэх л эрхтэй. Энэ эрх одоо ч байгаа. Байгаль экологийн гамшиг сүйрэл учруулахаас өмнө таслан зогсоох ёстой.

Нийтийн албан тушаалтан үндэслэлгүйгээр хөрөнгөжиж байгаа бол

түүнийг мэдээлэх эрх одоо ч гэсэн байгаа. Үүнийг бид өнөөдөр шүгэл үлээгчийн хуулиар оруулж ирж байгаагийн гол агуулга нь нэгдүгээрт шүгэл үлээгчийг хамгаалж өгье.

Хоёрдугаарт, урамшуулалтай болгоё. Бүх хүмүүсийг олон нийтийн хяналт руугаа чиглүүлж өгье гэсэн зүйлийг ярьж байгаа.

Сая Д.Батлут гишүүний тэр асууж байгаа зүйл таны яг асуусан асуултын дагуу энэ хуулийн төсөлд туссан. Өөрөөр хэлбэл төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа авлига, ашиг сонирхлын талаар олж авсан мэдээллээ шүгэл үлээхэд Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн хязгаарлалт хамаарахгүйгээр шүгэл үлээх эрх нь нээлттэй байгаа шүү гэдэг энэ хязгаарлалтыг нь авч өгсөн.

Тэгэхээр би эрхэм гишүүдийг нэг зүйлийг ойлгоосой гэж бодож байгаа. Бид энэ авлигатай тэмцэх тэмцэлд шүгэл үлээгчид буюу олон нийтийн хяналтыг чиглүүлэх нь юу юунаас чухал байна. Өнөөдөр Авлигатай тэмцэх газрын цөөн хэдэн албан хаагчид, хууль сахиулах байгууллагын цөөн хэдэн албан хаагчдын бүрэн хяналт дотор энэ авлига, албан тушаалын гэмт хэрэг, нийтийн эрх зүйн субъектүүдийн дур зоргоороо авирлаж байгаа үйлдэл, үйл ажиллагаа, томоохон корпорациудын хууль бус үйлдэл, үйл ажиллагаа ерөөсөө бүхэлдээ хянагдаж чадахгүй ээ.

Тийм учраас шүгэл үлээгчдийг эрх зүйн байдлыг нь хамгаалж өгч байж нийтээрээ энэ авлига албан тушаалтай тэмцдэг, эрх зүйн эсрэг бүхий л үйлдлийг шүгэл үлээдэг энэ эрх зүйн боломжийг нээж өгмөөр байна гэдгийг хэлье.

Тэгээд миний асуултад П.Сайнзориг дарга нэмээд хариулья.

**Г.Занданшатар:** Нэмж хариулах юм уу? 80. Пүрэвжавын Сайнзориг. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

**П.Сайнзориг:** Д.Батлут гишүүний асуултад хариулья.

Мөнгөн урамшууллын асуудал байгаа. Тэгэхдээ энэ бол нөгөө хуучин цагийн. Сайд сая хэллээ. Яг тэр матаас гэдэг ойлголт биш. Тэр бол хувь хүн рүү хэтэрхий чиглэсэн, улс төрийн зорилгоор, ахуйн хүрээний өс хонзон ч байдаг юм уу ийм чиглэлээрээ гол төлөв байсан бол энэ удаагийн мэдээлэгч буюу энэ шүгэл үлээж байгаа хүмүүс бол зөвхөн нийтийн эрх ашгийн төлөө үлээнэ.

Бид хэд энэ удаадаа нийт эрх ашгийн асуудлыг зөвхөн авлига, ашиг сонирхол, нийтийн эрүүл мэнд, шударга өрсөлдөөн, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчил гэсэн ийм тодорхой хүрээнд эд нарыг авч үзэж байгаа.

Тэгэхээр энэ дээрээ бид төвлөрч мэдээлэл хүлээж авах байгууллагуудыг тодорхой болгосон. Энэ байгууллагуудыг хэт өргөжүүлж болохгүй. Эргээд энэ мэдээлэл хаана ирж байгаа. Эдгээр байгууллагууд нь өөрсдөө гэмт хэрэг зөрчлийг шалгах эрх бүхий байгууллагууд байгаа.

Энэ мэдээллийг хүлээж авснаараа хойшлуулшгүй ажиллагаануудыг эхлүүлж, энэ мэдээлэл гаргаж байгаа этгээдийн аюулгүй байдал гэдэг юм уу, хамгаалах асуудлуудыг нь авах учраас бас тодорхой байгууллагуудыг нь зааж өгч байгаа асуудал байгаа.

Мэдээж дээр дурдсан сэдвийн хүрээнд нэмэлт гаргаж байгаа байгууллага

нь Хүний эрхийн Үндэсний Комисс байгаа. Прокурорын байгууллагад гаргаж болохоор байж байгаа. Ийм байдлыг танд хэлье.

Хоёрдугаарт, мэдээж мөнгөн урамшууллын асуудлыг заавал өгөх гэж байгаа асуудал биш. Энэ тухайн гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын талаарх мэдээлэл шүгэл үлээлээ гэхэд энэ нь өөрөө эргээд шүүхээр эцэслэгдэн шийдвэрлэгдэх ёстой. Аливаа нэг этгээд гэм буруу нь тооцогдож, тодорхой хэрэг маргаан шүүхээр эцэслэгдсэний дараа мэдээлэл гаргасан этгээд маань хүсэлт гаргавал тодорхой тэр гэмт хэрэг, зөрчлийн улмаас орж ирсэн орлогоос нь санхүүжих байдлаар тодорхой урамшууллыг олгоё гэдэг ийм зүйл орсон.

Сайд бас төрийн нууцтай холбоотой зүйлийг нэмээд хэлчихсэн. Ер нь авлига, ашиг сонирхлын чиглэлээр мэдээлэл үлээсэн нь төрийн болон албаны нууцын хязгаарлалт хамаарахгүй буюу нууц задруулсан тооцохгүй байдлаар орж ирж байгаа.

Тэгэхээр таны ярьж байгаа тэр нууцын гэсэн энэ халхавчийн доор маш олон авлига, ашиг сонирхлын хэргүүд дарагдаж байгаа гэдэг энэ олон нийтийн шүүмжлэлийг бид нээж өгч байгаа гэдэг зүйлийг танд хэлье.

Тэгээд хуулийн 2 дугаар зүйл дээр яг хувийнхаа ашиг сонирхол гэдэг юм уу, эргээд энэ өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу тал, өс хонзон авах байдлаар шүгэл үлээх асуудлыг хориглож өгсөн байгаа. Ийм чиглэлээрээ шүгэл үлээх юм бол бас тодорхой хуулийн хариуцлагатай байхаар оруулж өгсөн гэдэг зүйлийг танд хэлье.

**Г.Занданшатар:** Дамбын Батлут гишүүн тодруулж асууя.

**Д.Батлут:** Ойлгож байна. Тэр өнгөрсөн зууны асуудлыг ойлгож байгаа, мэдэж байна.

Гэхдээ нийгмийг соён гэгээрүүлэх тал дээр онцгой анхаарахгүй бол бас асуудал үүснэ. Нөхөд өө.

Энэ хуулийг сурталчлахаас авхуулаад олон чухал ажлуудыг бид нийгэмд хийх ёстой. Тэгэхгүйгээр явах юм бол ямар нэгэн шалтгаанаар хэн нэгнийг хэлмэгдүүлдэг асуудал тасрахгүй шүү.

Тийм учраас энэ дээр заавал энэ худал мэдээлэл гаргасан хүнд хариуцлага тооцдог зохицуулалтуудыг энд оруулж өгөх ёстой. Ингэж байж аливаа асуудал цэгцтэй, үнэн бодит байдалд нийцсэн байдлаар явагдана гэж харж байгаа. Юун дээр ч гэсэн шүгэл үлээгчийн тухай энэ хуулийн гол концепц нь чиглэсэн байх ёстой шүү гэдгийг хуулийн төсөл боловсруулж байгаа хүмүүст хэлье. Баярлалаа. Та бүхэнд.

**Г.Занданшатар:** Хишгээг Нямбаатар сайд хариулна. Хууль зүй, дотоод хэргийн сайд.

**Х.Нямбаатар:** Тийм. Д.Батлут гишүүн сая зөв хэллээ. Бид өнөөдөр хэн нэг хүний нэр төр, алдар хүндэд халдах. Тийм ээ. Бас эргээд эрх зүйн эсрэг үйлдэл гаргах вий гэдгээс давхар хамгаалалтуудаа хийж явах ёстой.

Эрүүгийн хуульд худал мэдээлэл тараах, бусдыг онц хүнд гэмт хэрэгт гүтгэх энэ төрлийн эрх зүйн хамгаалалтууд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Тэгээд би сая таныг хэлсэн үгэн дээр их баярлаж байна. Яагаад гэвэл Д.Батлут гишүүн энэ шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дэмжиж хамгийн анхны гишүүн үг хэллээ.

Тэгээд бид нар бас энэ шүгэл үлээгчийн эрх зүйн байдлаа их тодорхой болгож байж ирээдүйгээ, нийгмээ илүү гэрэл гэгээтэй, олон нийтийн хяналттай, нийтийн албан тушаалтнууд нь бүгд ёс зүйтэй, хариуцлагатай болдог энэ рүү чиглэхэд энэ маш том алхам болно. Тэгээд Д.Батлут гишүүнд баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин асуулт асууна.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм.

Гэхдээ энэ дээр хоёр, гурван ярих шаардлагатай асуудлууд байна л даа. Яах вэ, Америкт **Whistleblower Protection Act**[Мэдээлэгчийг хамгаалах тухай хууль] гэж байдаг. Энэ нь шүгэл үлээгчийн нууцыг хамгаалдаг тийм хуультай байдаг.

Харин мөнгөн урамшуулалд нь өөр зохицуулалттай. Мөнгөн урамшуулалд нь зөвхөн үнэт цаас, санхүүгийн гэмт хэрэг дээр ер нь төлөгддөг тийм орчинтой.

Одоо Америкийн “**Эс И Си**”[Securities and Exchange Commission (**SEC**)] гэж хэлдэг Санхүүгийн зохицуулах хороо нь үүнийг маш сайн ашигладаг. Өөрөөр хэлбэл олон нийтэд хувьцаагаа гаргасан компаниудын, ялангуяа нягтлан бодох бүртгэлтэй холбоотой, үнэт цаасны арилжаатай холбоотой гэмт хэргийг дотроос нь илрүүлж мэдээлэл өгөөд үүнийг үндэслэж ялладаг, шийтгэдэг тийм процесстэй. Энэ дээр Америкт саяхан гэхэд түүхэнд хамгийн өндөр, одоо 200 сая долларын урамшуулал өгч байсан тийм түүх байгаа.

Тийм болохоор энэ одоо орж ирж байгаа хуулийн төсөл дээрээ мөнгөн урамшууллыг эргэж харах хэрэгтэй.

Одоо Х.Нямбаатар сайд болохоор 80-аад оноос өмнө амьдарч байсан ах, эгч нар гэж хэлж байна л даа. Яах вэ, би бол хүүхэд байсан. Гэхдээ манай ээж, аав, эмээ, өвөөгийн хувьд бол энэ инээдэм биш байсан. Матаас бол зүгээр тэр нийгэмд матаасын ачаар албан тушаал ахидаг, нам дотроо нэр хүндтэй болдог ийм нийгэм байсан шүү дээ.

Тийм болохоор бид нар бас одоо энэ матаасын соёлыг ингэж мөнгөн урамшууллаар ерөөсөө дэмжиж болохгүй гэж би үзэж байгаа юм. Зарчмын хувьд.

Харин маш тодорхой гэмт хэрэг дээр. Жишээлбэл, санхүү, банкттай холбоотой байдаг юм уу, үнэт цаасны арилжаатай. Жишээлбэл, энэ коин гэсэн тиймэрхүү ийм олон хүнийг хамруулсан, олон энгийн иргэдийн санхүүгийн алдагдалд оруулсан гэмт хэрэг дээр бол байж болох юм. Зүгээр бусад юун дээр ямар нэгэн тийм ерөнхий зохицуулалтгүй, шалгуургүй мөнгөн урамшуулал өгөх чинь маш аюултай гэж бодож байгаа юм. Энэ бол зүгээр тэр чигээрээ бизнес болно.

Ингээд зарим нөхдүүд сошиал дээр бичсэн байна. Би чинь бараг хэдэн зуун сая төгрөг авчих юм байна шүү дээ гээд өөрсдөө биччихсэн байна лээ шүү дээ. Өөрөөр хэлбэл би ингээд матаад, гүтгээд тэрнийхээ урамшуулалд би тэдэн зуун сая төгрөг авна гээд сууж байх жишээний.

Энэ хуулийн төслөөрөө урамшуулал нь 100 мянгаас 1.5 тэрбум төгрөг хүртэл тийм хэмжээний урамшуулал авахаар хүмүүсийн нүдэнд мөнгө л харагдаж байгаа.

Тийм болохоор үүнийг би ажлын хэсэг болон сайдаас асуумаар байна. Энэ яг мөнгөн урамшууллыг яаж та нар зохицуулсан бэ? Одоо яг энэ нарийн шалгуурууд нь юу юм? Хэнд нь өгөөд хэнд нь өгөхгүй юм? Ямар тохиолдолд энэ

мөнгөн урамшуулал нь тооцогдох юм? Хэн үүнийг тооцох юм гэх мэтчилэн асуудлуудыг асууя. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар хариулна.

**Х.Нямбаатар:** Г.Амартүвшин гишүүн ээ.

Би тэр хуучин нийгмийн үеийн матаасны тогтолцоог инээдэм ханиадам байдлаар ерөөсөө огт хэлээгүй. Лениний “Төр ба хувьсгал” зохиолд харилцан иргэд бие биеийгээ хянах тогтолцоог маш тодорхой бичсэн байдаг.

Энэ нь цаашдаа биеллээ олж, маш олон мянган хүмүүс энэ матаас, гүжир гүтгэлгийн золиос болж хэлмэгдсэн энэ гашуун туршлага бидний өвөг дээдэс, эцэг өвгөдөд дайрч өнгөрсөн.

Тэгэхээр би таныг саруул ухаандаа энэ матаасны тогтолцооноос шүгэл үлээх харилцааг илүү өөрөөр ойлгоосой гэж бодож байгаа юм. Өөрөөр хэлбэл шүгэл үлээх харилцаа нь нийтийн албан тушаалтан, нийтийн албанд хувийн болон нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, урьдчилан сэргийлэх, хуульд заасан тэр чиг үүргээ хэрэгжүүлэхгүй, өөртөө давуу байдал үүсгэсэн, элдэв эс үйлдэхүй үзүүлсэн энэ үйлдэл бүрийг олон нийтийн хяналтад оруулах гэж байгаа ийм л үйлдэл.

Хоёрдугаарт, таны хэлж байгаа тэр санхүүгийн секторын мөнгөн урамшуулалтай холбоотой харилцаа бол энэ хууль тогтоогчийн өөрийнх нь цэвэр эрх хэмжээний асуудал.

Энэ Хууль тогтоомжийн тухай хуулиар анхдагч хуулийн төсөл. Урьд өмнө Улсын Их Хурал энэ төрлийн хууль батлаагүй. Анхдагч хуулийн төслийг өргөн мэдүүлж байгаа учраас хэлэлцүүлгийн

шатанд. Хэрэв хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн тохиолдолд хэлэлцүүлгийн шатанд энэ санхүүгийн секторынхоо хяналт шалгалтын шүгэл үлээх тогтолцоог өргөжүүлэн оруулах боломжтой гэж ойлгож байгаа юм.

Хоёрдугаарт, энэ 100 мянгаас 1.5 тэрбум төгрөгийн урамшууллын тогтолцоотой байхаар оруулж ирж байгаа юм.

Гуравдугаарт, энэ урамшууллыг урамшууллын зөвлөл өөрөө хэлэлцэж уг шүгэл үлээсэн асуудал нь үндэслэлтэй, учруулсан бодит хохирлыг нь нэхэмжилж гаргуулж, төрд учирсан хохирлыг нь арилгуулах боломжтой. Байгаль орчин, экологи сүйтгэсэн асуудлыг нь нөхөн сэргээлгэх боломжтой гэдэг энэ дүгнэлтийг нь үндэслэж байж асуудлыг шийдэж байгаа.

Өнөөдөр үүнийг нэгдсэн хуулийн зохицуулалтад оруулж өгье гэдэг асуудал яригдаж байгаа болохоос биш та, би, бид бүхэн, энд ирсэн бүх хүн хууль бус үйлдэл, үйл ажиллагааны талаар мэдээлэх үүрэгтэй.

Хоёрдугаарт, хүн бүр өнөөдөр Монгол Улсад бараг 2.1 сая фэйсбүүк хэрэглэгч интернэтэд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ фэйсбүүк дээр тавьж байгаа пост болгон өөрөө өнөөдөр шүгэл үлээж байгаагийн хэлбэр юм.

Үүнийг илүү хариуцлагатай, зөв зүйтэй, бодит мэдээллийг гаргадаг энэ тогтолцоог бий болгоё. Гаргасан хүний тэр нэр төр, алдар хүндийг хамгаалдаг хамгаалалтын механизмыг нь бүрдүүлж өгье. Бодит мэдээллийг нийтэд ил тод, шүгэл үлээсэн тохиолдолд урамшуулдаг тогтолцоотой болгоё гэдэг өнөөдрийн амьдрал дээр байгаа бодит зүйлийг

хуульчилж өгч байгаа нэг ийм хэлбэр юм гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан, Хүрэлбаатарын Булгантуяа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын урилгаар Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Ганибалын Амартүвшин гишүүн тодруулж асууна.

**Г.Амартүвшин:** Би асуулт асуух үедээ эхэндээ би хэлсэн. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Шүгэл үлээгчийг хамгаалах нь зөв. Энэ нь Европын Холбооны бүх орнуудад байдаг. Америкт байдаг. Бусад орнуудад байдаг. Байх ёстой гэж үздэг. Тийм болохоор энэ дээр дэмжиж байгаа, үгүй. Хэлэлцэх эсэхийг нь 100 хувь дэмжиж байгаа.

Зүгээр одоо энэ хуулийн хэлэлцэх эсэхийг нь шийдээд ажлын хэсэг байгуулагдаад явахдаа яг тэр мөнгөн урамшуулал тал дээр нь сайн ажиллаасай л гэж би яриад байгаа болохоос. Түүнээс нэг их шүгэл үлээгчийг хамгаалах ёсгүй гэдэг тийм байр суурь надад байхгүй. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хариулах уу? Санал хэллээ. Тийм ээ.

Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Эрхэм гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуулт асууя.

**Б.Пүрэвдорж:** Шүгэл үлээгчийн тухай хуулийг оруулж ирж байна. Мэдээж авлига, хээл хахууль, хүнд суртал Монгол Улсыг хэрж, үүнээс болж эдийн засаг

доройтож гол асуудал энд л байгаад байгаа.

Тийм учраас энэ Шүгэл үлээгчийн тухай хуулийг оруулж ирж байгаа нь зөв. Гэхдээ зөндөө асуудлууд байна. Тэгэхээр одоо жишээ нь Цагаан хадны нүүрсний цэгээс Ганц модны боомт хүртэл 29 километр газарт 120 сая төгрөгөөр нүүрсний тээврийг хийж байсан. Тэгээд энэ 29-хөн километрт 120 сая төгрөгөөр нүүрсний тээвэр хийнэ гэдэг чинь юунаасаа хулгайлж байна вэ гэхээр нөгөө Эрдэнэс Тавантолгойд очих ашгаасаа хулгайлж байна гэсэн үг байхгүй юу.

Тэгээд 1072-ын хувьцаанд ирэх ёстой бидний тэр хувьцаанаас хулгайлж байна гэсэн үг. Хэдхэн албан тушаалтан энд оролцож байна гэсэн үг.

Тэгээд эд нар яадаг юм бэ гэхээр бүх тээврийн зардлаа бүгдийг нь Хятадын тал руугаа шилжүүлж байгаад тэндээ хувааж аваад наашаа цаашаа шилжүүлцгээжээ. Энд нь Монголын олон дарга нар оролцдог. Дээрээс нь дахиад тэндээ цаанаасаа гарчхаад Ганц модны боомтоосоо янз янзын бараа бүтээгдэхүүнийг тэр контейнертаа ачаад буцаж наашаа оруулж ирдэг. Түүнд нь 100-гаас 120 мянган юань буюу 50-иас 60 сая төгрөг төлдөг.

Тэр тээврийнхээ хөлсийг бүгдийг нь цаашаа Хятадын талдаа аваачиж байгаад хувааж авдаг. Ерөөсөө 29-хөн километрт л хоёр талдаа ингээд 170 сая төгрөгийн тээвэр хийж байна гэсэн үг шүү дээ.

Тэгээд энд оролцсон хүмүүс мэдээж байж байгаа л даа. Энэ мөнгийг ийшээ тийшээ шилжүүлсэн гээд нэг шүгэл үлээгч гарч ирээд асуудал тавилаа гэхэд тэрийг нь Авлигатай тэмцэх газар хүлээж аваад дарчихвал яах юм? Хэргийг нь хэлэлцэхгүй бол яах юм? Тэгээд тэр шүгэл үлээгчийн бүх нэр хаягаа бүгдийг нь бүгд

тавина. Тэгэхээр нь тэр дагуу тэр шүгэл үлээгчид дарамт үүсвэл яах юм?

Тэгээд энэ гэрч, хохирогчийг хамгаалах, өөрөөр хэлбэл шүгэл үлээгчийг хамгаалахын тулд хамгийн гол нь 2012-2016 онд хэрэгжиж байсан тэр Тахарын албыг байгуулж, тэр Тахарын алба чинь яг тэр гэрч, хохирогчоо бүрэн дүүрэн хамгаалах ийм боломжийг хангадаг байсан шүү дээ. Гэтэл энэ гэрч, хохирогчоо хамгаалах талаар ямар ч юм байхгүйгээр ингэж Шүгэл үлээгчийн хуулийг оруулж ирнэ гэдэг бол энэ Шүгэл үлээгчийн хууль үндсэндээ явахгүй. Ер нь пропандын чанартай ийм хууль болж магадгүй болчихоод байгаа байхгүй юу.

Тийм учраас хэлэлцүүлгийн явцад хамгийн гол нь шүгэл үлээгчийн өргөн барьсан тэр мэдээллийг хэр хугацаанд яаж шийдэх юм. Ямар процедураар хэргийг хянан шийдвэрлэх юм. Энэ асуудлыг тодорхой хуульд тусгаж өгөх хэрэгтэй.

Дээрээс нь хамгийн гол нь тэр шүгэл үлээгчийг хамгаалах ёстой асуудал байхгүй юу даа. Жоохон явж байгаад нөгөө шүгэл үлээгчээ дарамталсаар байгаад материалыг нь буцааж авхуулдаг ийм юм руу л ерөнхийдөө наадах юм чинь орох гээд байна шүү дээ. Нөгөө шүгэл үлээгч чинь гэрээсээ гарч чадахгүй, орж чадахгүй. Гарсан тохиолдолд дарамтад ороод энэ хамгаалах ямар ч тийм эрх зүйн орчныг бүрдүүлэхгүйгээр энэ хуулийг явуулна гэдэг буруу л гэж үзэж байна.

Тийм учраас мэдээж сайхан сэтгэл байна. Тэгэхдээ үүнийгээ яаж шийдэх юм. Хэлэлцүүлгийн явцад үүнийг нэмж оруулах боломжууд байгаа юм уу? Энэ талаар тодорхой хариулт авъя.

**Г.Занданшатар:** Авлигатай тэмцэх газрын эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн. 84.

**Д.Дуламсүрэн:** Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр Авлигатай тэмцэх газарт ирж байгаа өргөдөл, гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газар холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шалгаж шийдвэрлэх, өөрсдийнхөө эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ёстой өргөдөл гомдлыг шийдвэрлэж, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргагчид хариу хүргүүлдэг. Харин эрүүгийн гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол, мэдээлэл бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу процессыг прокурорын хяналт доор явуулдаг учраас Авлигатай тэмцэх газар ямар нэг байдлаар үүсчихсэн хэргийг ч юм уу, хянан шалгаж байгаа хэргийг нуун дарагдуулах. Түүний хувь заяаг тийм ээ өөрсдийнхөө үзэл бодлын дагуу шийдвэрлэх ийм боломж байхгүй гэдгийг би энд зориуд хэлмээр байна.

Тэгэхээр Авлигатай тэмцэх газрын хувьд ирүүлсэн өргөдөл, гомдлыг гэмт хэргийн шинжтэй тохиолдолд манай Мөрдөн шалгах хэлтэс холбогдох мөрдөн шалгах ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокурорын хяналтад явуулдаг. Хэрэг нээлээ л бол энэ бүрэн прокурорын хяналтад ордог. Түүнээс зүгээр сонирхлын зөрчилтэй холбоотой хувь тийм ээ албан тушаалтны ёс зүйтэй холбоотой асуудал бол Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн дагуу явж байгаа.

Тийм учраас хууль зөрчих тийм ээ ямар нэг байдлаар нуун даруулах ийм асуудал гардаггүй гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Пүрэвжавын Сайнзориг. 80. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

**П.Сайнзориг:** Б.Пүрэвдорж гишүүний хоёр асуултад хариулья.

Хуулийн төслийг та зарчмын хувьд дэмжиж байгаад талархаж байна. Тэгээд хуулийн төслийн 8.2 дээр байгаа. Яг эрх бүхий байгууллага шүгэл үлээсэн энэ мэдээллийг хүлээж авснаас хойш ямар арга хэмжээ авах вэ гээд. 30 хоногийн дотор хяналт шалгалтыг явуулж, шалгалтын үр дүнгээс шүгэл үлээсэн хүндээ мэдэгдэх энэ үүргийг хүлээж байгаа.

Хоёрдугаарт, яг энэ шүгэл хүлээлгээд мэдээллийг гаргаад зогсохгүй яг хуулийн төслийн 9.4 дээр шүгэл үлээгч, түүний төлөөлөх эрх бүхий этгээд буюу өмгөөлөгч нь ч байдаг юм уу, эсвэл холбогдох төлөөлөх эрх бүхий этгээд нь хамгаалалтын арга хэмжээг авья гэх юм бол үүнийг Авлигатай тэмцэх газар болон бусад мэдээллийг шилжүүлж авсан байгууллагууд энэ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авах үүргийг хүлээж байгаа.

Тэгэхээр энэ төрийн байгууллагууд талдаа энэ мэдээллийг ил тод гаргаж тавьж байгаа хүмүүсийг эрх зүйн байдлыг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах энэ арга хэмжээг хослуулан хүсэлтийнх нь дагуу аваад явах энэ үүргийг хүлээж байгаа гэдэг зүйлийг танд хэлье.

Хоёрдугаарт, мэдээж шүүх хүлээгч маань бас нэг боломж юу вэ гэхээрээ хувийн мэдээллээ олон нийтэд гэдэг юм уу дэлгэхгүй байх энэ асуудлыг хөндөж тавьж болно. Энэ тохиолдолд эрх бүхий байгууллагаас мэдээллийг хамгаалах үүрэгтэй байж байгаа.



Мэдээж мэдээллийг шалган шийдвэрлэж дуусаж байж л энэ шүгэл үлээгчийн урамшуулал ч гэдэг юм уу, дараагийн дараагийн асуудал яригдана. Түүнээс биш хуучин цагийн мэдээлэл гаргаад л арга хэмжээ авчихдаг зүйл биш. Энэ гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиараа бусад төрлийн мэдээлэл, ашиг сонирхлын мэдээлэл юм уу, зөрчлийн мэдээлэл байвал зөрчил шалган шийдвэрлэх байдаг юм уу, татварын асуудал ч юм уу, эсвэл өрсөлдөөний асуудал байвал холбогдох хуулийн дагуу шалган шийдвэрлэсний дараа бусад тэр асуудлуудаараа урамшуулах байдаг юм уу, бусад төрлийн асуудлууд нь яригдана гэдэг зүйлийг дахин нэг тодотгож хэлье.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Наадах юм чинь их явахгүй юм байна даа.

Тэгээд одоо ингээд Авлигатай тэмцэх газар гүйцэтгэх байгууллагын хяналт доор байдаг. Томилгоон доор байдаг. Тэгээд тэндхийн янз янзын сонирхлууд ордог. Дарга цэрэг нар мэддэг, энэ харцаараа хөдөлгөдөг, хуруугаараа хөдөлгөдөг ийм юмнууд зөндөө л байгаа шүү дээ.

Тэгээд ийм тохиолдолд тэр одоо жишээ нь Цагаан хадны боомтоор гарч байгаа тэр их авлигал, хээл хахууль бүх дарга нар бүгдээрээ холбоотой болчихсон энэ тохиолдолд тэрийг жишээ нь шүгэл үлээсэн хүнийг бүгдээрээ нийлж байгаад тал талаас нь тасдаж идэх юм байна шүү дээ.

Тэгээд тэр шүгэл үлээснийхээ төлөө бүр өөрийнхөө амь насыг эрсдэлд оруулах юм байна. Бүх мэдээлэл нь бүгдээрээ 1 минутын дотор гэхэд цаана энд холбогдсон албан тушаалтан дээр бүгдээрээ очно.

Тэгээд энэ шүгэл үлээсэн хүн чинь өөрөө эрсдэлд орно. Үүний төлөө шүгэл үлээгч.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Одоо эрхэм гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга.

**Б.Энх-Амгалан:** Авлигаас ангид байх гэж байгаа, авлигаас урьдчилан сэргийлэх гэж байгаа, авлигын индексийг бууруулах гэж байгаа, ард олон нийтийн хараа хяналтыг нэмэгдүүлэх гэж байгаа энэ санаа нь зөв өө. Зорилго нь зөв. Санаачилга нь зөв.

Гэхдээ би энэ хуулийг зүгээр юугаар хараад байна гэхээр зэрэг Монгол Улсын үндэсний аюулгүй байдал талаас нь, Монгол төрийн дархлаа талаас нь, хүний эрх талаас нь, Үндсэн хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй байна гэдэг талаас нь, ард түмний эв нэгдэл талаас нь хараад байх юм.

Тэгээд хуулийн энэ бичиглэл нь болж өгөхгүй байна. Амаар, бичгээр, захидлаар эрх бүхий хуулийн хоёрдогч, гуравдагч этгээдээр дамжуулж мэдээлэл өгч болох юм байна.

Монгол хэл дээр мэдээлэл өгч болох юм байна. Өөрийнхөө эх хэл дээр өгч болох юм байна. Сайн мэддэг гадаад хэл дээр өгч болох юм байна.

Тэгэхээр гадаадын иргэд Монголын дотоод хэрэгт оролцож Монголын иргэдийг хууль хяналтын байгууллагад нь матах нь ээ. Тэгж ойлгогдож байна. Биччихсэн энэ бичиглэлээс чинь.

Тэгээд тэр өгсөн мэдээллийг битүүмжлээд хадгалах юм байна. Тэгээд мэдээлсэн этгээдийг зөвшөөрөлгүйгээр тэр мэдээлэлтэй танилцахыг хориглох юм

байна. Мэдээллийн дагуу шуурхай хойшлуулшгүй ажиллагаа явуулж, хяналт шалгалт хийх юм байна. Энэ хуулийн байгууллагууд. Тэгээд өгсөн мэдээллийн асуудлаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллагад хандаж болно. Гэхдээ мэдээлсэн эх сурвалжаа нууцлах юм байна.

Дээр нь төрийн албан хаагч мэдээлэл гаргах юм бол төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийг нь тогтоосон хязгаарлалт хамаарахгүй юм байна.

Ингээд ерөөсөө нууц задлах нь байна шүү дээ. Энэ чинь. Тэгээд тэр мэдээлэл өгч байгаа гаднын тэр матаасчин гэдэг юм уу, юу гэдэг юм. Тэр шүгэл үлээгч гэж нэрлээд байгаа нөхрийнхөө баталгааг Монголын төр хангах юм байна. Баталгааг нь гаргах юм байна. Хохирол учруулахаас болгоомжлох юм байна. Шүгэл үлээгчийг хариуцлагад татахгүй юм байна. Хамгаалалтын арга хэмжээнүүд авах юм байна. Эрх бүхий байгууллага буюу энэ хуулийн байгууллагууд чинь шүгэл үлээгчийг дэмжиж ажиллах юм байна. Шүгэл үлээгчид Монголын төр мөнгөн урамшуулал олгох юм байна. Нөхөн төлбөр олгох юм байна. 50-иас 1.5 тэрбум төгрөг олгох нь. Ийм олон зүйл байгаа юм.

Тэгээд энэ 5 бүлэг, 22 зүйл дээр тэр мэдээлэл өгсөн гадна, дотнын нөхдүүдээс болоод хүний эрх зөрчигдвөл яах вэ, хохирвол яах вэ гэдэг юмыг би нэгийг ч олж үзсэнгүй.

Түрүүн Төрийн нарийн 20 дугаар зүйл гээд байна. Тэр чинь зүгээр л худал мэдээлэл өгөхийг хориглох тухай л ганцхан заалт байна лээ. Хариуцлага нь алга.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд бие даасан хууль байж байгаа шүү дээ. Мэдээлэгчээс мэдээлэл худалдан авах тухай 6 хууль байж байгаа.

Тэгээд энэ шүгэл үлээгч гэж нэрлэж байгаа энэ мэдээлэгчээс болоод төрийн албан хаагч бие биеийгээ мартвал яах вэ? Дургүй албан хаагчаа.

Нэг чиглэлд ажилладаг аж ахуйн нэгж монополийн тухай хуулиар асуудлаа нэгийгээ унагах ийм мэдээлэл дамжуулбал яах вэ?

Улс төрийн албан тушаалтнууд, улс төрийнхөн өрсөлдөгчөө дарамтлах, өрсөлдөгчөө зайлуулах ийм бодлого явуулбал яах вэ?

Монгол Улсын иргэн дарамт шахалтад орвол яах вэ? Монгол Улсын иргэний эрх зөрчигдвөл яах вэ? Эрхээ хязгаарлуулбал яах вэ? Хүчирхийлэлд өртвөл яах вэ? Өш хонзонгийн бай болбол яах вэ?

Бид дөнгөж л сая хэлмэгдлийн тухай яриад л явж байгаа даа. Нийгэмд эзлэх байр суурь, энэ удам судар олон юмаараа доромжлуулбал яах вэ?

2.6 сая фэйсбүүк дээр байж байгаа пост чинь шүгэл үлээгч юмаа гэж яриад сууж болдог юм уу? Бид нар. Бид хуурамч хаягуудаа цэгцэлж чадаагүй байгаа шүү дээ. Энэ баруунтан зүүнтэн, Лхүмбийн хэрэг, Гэдэн, Дэмидийн хэрэг, энэ Японы тагнуулын хэрэг гээд баахан монгол хүнийг, эх орончдыг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариулт хангалтгүй бол дэгийн хуулиараа. Хариулт хангалтгүй бол тодруулж асууж болно гэж байгаа. Хариулаагүй байгаа юм чинь.

Хишгээгийн Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** Б.Энх-Амгалан гишүүн ээ. Хэдүүлээ энэ хандлагаа өөрчилмөөр байгаа юм.

Авлигажсан үндэсний аюулгүй байдал, авлигажсан төрийн нууц, авлигажсан албаны нууц гэж ерөөсөө байхгүй.

Шүтэл үлээхэд Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа гадаад, дотоодын иргэний ялгаа байхгүй. Гадаадын хөрөнгө оруулагч тодорхой асуудлаар шүтэл үлээхэд энэ ерөөсөө олон улсын дэлхий нийтийн жишиг хандлагаар л явж байгаа.

Би таныг яг хаанаас ийм шүтэл үлээгчийн төгс төгөлдөр хууль уншсаныг мэдэхгүй байна. Бид энэ Европын Холбооны улс орнуудад хүчин төгөлдөр үйлчилж байгаа шүтэл үлээгчийн хуулийн стандарт, норм, дүрэм журмын дагуу үг, хэллэгийг монгол хэл дээр орчуулж өөрийн орны бусад хууль тогтоомжуудтай нийцүүлэх замаар шүтэл үлээгчийн хуулийг бичсэн.

1930, 1940-өөд оны үеийн улс төрийн их хэлмэгдүүлэлт 1950, 1960-аад оны үеийн сэхээтний төөрөгдөл гэдэг айхтар гашуун туршлагыг бүгд мэдэж байгаа. Яг үүнтэй адилхан энэ матаасны тогтолцоо оруулж ирж байгаа зүйл огт байхгүй.

Тэр төрийн албан хаагч, нийтийн албан тушаалтан ажил, хөдөлмөрөө ном журмынх нь дагуу гүйцэтгэж байгаа тохиолдолд тэр хүний ажил, хөдөлмөрийг харлуулж, гүтгэх зорилгоор хуулийн байгууллагад шалгуулж байгаа үйлдэл, үйл ажиллагаа одоо ч гэсэн явж байгаа. Одоо ч гэсэн явж байгаа.

Өнөөдөр энэ фэйсбүүк дээр постолж байгаа пост чинь өөрөө шүтэл үлээж байгаа хэлбэрүүдийн нэг. Бид үүнийг хэлбэржүүлж өгье. Нийтийн албан

тушаалтны ёс бус, хууль бус үйлдэл, үйл ажиллагааг олон нийтийн хяналт руу оруулъя л гэж байгаа шүү дээ.

Алт хууль бусаар ухаад тэнд нь байгаль орчин, экологид хор хөнөөл учруулахуйц цианит натри ашиглаж байгаа талаар мэдээллийг яагаад гадаадын хөрөнгө оруулагч зэргэлдээх байгууллагынхаа талаар мэдээллийг Экологийн цагдаагийн байгууллагад мэдээлж болохгүй гэж.

Прокурорын байгууллагын албан тушаалтан, мөрдөгч хоёр үгсэн хуйвалдаад хөрөнгө оруулагчийнх нь, нөгөө хөрөнгө оруулагчийнх нь захиа даалгавраар бусдыг хэлмэгдүүлж, шударга бусын хонгилоор явуулж байгаа зүйлийг яагаад мэдээлж болохгүй гэж.

Тэгэхээр өнөөдөр шүтэл үлээх гэдэг ойлголт бол хэн нэг хүнийг хэлмэгдүүлэх, гүжирдэн гүтгэх гэдгээсээ илүүтэй хууль бус үйлдэл, үйл ажиллагааг олон нийтэд илчилж гаргаж ирэх бүх нийтийн хяналтын тогтолцоо гэдгийг л та ойлгомоор байна.

Хоёрдугаарт, бид бусдыг гэмт хэрэгт гүтгэж, эрх, эрх чөлөөнд нь халдаж байгаа үйлдэл, үйл ажиллагааг нөгөө гүтгүүлсэн, шалгуулсан хүн чинь гаргах эрх нь Эрүүгийн хуулиараа нээлттэй байгаа шүү дээ. Монгол Улсын Эрүүгийн хууль, Монгол Улсын Зөрчлийн тухай хууль гэдэг бол Монгол Улс дахь хариуцлагын нэгдсэн тогтолцоо. Тэнд хэн нэг хүний эрх, эрх чөлөөнд халдаж байгаа тохиолдол бүрт нь эрхээ хамгаалуулах, өргөдөл гомдлоо гаргах эрх нь тэнд давхар нээлттэй байгаа.

Хуучин тогтолцоо шиг язгуур гаралтай, шашин шүтлэгтэй лам хард үзүүлдэг гээд шалгуулаад.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэнгийн урилгаар Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Наран ургах зүг эх орны зүүн хязгаараас хүрэлцэн ирсэн Та бүхэндээ хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Асуулт хариултын цаг үргэлжилж байгаа. Одоо Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн тодруулж асууна. 1 минут.

**Б.Энх-Амгалан:** Би тодруулж асуухгүй. Би зүгээр хуулийн заалтууд л Та бүхэнд сая уншиж өгсөн шүү. Ийм аюулууд байна гэдгийг.

Улс орны тусгаар тогтнол талаасаа, төрийн дархлаа талаасаа, хувь хүний эрх, эрх чөлөө талаасаа, ард олон нийтийн эв нэгдэл талаасаа ийм орж ирсэн бичигдсэн бичиглэл чинь ийм байна шүү л гэж хэлсэн шүү.

Түүнээс би үүнийг нэг их эсэргүүцээд хамгаалаад байгаа юм алга.

Ер нь бид нэг юмыг сайн санаж байх хэрэгтэй. Лхүмбийн хэрэг, энэ Гэндэн, Дэндийн хэрэг, баруунтан, зүүнтэн гэж бид олон хүний халуун амь, бүлээн цусаар хэлмэгдүүлж байсан. Гаднын гар хөлөөр хэлмэгдүүлж байсан ийм тохиолдол бий шүү. Үүнийг сайн анхаараарай л гэж хэлэх гээд байгаа юм.

Энэ тусгай албадын янз янзын арга хэрэгсэл бий шүү. Үүнийг анхаараарай л гэх гээд байгаа юм.

Наад дээр чинь хэрвээ асуудалд ороод хэлмэгдчихэж яах вэ гэдэг асуудлыг нь ярихад гүтгүүлсэн гэдэг юмаараа барь гэж байгаа юм. Тэр хүн чинь том асуудалд орчихвол яах вэ л гэж яриад байгаа юм.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Балжиннямын Баярсайхан асуулт асууна.

**Б.Баярсайхан:** Сүүлийн 30 жилд Монгол Улсын хөгжлийн алдаа нь энэ салбар болгонд авлига цэцэглэсэн, ёс суртахуун унасан. Үүнээсээ болоод өнөөдөр бид хөгжиж чадахгүй, цаашаа гацчихсан байгаа нэг ийм хамгийн том асуудал байгаа. Энэ асуудлыг шийдэх гэж зорилго нь зөв орж ирж байгаа хууль гэж харж байна.

Тэгээд Х.Нямбаатар сайд аа, би хоёр, гурван асуулт асуумаар байна. Энэ улсын хэмжээнд байгаа 200-гаад мянган төрийн албан хаагч нар дотор чинь шударга хүмүүс олон байдаг.

Тэгээд төрийн албан хаагч нар маш их шүгэл үлээдэг шүү дээ. Тэрийгээ шүгэл үлээж байна гэж ярихгүй боловч энэ төрийн албанд байгаа шударга бус зүйлийн талаар, авлигын талаар, ёс суртахуунгүй байдлын талаар, энэ салбарыг самарч байгаа хэн нэгний талаар шүгэл хүлээдэг. Харамсалтай нь энэ төрийн албан хаагчдын үг, дуу хоолой ерөөсөө хүрдэггүй. Төрийн албан хаагч учраас даруу байх ёстой гэдэг юм уу, яадаг юм.

Би үүнийг өөрөө биеэрээ мэдэрсэн хүний хувьд хэлж байна. Ноцтой ноцтой гэмт хэргийн чанартай асуудлуудыг Авлигатай тэмцэх газарт явуулдаг. Энэ хэрэг замхарчихдаг. Хууль хяналтын байгууллага дээр ялгаварлаж шийдэгддэг. Улс төрийн нөлөөлөл ордог. Тэр битгий

хэл улс төрч биш байсан ч гэсэн яам, Тамгын газрын дунд шатны дарга нар Авлигатай тэмцэх газарт байдаг холбоо сүлжээ, хууль хяналтын байгууллагад байдаг холбоо сүлжээгээрээ хэргээ нуун дарагдуулаад өнгөрчихдөг ийм асуудал өнөөдрийг хүртэл байсаар байна.

Тэгэхээр төрийн албан хаагчид, шударга төрийн албан хаагчдын энэ төрийн албыг цэвэр тунгалаг байлгахын төлөө хэлж байгаа, ярьж байгаа, дуугарч байгаа асуудал дээр та нар яг ямар байр суурьтай энэ хууль үйлчлэх юм бэ гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуудал бол энэ шүгэл үлээгч байснаараа хэлмэгдэх тохиолдол байна. Энэ бол ганцхан Монгол Улсад биш, олон улсад ч гэсэн ийм жишээнүүд байна.

Хэрвээ Монгол оронд шүгэл үлээгээд өөрийнх нь амь нас, өөрийнх нь карьер, амьдрал нь ямар нэгэн байдалд эрсдэлд ороод гадаад улс руу явъя гэхэд тэнд манай монгол хүмүүсийг авах эрх нь нээлттэй байгаа юу? Энэ хууль батлагдсанаараа ийм эрх нээгдэх үү гэдэг асуудал байна.

Мөн гурав дахь асуулт бол энэ хууль батлагдсанаар Монгол Улс олон улсын ямар гэрээ эрх зүйн фактад нэгдэх юм бэ? Өөрөөр хэлбэл энэ шударга ёсыг тогтоох гэж ингэж амь нас, эрүүл мэнд, магадгүй гэр бүлийнхээ гишүүдийг. Тийм ээ. Өөрийнхөө бүхий л энэ амьдралыг эрүүл мэндийг хамгаалахын тулд нийгмээ сайхан байлгахын тулд шүгэл үлээгээд тэгээд араас нь энэ хүнд зүгээр мөнгөн урамшууллаас гадна ямар баталгаа байх юм бэ гэдэг чинь тодорхойгүй ингэж харагдаад байна.

Их Хурлын чуулган дээрээс, Байнгын хорооны хурал дээрээс хүртэл Улсын Их Хурлын гишүүний хувьд шүгэл

хүлээж байгаа би олон асуудлуудыг ярьж байгаа шүү дээ. Жишээлбэл, Завхан аймагт тэр чигт нь бүх суманд нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бүх бүтээн байгуулалтыг бүгдийг нь чанаргүй хийгээд луйвардаад алга болчихсон хэсэг хулгайч нарыг бариад өгөөч ээ. Энэ бүхэл бүтэн далан хэдэн мянган хүн амтай энэ аймгийг хохиролгүй болгоод өгөөч ээ. Бүлэглээд ингээд авлигажаад идээд уугаад хохироогоод явчихсан энэ хүмүүст хариуцлага тооцоод өгөөч ээ гээд л яриад байхад энэ дээр Авлигатай тэмцэх газар ч дуугардаггүй, Засгийн газар, Сангийн яам энэ дээр юу ч хэлдэггүй шүү дээ.

Үндэсний аудитын байгууллагынх нь дүгнэлт нь гарчихсан байж байдаг. /минут дуусав/

**Г.Занданшатар:** Хишгээгийн Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** Би Б.Баярсайхан гишүүнтэй ер нь санал нэг байна.

Энэ манай эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, ялангуяа мөрдөн шалгах ажиллагаа хэдэн жил ч үргэлжилж болдог, хэчнээн удаан ч хэрэг шийдэгдэхгүй байж болдог, эсвэл ингээд шүүх дээр очоод замхардаг ийм байдалтай байгаа.

Би энэ сарын 28-ны өдөр сүүлийн 10 жилийн хугацаанд гадна, дотнын хөрөнгө оруулагчдыг дээрэмдэж, тоносон бүх эрүүгийн хэргүүдийн талаар мэдээллийг олон нийтэд хүргэнэ.

Үүгээрээ би юу хэлэх гэж байна вэ гэвэл энэ хэрэгт ямар хүмүүс мөрдөн шалгах ажиллагаа явуулсан юм, хэн мөрдөн шалгах газрынх нь дарга байсан юм, хэн гэдэг хүн энэ хяналт тавьж ажилласан прокурор нь юм. Энэ бүх мэдээллүүдийг олон нийтэд ил болгож бас

нэг шүгэл үлээж байгаа хэлбэрийг үзүүлье гэж бодож байгаа.

Тэгээд цаашид бид энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиа илүү боловсронгуй болгож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар маш богино хугацаанд хэргийг мөрддөг. Гэм буруутай бол буруутай гэдгийг нь нотлоод шүүх рүү явуулдаг. Буруугүй бол цагаатгаад хүнийг хэлмэгдүүлдэггүй ийм тодорхой процессын шуурхай байх зарчмыг хангасан өөрчлөлтийг оруулж ирэхээр бид ажиллаж байгаагаа хэлье.

Төрийн албан хаагчтай холбоотой асуудал дээр энэ хууль дээр төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа авлига, ашиг сонирхлын талаар олж авсан мэдээллээр шүгэл үлээхэд төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний нууцын мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийн хязгаарлалт хамаарахгүй. Төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулсан гэж хуулийн хариуцлага хүлээлгэхгүй гээд хуульчилж өгсөн.

Хоёрдугаарт, бид Авлигын эсрэг конвенцод нэгдэж орсон улс. Авлигын эсрэг конвенцод нэгдэж орсон улс орнуудад өгсөн зөвлөмжийн хүрээнд олон нийтийн хяналтын тогтолцоо буюу шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг тодорхой болгооч ээ гэдэг ийм зөвлөмжүүд удаа дараа гарсан.

1998 онд Европын Холбоо байгуулагдсаны дараа Европын Холбооны гишүүн улсууддаа Европын парламентаас зөвлөмж гаргасан. Энэ зөвлөмжийн хүрээнд өнөөдөр Европын Холбооны бараг бүх улсууд шүгэл үлээгчийн эрх зүйн тогтолцоотой болоод байгаа. Бидний бас чиг баримжаа болгож энэ төслийг бичсэн хууль эрх зүйн орчин бол Европын Холбооны шүгэл үлээгчдийн харилцааг энэ хууль дээр илүү тусгаж өгсөн.

Хамгаалалтын хувьд гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрт хамруулахаас гадна энэ хуульд заасан болон бусад Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар шүгэл үлээгчдийн эрх зүйн байдлыг хамгаалж өгч байгаа гэж ойлгож болно.

Дээр нь шүгэл үлээгчтэй бид бас тодорхой зүйлүүдийг хориглож байгаа. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулж болохгүй. Өөрт болон өөрийн хамаарал бүхий этгээдүүддээ шүгэл үлээснийхээ төлөө давуу байдал, ашиг хонжоо бий болгож болохгүй гэсэн ийм зохицуулалтуудыг бий болгож өгч байгаа.

Тэгээд одоо би Б.Баярсайхан гишүүнд яг нэг зүйлийг хэлэх гэж байна. Та ингээд илүү их.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарын урилгаар Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төр, ард түмнийг холбох, төр ард түмэндээ үйлчлэх ариун үйлсэд чинь өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Тодруулж асуухгүй. Тийм ээ. Хишгээгийн Нямбаатар сайд гүйцээж хариулъя.

**Х.Нямбаатар:** Тийм. Гишүүн маш их ийм дэвшилтэт үзэлтэй байгаад баярлаж байна.

Энэ хэлэлцүүлгийн явцад яг л хоёр хуваагдаж байгаа юм. Зарим хүмүүс нь хуучин матаасны тогтолцоо л гэж хараад

байгаа. Үгүй. Энэ бол илүү олон нийтийн хяналт гэдэг агуулгаас л бид харах ёстой.

Тэгээд би нэг зүйлийг Б.Баярсайхан гишүүн яг хэлж мэдэхгүй байна. Энэ анх удаагаа Монгол Улсад энэ эрх зүйн орчныг бид хамгаалалтын орчныг бий болгох гэж байгаа юм. Амьдралд хэрэгжих явцад мэдээж хэрэг алдаа оноотой талууд гарч ирэхийг үгүйсгэхийн аргагүй. Гэхдээ бид нэг алхам урагшаага алхъя. Бүх болж бүтэхгүй зүйлийг сумын иргэд ч гэсэн шүгэл үлээдэг. Энэ болохгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэж байгаа чанаргүй, байгаль орчинд хор хөнөөлтэй байдлаар гүйцэтгэх гэж байгаа компанийг хүртэл шүгэл үлээдэг энэ эрх зүйн орчинг л бий болгох гээд байгаа юм.

Тэгээд би Б.Баярсайхан гишүүн тэргүүтэй дэмжиж энэ шүгэл үлээх эрх зүйн орчныг бий болоосой гэж дэмжиж байгаа гишүүддээ талархлаа илэрхийлье.

**Г.Занданшатар:** 1 минут.  
Б.Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Ингээд Б.Чимид багшийн хэлсэн сайхан үг байгаа. Улсын Их Хурал нь сайн хууль батлаад, Засгийн газар нь сайн хэрэгжүүлээд, хууль хяналтын байгууллага нь шударга ажиллах юм тэнд сайхан нийгэм бүрдэнэ гэж.

Харамсалтай нь өнөөдөр хууль хяналтын байгууллага ёс зүйгүй үйлдэл, ёс зүйгүй хүмүүс ажиллаж, улс төрийн болон янз бүрийн ялгаварлан гадуурхалт, хэрэг нуун дарагдуулах ийм асуудлууд байгаа гэдэг нь нууц биш. Өөрөөр хэлбэл хууль хяналтын байгууллага төдийлөн шударга ажиллаж чадахгүй байгаа гэж би хэлэх гээд байна.

Тийм учраас Х.Нямбаатар сайд аа. Одоо нийгмийг бухимдуулж байгаа олон олон энэ том том хэргүүдийг маш хурдтай

шалгаж, энэ нийгмийг төрдөө итгэх итгэлтэй цаашдаа олон шударга шүгэл үлээгчдийг энэ нийгэмд төрүүлэхийн тулд, энэ нийгмийг цэвэрлэхийн тулд Та бүхнийг үр дүнтэй ажиллахыг хүсэж байна? Ард түмэн ч гэсэн үүнийг хүсэж байгаа гэж харж байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Үг хэллээ.  
Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Хоёр, гурван асуулт асууя. Яг энэ хуулийг баталснаар манай улсын авлигын индекс хэрхэн яаж сайжрах юм? Ямар тооцоо, судалгаа байна? Энэ хуульгүй болохоор авлигын индекс унаад байна гэж ингэж үзэж байгаа юу? Батлагдсанаар ингэж сайжрах юм. Хоёр оронтой тоо руу орох бололцоо, боломж байна гэдэг ийм тооцоо судалгаа байна уу гэдгийг нэгт асууя.

Хоёрт, шүгэл хүлээгч гээд бид энд ярихаар ингээд олон улсын нэр томъёо гээд. Яг иргэдэд очоод ингээд хуулийн талаар танилцуулга, мэдээлэл хийхээр нэг л бууж өгөхгүй байна л даа.

Тэгээд нэр томъёоны хувьд. Илчлэн мэдээлэгчийн тухай хууль гээд нэрлэж болохгүй юу? Шүгэл үлээгч гэхээр хажууд нь яг нөгөө саяын сайдын хэлдгээр нэг матаачийн гэдэг юм уу. Тэр агуулга юм сонсогдоод харагдаад байгаа байхгүй юу. Энэ дээр.

Нөгөө талаар шүгэл үлээж байгаа нөхөр, субъект, эрх зүйн харилцаанд оролж байгаа нөхөр бүх талаар хууль зүйн хамгаалалт авч байна.

Аюулгүй байдал талаасаа. Нөгөө талаар илчилснийхээ төлөө мөнгөн урамшууллаар хүртэл шагнагдах бололцоотой болж байгаа юм.

Нөгөө талаас нь бас хэр харсан бэ? Магадгүй зүгээр улс төрийн гэдэг юм уу, хувийн өш хонзонгийн сэдлээр тухайн хүний нэр хүнд, алдар хүндийг гутаах, унагах зорилго бүхий ийм байдлаар асуудалд хандчихаад дараа нь тэгээд ямар ч хуулийн хариуцлага хүлээхгүй ингээд асуудлаас бултаад. Тэгээд сүүлдээ үндсэндээ тэр нөхөр гүтгүүлээд дуусдаг. Тэр нөхрийн цаана хань ижил, гэр бүл, үр хүүхэд, хамт олон, ах дүү, хамаатан садан бүгд сэтгэл зүйн хохирол амсаад үлддэг. Гүтгүүлээд дуусдаг. Нийгэм дэх нэр хүндийн асуудал байхгүй болдог.

Ингэсэн тохиолдолд энэ хуулийн энэ хууль зүйн харилцаанд орж байгаа хоёр субъект хэтэрхий нэг талыг барьсан ийм хууль болж байна уу, үгүй юу?

Нөгөө талын хүн чинь бас хүн шүү дээ. Эрхээ хамгаалуулах эрхтэй шүү дээ. Зүгээр мөрөөрөө байж байгаад хэн нэг хүнд гүтгүүлэх асуудал өнөөдөр ямар байгаа билээ. Нийгэмд. Тэр дундаа. Манайхан хуулийг яаж гууль болгодог билээ. Мушгин гуйвуулдаг билээ. Тэр дундаа энэ хуулийг чинь улс төрийн сонгуулийн үеэр маш өргөн хүрээнд ашиглагдаж ингэж явах юм байна.

Нөгөө талаар 3.2.2-ын заалт. Яг тэр асуудал чинь төрийн болон албаны нууцын хамааралтай. Үүний чинь цаана тэр авлига, ашиг сонирхлын асуудал чинь байгаа юм биш үү.

Бүх юмаа энэ төрийн албаны нууцаар хаачхаад тэгээд бүхнээс ингээд хаагдмал байдалтай явж ирж. Хэрвээ энэ заалтыг өөрчлөхгүй бол энэ хуулийн төслийг дэмжих бололцоо, боломж байхгүй л гэж үзэж байгаа юм. Яг гол асуудал чинь үүний цаана байна шүү дээ. Энэ том нууцын тухай хуулийн чинь цаана байна шүү дээ. Том төсөл, хөтөлбөрүүд

дээр байна шүү дээ. Энэ авлига, ашиг сонирхлын асуудлууд чинь.

Тэгээд энэ болгоныгоо хууль оруулж ирээд нууцын зэрэглэлд хамааралтай гээд ингээд хаачхаад. Тэгээд энэ шүгэл үлээгчийн хууль бол энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй гэхихээр чинь гол байгаа онохгүй байгаа юм биш үү. Харин ч үүнийг илчилж байх ёстой юм биш үү. Хэрвээ үүнийг өөрчлөхгүй бол энэ хуулийн төслийг дэмжих боломж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хишгээгийн Нямбаатар сайд хариулья.

**Х.Нямбаатар:** Би Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт, энэ хууль батлагдсанаар авлигын төсөөллийн индекс ер нь хэрхэн байр доошлох юм бэ гэдэг ийм асуултыг асууж байна. Трансперенси интернэшнл олон улсын байгууллагаас бидэнд өгч байгаа зөвлөмжөөр хоёр зүйл дээр их том юу өгч байгаа. Анхаарал тавьж байгаа. Анхаараач ээ гэж байгаа юм.

Нэгдүгээрт, улс төрийн нам, улс төрийн намын санхүүжилтийнхээ асуудлыг тодорхой болгохгүйгээр том байр урагшлахгүй гэдгийг маш тодорхой хэлж байгаа.

Хоёрдугаарт, төрийн болон орон нутгийн өмчит компанийнхаа засаглалыг сайжруулж, нээлттэй компани хэлбэр лүү шилжүүлэхгүйгээр танайх энэ авлигын төсөөллийн индексийг урагшлуулахад том ахиц үзүүлэхгүй гэж байгаа юм.

Гурав дахь асуудал бол мэдээж хэрэг бүх нийтийн хяналтыг эрх зүйн орчинг нь тодорхой болго гэдэг ийм гурван зүйл дээр илүү их төвлөрч бид нарт зөвлөмжүүд өгч байгаа.



Тэгэхээр бид Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд хэлэлцэх эсэх нь шийдэгдсэн явж байгаа. Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийг боловсруулах ажлын хэсэг Ц.Мөнхцэцэг гишүүнээр ахлуулаад ингээд ажлын хэсэг явж байгаа. Удахгүй энэ ондоо би өргөн барина гэж найдаж байгаа. Энэ хууль ингээд батлагдаад энэ гурван хуулийнх нь эрх зүйн орчинг бид бий болгоё. Ингэсэн тохиолдолд бид хоёр оронтой тооноос бүр илүү доошоо орох боломж нөхцөлүүд бүрдэнэ гэж үзэж байгаа.

Бид хэд хэдэн зөвлөхүүдтэй уулзаж зөвлөгөөнүүд аваад явж байгаа. Манайд одоо байгаа таны хэлж байгаа зөв. Тэр томоохон төсөл, хөтөлбөрүүдийн ард томоохон авлигын асуудал яригддаг. Одоо нэг банк, жишээлбэл Голомт банк хажуудаа компани байгуулаад л ямар ч тендергүй **OFF-TAKE**<sup>1</sup> нөхцөлөөр төмөр замын төслийг аваад л явж байгаа юм.

Тэгээд энэ төмөр замын төслийг авахдаа төртэй байгуулсан **OFF-TAKE** гэрээнийх нь нөхцөл нь нэг үнэтэй. Цаашаа зарж байгаа гэрээнийх нь үнэ бас өөр. Дахиад дараагийн төслөө авна гээд л явж байгаа юм.

Тэгэхээр банк бол банкныхаа л ажлыг хийх ёстой. Энэ асуудлуудыг бид шүгэл үлээх ёстой. Ийм учраас таны хэлж байгаа Төрийн болон албаны нууцын тухай хуульд бид өөрчлөлт оруулъя. Төрийн болон албаны нууцын тухай хуулиар аж ахуйн шинж чанартай төсөл, хөтөлбөрүүдийг огт төрийн болон албаны нууцад хамааруулахгүй байна гэдэг энэ зохицуулалтыг бид оруулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр ажлын хэсэг гараад Төрийн нарийн бичиг П.Сайнзориг даргаар ахлуулсан ийм ажлын хэсэг явж байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр энэ тухай ч хэлж байгаа.

Ц.Сандаг-Очир гишүүн. Бид яг нэг үеийн залуучууд. Нэг зүйлийг л ойлгоосой. Энэ матаас биш ээ. Бид энэ нийгмийн даатгал, татвар. Одоо юу байдаг юм. Гааль, Газрын алба. Энэ бүх салбар, дунд шатанд чинь тэр авлига гэдэг зүйл тасрахгүй байна. Үүнийг хууль хяналтын хэдхэн байгууллага дийлэхгүй байна. Олон нийтийн хяналтын доор үүнийг шийдье л гэж байгаа юм.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

**Ц.Сандаг-Очир:** Яах вэ, энэ хууль батлагдсанаар ингээд авлигын индексийн үзүүлэлт юмнууд сайжирна. Тэр холбогдох байгууллагаас өгсөн зөвлөмж юмнуудын хүрээнд дээшилнэ гэж байгаа бол. Үүнийг нэг их айхтар эсэргүүцсэн юм байхгүй шүү дээ. Тэгээд гол харин тэр асуудлаа. Тэр төрийн болон албаны нууцын тухай хуулийн энэ өөрчлөлт оруулж ирэх юм бол болж байна. Тийм. Бид бүхний үзээд байгаа, хараад байгаа, яриад байгаа бол энэ гол юман дээрээ хязгаарлачихаад ингээд.

Ер нь цаашдаа зүгээр энэ хууль батлагдсанаар сөрөг юмнууд гарах юм байна даа гэсэн зүгээр хувь хүний хувьд бодол байгаа шүү. Төрийн өндөр албан тушаал хаших хүн ер нь олдохгүй болох юм байна л гэж би харж байгаа юм. Төрийн өндөрсөөд байх юм байхгүй. Төрийн өмчийн компанитай. Компанийн удирдлага. Зүгээр байгууллага, аж ахуйн нэгж, хэлтэс, албадын дарга нар орон нутагт хийх хүн ер нь олдохгүй болох юм байна шүү.

Хэрэгтэй хэрэггүй гэдэг юм уу, үнэн худал нь тогтоогдохгүй энэ одоо ингээд л.../минут дуусав/

<sup>1</sup> Урьдчилан худалдах, худалдан авах гэрээ.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Одоо эрхэм гишүүн Норовын Алтанхуяг.

**Н.Алтанхуяг:** Энэ их чухал хууль орж ирж байгаа юм. Би энэ хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа.

Би энэ Засгийн газрыг хуулийн төслийг оруулж ирэх үү, үгүй юу гэдэг чинь хүсэл зоригийн асуудал байхгүй юу.

Тэгэхээр харин энэ Засгийн газар, Ерөнхий сайд нь, Хууль зүйн сайд нь энэ юман дээр ийм хүсэл зориг гаргаж байгаад би баярлаж байгаа юм.

Манай гишүүдийн ярьж байгаа мянган болгоомжлол байгаа юм. Матаасны хууль болчих вий дээ, тэгчих вий дээ, ингэчих вий дээ. Тэр зовлонгуудаас чинь энэ хүсэл зориг нь арай илүү дээр байгаад байгаа юм. Үүнийг нэг ийм юм оруулж ирэх хэрэгтэй байгаа юм.

Цагтаа би ч бас энэ шүгэл үлээнэ гэдэг юм уу, одоо та нарын хэлээр бол матаас гэдэг юм уу. Үүнийг чинь хонгил гээд бүгдийг нь гаргасан.

Тэгэхээр хүн ийм зовлон дундуур явж байж, хонгил дундуур явж байж, ийм юман дундуур явж байж л ойлгодог юм шиг байгаа юм.

Тэгэхээр Монголын нийгэмд хэрэгтэй. Одоо өнөөдөр үнэнээ хэлэхээс айдаг болчихсон шүү дээ. Хүмүүс. Намайг яачих бол, миний эхнэр, хүүхдийг яачих бол, хамаатан садныг минь яачих бол, бизнесийг минь яачих бол. Тэгээд бүгдээрээ яадаг вэ. Хар амиа хичээдэг болчихсон.

Тэгэхээр би Монголын нийгэмд хэн нэгэн хүнийг матах агуулгаар биш тогтолцоо чинь болохгүй байна. Энэ механизм чинь болохгүй байна. Үүнийг ингэж өөрчлөх нь зүйтэй. Энд одоо эд нар

нийлээд хууль хяналтын байгууллагынх нь улс төрчидтэй нийлээд ингээд идэж уугаад завааруулаад байна энэ тэр гэдгийг яагаад хэлж болохгүй юм. Маш их эрсдэлтэй алхам байхгүй юу.

Та нар болохоор зүгээр хажуу дахь хүнээ матах тухай бодоод байх шиг байна. Би бол нийгэмд болохгүй байгаа олон чухал асуудлаар Монголчууд хэнээс ч айхгүйгээр дуугардаг болгох хэрэгтэй.

Тэгэхдээ та нартай бас адилхан нэг юм хуваалцаж байгаа юм. Одоо Ц.Сандаг-Очир гишүүн болоод энэ Б.Энхбаяр гишүүн нар яриад байгаа юм. Энэ төрийн нууц, албаны нууц, байгууллагын нууц гэж ёстой нэг заваарсан хууль гаргачихсан.

Би одоо та нарт зүгээр амьдралын жишээ хэлье. Би Их Хурлын гишүүн болоод 2020 онд орж ирээд л Монголбанкнаас ингээд танай байшинг хэдээр боссон юм гэсэн чинь нууц гээд өгчихсөн. Нэг тоо өгчихсөн. Нууц. Би хэлж чаддаггүй. Ярихаар нөгөө нууц зөрчсөн гээд нөгөөдүүл чинь далим үсэргэчих байх гээд айгаад.

Одоо Х.Нямбаатар сайд сууж байна. Хууль зүйн яамны байшин хэд дээр боссон. Нууц. Татвараас нэг компанийн тухай мэдээлэл авсан чинь. Нууц. Үгүй ээ одоо нийгэмд шүгэл үлээх нь байтугай Улсын Их Хурал дээр юм ярихад боломжгүй болчихсон.

Тэгэхээр хэдүүлээ яах вэ, ингээд би хүсэл зориг бол сайхан байна. Сайн байна. Үүнийг дэмжиж байна. Тэгэхээр ийм ийм болгоомжлол байгаа юм шүү. Тэгэхээр үүнийг Та бүхэн маань одоо сая Х.Нямбаатар сайдын яриаг сонсож байхад тэр хуулийг өөрчилнэ гэж байгаа юм. Үүнийг өөрчлөхгүй болохоор хулгайн тендер зарлаад мөнгө идсэнийг нь нууцын тамга дарчихсан байгаа байхгүй юу. Ийм юм ёстой түм бум байна.

Та бол ингээд тэр олон улсын байгууллага бол авлигатай тэмцэхийн тулд гурван том зүйл хий гэж байна. Зөв. Би бол юу гэж хардаг юм гэхээр Монголын хууль шударга бус үйлчилдэг юм. Одоо тэнд нэг иргэдэд бол галзуу үйлчилнэ. Дээшлэх тусмаа энэ хууль үйлчлэхээ больдог. Ийм юманд л олон нийт дургүйцээд байгаа юм.

Тэгэхээр тэр доод талын хүмүүс гарч ирээд шүгэл үлээгээд болохгүй байна гээд хэлж байгааг нь 100 мянган төгрөгөөс 1.5 тэрбум төгрөг авна гэдэг бол тэр мөддөө байхгүй. Ядаж тэр хүнийг дарамтлахгүй, ядаж тэр хүнийг тэр үнэн үг хэлснийх нь төлөө зовоохгүй ийм л байгаасай гэж би ингэж хүсэж байгаа юм.

Тэгэхээр энэ хуулиа би алга болгох юм байна гэж ингэж ойлголоо. Ер нь хамгаалах хэрэгтэй. Дээр үед боломж байсан юм шиг байгаа юм.

Одоо энэ зах зээлд орсноос хойш мөнгөтэй хүн л бүх юмыг дийлдэг гэдэг нэг ийм болж байна шүү дээ. Одоо саяын тэр нэг хүүхэд дайрч байгаа асуудал дээр гарч ирж байгаа биз дээ. Мөнгөний хүчин тамир чадал, бяр ямар их болчихсон бэ гэдгээ харагдаж байна шүү дээ. Бүх юмыг худалдаж авна. Ийм шударга бус байгаа учраас ядаж Монголд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариулт сонсьё гэнэ. Хишгээгийн Нямбаатар. Түр байж байгаарай.

Зочид танилцуулаадахъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Ерөнхий боловсролын “Оюуны ундраа” сургуулийн ахлах ангийн багш, сурагчид Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт багш, сурагчид Та бүхнийхээ сурч боловсрох ариун үйлсэд өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг өөрөө тогтоно гэж байгаа.

Хишгээгийн Нямбаатар сайд асуултад хариулна.

**Х.Нямбаатар:** Н.Алтанхуяг гишүүний асуултад хариулъя.

Ер нь яах вэ, шүүхээр урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл энэ авлига, албан тушаалын гэмт хэрэг шүүхээр шийдэгдээд, урамшууллын хэмжээ хязгаарыг тогтоогоод шүүх эцэслэн шийдэгдсэний дараа урамшууллын асуудал шийдэгдэнэ гээд хууль дээр тусаж байгаа.

Хоёр дахь нэг асуудал бол гэрч, хохирогчийг бид ер нь энэ шүгэл үлээгчийг яг яаж хамгаалалтад авах вэ гэдэг асуудал яригдана. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар энэ асуудал зохицуулагдана. Тэр дотроо улс дотроо нүүлгэн шилжүүлж болно. Бүр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гадаад улс орон руу шүгэл үлээгчийг нүүлгэн шилжүүлэх замаар амь нас, аюулгүй байдал, гэр бүлийнхнийг нь хамгаалалтад авах ийм эрх зүйн орчныг бүрдүүлж өгч байгаа юм.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг бид түрүүн ярьсан.

Дээр нь нэмээд, ер нь ингээд төрийн албан тушаалтан энэ авлигажсан асуудал нийтийн албан тушаалд Нийтийн болон хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх энэ хуулийг зөрчсөн ийм үйлдэл, үйл ажиллагаа энэ төрийн нууцтай танилцах явцад илэрсэн тохиолдолд

түүнийгээ мэдээлсэн нь төрийн нууцыг задруулсан тооцогдохгүй гэж энэ хуулиар давхар хамгаалалт тогтоож өгч байгаа.

Цаашид ер нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийг бид ойрмогхон оруулж ирье. Тодорхой болгож өгье. Бүх зүйлийг тэр төрийн нууцад хамруулдаг. Жишээлбэл, яамны нэг байшин барихыг төрийн нууцад оруулаад байх ямар ч шаардлагагүй зүйл шүү дээ.

Бид гол нь энэ худалдан авах тухай хуулиасаа л тойрч хурдан хугацаанд барих, тендер сонгон шалгаруулалтаас болж дахин дахин шүүхдэж хөрөнгө оруулалтын ажил удаж гацдагаас шалтгаалж л ийм нэг жишиг тогтоод явчихсан.

Тийм учраас цаашид бид энэ худалдан авах хуулиа ч гэсэн параллельны оруулж ирээд уу худалдан авах хуулиар сонгон шалгаруулалт зарлах хугацааг богиносгох, гомдол маргааныг шийдэх хугацааг богиносгох энэ тэр олон зохицуулалтууд байгаа.

Бид нөгөө зовлонгийн шалтгаан маань юун дээр оршиж байна вэ гэвэл энэ албаны нууц, төрийн нууцад хамруулаад хурдан гэрээ байгуулаад худалдан авалт, хөрөнгө оруулалтын ажлыг тухайн жилд нь багтааж явуулах гэдэг энэ зовлонгоос л үүдэлтэй. Тэгээд сүүлдээ тэр маань төмөр зам барьсан ч төрийн болон албаны нууц болоод. Шороон далан босгосон ч төрийн болон албаны нууц болоод ингээд явчихсан ийм гажуудал байгаа. Үүнийг засаж залруулна гэдгийг хэлье.

Тэгээд бид энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн орчныг өнөөдөр хуульчилж өгснөөр олон нийт нөгөө Нийтийн мэдээллийн тухай хуулиар нийтэд ил тод болгох мэдээлэлтэй бүгд л танилцаж байгаа.

Одоо энэ зарим нийтэд мэдээлэл ил тод болгох үүргээ албан тушаалтнууд хэрэгжүүлэхгүй байгаа. Үүнийг Их Хурлын гишүүд эхнээсээ дуугараад эхэлчихсэн.

Бид 05 сарын 01-нээс өнөөдөр ингээд 10 сарын хэдэн бэ. 5 сар гарны хугацаанд нөгөө албан тушаалтнууд газрын, ашигт малтмалын, байгалийн тусгай хамгаалалтад газар олгосон бүхий л асуудлуудыг нийтэд ил тод болгох үүргээ хүлээх ёстой. Одоо ил болгочихсон байх ёстой. Энэ зүйлүүд дээр анализ хийгээд ингээд олон нийт.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Норовын Алтанхуяг гишүүн тодруулж асууя.

**Н.Алтанхуяг:** Би энэ хуулийн төслийг ингэж сэтгэл гаргаад зориглоод оруулаад ирсэнд би баярлаж байгаа юм. Дахиад хэлчихье.

Ер нь тэгээд **“Сануулж хэлэх хүн байхгүй бол сайн төр ч гэсэн ялзардаг.”** гэсэн эртний ийм үг байдаг.

Тэгэхээр ядаж зуун шударга Монгол хүн олдох байлгүй дээ. Тэгээд тэр зуун хүн үг хэлээд байхад энэ нийгэмд бас нэг нэмэр болох байх.

Тэгэхээр тэр хүмүүсийгээ хэлмэгдүүлчихгүй хамгаалчих, хамаатан садан, ах дүү нараар нь оролдоод байхгүй байхаар нэг иймэрхүү нэг тогтолцоо өгүүлэгдээд байх нь өгүүлэгдээд байсан юм. Зүгээр яг амьдрал дээр яах юм байгаа юм. Би мэдэхгүй байна.

Процесс удаан байна гэж манай гишүүд бас хэлдэг. Одоо түрүүн Б.Баярсайхан гишүүн. Энэ бас ер нь эд нар анхаарахгүй бол болохгүй байна.

Ц.Даваасүрэн гишүүн өнөө өглөө маш их том, одоо гайхалтай айхтар шүгэл үлээчихсэн гэж би харж байгаа.

Одоо Хөгжлийн банктэй холбоотой асуудлаар аймаар шүгэл үлээлээ шүү дээ. Үндсэн хуулийн цэцийн асуудлаар ч шүгэл үлээж байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг гишүүн.

**С.Чинзориг:** Энэ шүгэл үлээгчийн тухай хуультай холбоотой ганц нэг зүйл тодруулмаар байгаа юм. Жаахан. Зарим нэг нь эргэлзээ бол бас байгаад байгаа юм.

Яах вэ, энэ хуулийг харахаар яг тэр шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах ийм л хуулийн төсөл байна л даа.

Тэгэхээр одоо манай нийгэм чинь их л сонин л байна шүү дээ. Нэг хүн хэрэгт шалгагдлаа гэдэг юм уу, асуудал гарвал тэгээд л нийгмээрээ л урьдчилаад ер нь яллаад хаячхаж байна шүү дээ. Дахиж тэр хүнийг босгох, цагаатгах, нэр төрийг нь сэргээх ямар ч асуудал байхгүй болгоод хаячхаж байна шүү дээ.

Тэгэхээр ийм байдал нэлээн газар авчих вий дээ гэж би болгоомжлоод байгаа юм.

Энэ хуулийг чинь харахаар зөвхөн тэр шүгэл үлээгчийн л эрхийг хамгаалах, баталгаажуулахтай холбоотой байгаа болохоос биш цаана нь тэр шүгэл үлээлгүүлээд байгаа тэр байгууллага, иргэний эрхийг хамгаалах, хангах, нэр төрийг нь сэргээх ийм асуудал байхгүй байх юм уу? Тэгээд тийм шүгэл үлээлгүүлж байгаа тэр хүний эрхийг нь хамгаалах, нэр төрийг нь сэргээх ийм асуудал энэ хуульд ерөөсөө байхгүй байгаа юм л даа.

Аливаа юм чинь хоёр талын л харицаатай л асуудал үүснэ шүү дээ. Энэ чинь. Нэг нь шүгэл үлээгч болно. Нэг нь тэр шүгэл үлээлгүүлж байгаа хүн болно. Тэгээд ингээд нэг шүгэл үлээлээ гээд ярьдаг. Тэгээд тэр шүгэл үлээлгүүлсэн хүнийг чинь нийгмээрээ тэгээд ерөөсөө Монголд амьдрах аж төрөх ямар ч нүүргүй л. Урьдчилаад л манайхан чинь яллаад, газар гишгэх, хүний нүүр харах нүүргүй болгоод хаячихдаг шүү дээ.

Тэгээд тэр хүний эрхийг нь хамгаалдаггүй. Нэр төрийг нь сэргээдэггүй. Сэргээлээ ч гэсэн нэг сонины бүр дөрөвдүгээр нүүрний хамгийн доод буланд нь нэр төрийг нь сэргийлээ ч гэдэг юм уу. Үгүй бол уучлал хүсэж байна гээд жоохон юм тавьдаг.

Анх тэр хүн хэрэг хийчихсэн юм байна гэдэг ойлголтыг авсан хүн тэр нэр төрийг нь сэргээлээ, уучлал гуйлаа гэдэг мэдээллийг дахиж олж харж чаддаггүй юм шиг байгаа юм.

Тэгээд л ерөөсөө анх надад төрсөн мэдээлэл энэ нөхөр бол ер нь хэрэг хийчихсэн нь гарцаагүй болчихлоо доо гэсэн тэр санаа дохио нь тэр чигээрээ явчихдаг.

Тэгэхээр тэр шүгэл үлээлгүүлээд байгаа хүний эрхийг хамгаалах, нийт тэрийг нь сэргээхтэй холбоотой асуудал энэ хуулиар харилцааг нь зохицуулж болохгүй юм уу гэдэг нэг асуудал.

Манайхан шиг цөөхөн хүн амтай, тэр дотроо Монголчууд бие биеэ бараг бүгдээрээ таньдаг улсууд. Ийм цөөхөн хүн амтай оронд энэ харилцаа хэр үр дүнтэй болох болов уу гэж би болгоомжлох.

Хоёр дахь асуудал нь, энэ үйлчлэх хүрээг нь жаахан хязгаартай тогтоож болохгүй юу? Үүнийг харахаар нэлээн

нийтлэг л их өргөн хүрээгээр л хамаарахаар байх шиг байгаа юм.

Яг тодорхой асуудлаар. Үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн асуудал ч гэдэг юм уу. Ингээд хүрээг нь жаахан хязгаарлаж, хумьж өгч болохгүй юу?

Дөрөв дэх асуудал нь, шүгэл үлээнэ гэдэг чинь энэ хүний итгэл үнэмшилтэй холбоотой, ёс зүйтэй л холбоотой асуудал шүү дээ. Хүний итгэл үнэмшил, ёс зүйг бид тэгээд цаашдаа одоо ингээд үнэлээд урамшуулаад байх юм уу? Би ёс зүйг үнэлж болохгүй харилцаа бол энэ ёс зүй гэж ойлгодог.

Тэгээд ер нь одоо тэгээд бид ингээд шударга байгаа гээд энэ ёс зүйтэй байгаа хүнийг үнэлээд энэ чинь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хишгээгийн Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** Тийм. Энэ хуулийн өөрийнх нь үндсэн зорилго бол шүгэл үлээж байгаа хүний эрх зүйн байдлыг л тодорхой болгож өгч байгаа хуулийн төсөл.

Нөгөө талдаа манай улсын үндэсний эрх зүйн тогтолцоогоор тэр шүгэл үлээгдэж байгаа, шалгуулж байгаа, хэрэг түвэгт холбогдож шалгагдаж байгаа хүмүүсийн эрх зүйн байдлыг бусад хууль тогтоомжуудаар хамгаалалтыг нь тогтоож өгч байгаа.

Сэжиг сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих журмын хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль. Цаашлаад хүний эрхийн суурь Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь бүхий л конвенцуудад манай улс нэгдэж орсон.

Тэгээд бид энэ 11 сардаа нэг том хэлэлцүүлэг хийгээд. Яг саяын таны хэлж

байгаа тэр цахим орчинд урьдчилаад яллаад байгаа асуудлыг хуульчилж өгье. Сүүлийн үед үүнийг **social court** ч гэж яриад байгаа юм. Цахим орчинд шүүгээд байгаа, бусдыг яллаад шүүгээд байгаа энэ асуудлыг бид цахим орчинд Хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг энэ 11 сардаа багтаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр манай Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр том баг гарчихсан ажиллаж байна.

Мөн удахгүй фэйсбүүкийн толгой компаниас Америкаас хуулийн баг ирж манай хуулийн төсөл дээр хамтарч ажиллая. Тэгээд энэ ажлын хэсэг дуусахаар яг таны хэлсэн саяын нөгөө цахим орчинд хүний эрх хамгаалах хуулийн төслийг Их Хуралд өргөн мэдүүлье гэдэг ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм.

Тэгэхээр би таны хэлж байгаа өнцгийг ойлгоод байна. Энэ хууль бол зөвхөн Шүгэл үлээгчийн тэр өөрийнх нь эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль. Нөгөө талдаа тэр шүгэл үлээсний улмаас шалгагдаж байгаа хүмүүсийн эрх ашигтай холбоотой асуудал бол нэр төр, алдар хүндээ сэргээлгэх, гутаан доромжлуулахгүй байх энэ бүх эрхүүд нь эрүүгийн болон бусад хууль тогтоомжуудаар мөн хангагдсан гэдгийг л бид ойлгох ёстой.

Тэгээд одоо энд хэлсэн сая арваад гишүүд үг хэллээ. Бүгд л өөр өөрийн гэсэн байр суурийг илэрхийлж байгаа юм.

Тэгэхээр бид хууль тогтоогчид яг нийтлэг эрх ашгийг л хангаж хамгаалах ёстой. Бид авлигатайгаа нэг алхам тэмцэж урагшаа ахья гэвэл нийтээрээ шүгэл үүлэх ёстой.

Сая Н.Алтанхуяг гишүүн маш зөв зүйрлэл хэллээ шүү дээ. Энэ улс чинь ядаж зуун шударга хүн шүгэл үлээвэл энэ

байдал чинь дээрдээд л ирнэ гэж байгаа юм. Тэгээд мянга мянгаараа бид шүгэл үлээвэл тухайн салбар болгонд байдаг авлига, хүнд суртлын асуудал цэгцэрнэ л гэж ойлгож байгаа.

Тийм учраас үүнийг би бас эрхэм гишүүн С.Чинзориг гишүүнийг энэ хуулийн төслийг дэмжиж өгөхийг танаас хичээнгүй л хүсэж байна.

**Г.Занданшатар:** Зүйтэй. Ер нь энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай асуудал бол дэлхий нийтийн олон улсын чиг хандлага. Босоо хариуцлагын тогтолцоог төр хэрэгжүүлдэг. Хэвтээ хариуцлагын тогтолцоо гэж **horizontal accountability**<sub>[хэвтээ хариуцлага]</sub> гэдгийг иргэний нийгэм, иргэдийн оролцоотой хэрэгжүүлдэг.

Гэхдээ шүгэл үлээх гэдэг бол процесс болохоос биш ингээд үйл явдал, тодорхойлолт биш.

Тийм учраас Шүгэл үлээгчийн процессыг нь тодорхойлохгүй бол мэдээж энэ нөгөө хүний эрхийн асуудал. Аливаа хуулийн асуудал дандаа эерэг, сөрөг хандлага дээр тогтдог учраас гишүүдийн ч болгоомжлоод байгаа тэр процесс нь тодорхой байх. Тэгээд шүгэл үлээгч нь байгууллагын ажилтан байж болно, иргэний нийгэм байж болно, хувийн хэвшил дотор байж болно, төрийн албан дотроос байж болно. Тийм. Компаниуд, төрийн бус байгууллагууд хүртэл байна.

Тэр маань тэгэхдээ нөгөө процесс нь хуулийн хүрээнд явагдах. Хуулийн байгууллагууд дотроос хүртэл шүгэл үлээдэг. Төрийн байгууллагууд дотроосоо шүгэл үлээдэг. Шүгэл үлээгч бол нийгмийн анхаарлыг татах зорилготой л үйл ажиллагаа. Түүнээс биш шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг болж хувирч болохгүй. Нөлөөллийн ажиллагаа явуулах хэлбэр энэ тэр гээд их нарийн хуульчилж

зохицуулах, процессыг нь зохицуулахгүй бол бас нөгөө хүн ялладаг, шүүдэг шүүхэд нөлөөлж болохгүй буюу шүүн туслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, шүүх ажиллагаа явуулдаг тийм юм байж болохгүй гэж байгаа юм. Тийм нарийн тодорхойлолтуудтай учраас процессыг нарийвчлан заах хэрэг гарч магадгүй.

Хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа тэр процессыг нь нэлээн нарийн тодорхой болгох хэрэгтэй байгаа юм. Процессыг анхаарах хэрэгтэй.

Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн. Алга байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Үүнийг дэмжихдээ хамгийн гол нь шударга бус юмтай тэмцэж байгаа, яг үнэний дуу хоолой болж байгаа, олон нийтийн эрх ашгийн төлөө дуугарч байгаа. Энэ нь өөрөө нийгэмд тустай үйлсийн төлөө чиглэл хүлээж байгаа хүмүүсийг хамгаалах энэ асуудлыг бид хөндөж тавьж, энд хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх талаасаа чухал л даа.

Би нэг түүхийг маш сайн мэдэх юм. Сэтгүүлч Л.Болормаа гээд **“Өнөөдөр”** сонины маш мундаг тоймч байсан. Тэр хүн одоо энэ хүүхэд хамгаалах, хүний эрхийн төлөө маш чухал чухал баримтууд гаргаж ирээд тэмцэж байсан боловч хамгаалалтгүй, тэгээд эцэст нь үнэхээр хохироод үлдсэн л дээ тэр гэр бүл.

Тэгэхээр энэ үүднээс аваад үзвэл энэ бол маш чухал хууль байгаа. Харин өнөөдөр олон нийтийн сүлжээ, нийгмийн уур амьсгалыг ингээд харахад хөрс суурь бүрдсэн үү, үгүй юу гэдэг асуудал их чухал байна л даа.

Тийм учраас маш олон хүмүүс эргээд матаас, бие биеийгээ буруугаар яриад. Тэр нь өөрөө ажил хэрэг болоод явчихдаг ийм буруу зуршлыг нийгэм бий болгочих вий дээ гэсэн болгоомжлол нийгэмд маш их байна л даа.

Би өнөөдөр өглөө нэг зүйлийг сая хэлсэн. Юу гэхээр бүр энэ манай хүн амын, жишээлбэл Улаанбаатар хотын хүн амын 70 орчим хувь нь гэр хороололд амьдарч байна. Тэнд бизнес эрхэлж байгаа хүмүүс маань өөрсдөө шөнийн эрчим хүчний тарифын хөнгөлөлт бидэнд маш их нөлөө үзүүлдэг юм. Тэгтэл одоо Эрчим хүчний сайдын багцаас энэ санхүүжилт тусгагдаагүй ороод ирсэн байна. Үүнийг Та бүхэн маань ард иргэддээ хэлээд өгөөч ээ.

Тэр төсөв баталж байгаа хүмүүстээ Сангийн яамныхандаа тайлбарлаад өгөөч ээ гээд үүнийг хэлэхдээ энэ утааны асуудал ганц гэр бүлийн гэр хорооллын айл өрхүүдийн асуудал биш ээ. Энэ бол энэ бүх хүний асуудал болчихоод байна. Агаар, хөрсний бохирдол өнөөдөр эмнэлгүүдээр хүүхдүүд энэ амьсгалын замын өвчнөөс болоод ямар их болчхов. Энэ ганц хотын төв, тэр Зайсанд нь хүртэл энэ чинь асуудал болж байна шүү дээ гэдгийг хэлэхэд зүгээр Зайсангийн тухай ярьсан юм шиг л ингээд гуйвуулаад явчхаж байгаа байхгүй юу. Нэг, хоёр сөрөг хүмүүс.

Тэгэхээр ийм буруу зөрүү ойлголт нь өөрөө иймэрхүү хуулийн зохицуулалтаар буруу юм явчих вий дээ гэдэг болгоомжлолууд байна.

Нийгэм яг чухал асуудал руу нь хандах ёстой шүү дээ. Эртээд тэр автобусны тухай ярьж байхад бас яг бид парк шинэчлэлийн тухай л ярьж байгаа болохоос биш тэр автобусанд иргэд суух тэр орчныг нь сайжруулах тухай ярьж байхад бас нэг үг дээр гуйвчлаад л ингээд л

буруу ойлголт төрүүлэх гээд л явчхаж байна.

Өнөөдөр энэ утааны асуудал энэ гэр хорооллын айл өрхүүдийн ирж байгаа саналыг бид тусгах ёстой асуудал болохоос биш үүнийг тоглоом шоглоом болгоод сөрөг зохион байгуулалттай нөгөө хар Пи Ар-аар хүний нэр төрийг унагаах гэсэн зориулалт болгож ашиглах энэ тэр бол байж боломгүй зүйл байхгүй юу.

Тэгэхээр иймэрхүү зүйл дээр бид бас өнөөдөр хууль тогтоож байгаа хүмүүсийн хувьд бас энэ хуулийг оруулж ирж байгаа Хууль зүй, дотоодын хэргийн яам маань заалт бүр дээр анхаарах ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Би бас энэ Авлигатай тэмцэх газрын олон нийттэй харьцах асуудал хариуцсан чухал хүмүүс маань сууж байна. Эртээд П.Сайнзориг дарга чухал асуудал ярьсан шүү дээ. Өнөөдөр нийгэмд ёс зүй, ёс суртахууны талаар гэхэд л бас ингээд л бөөн асуудал үүсээд л. Үүнийг нь гуйвуулаад л ингээд явчихсан. Өөрөө ч үүнийг мэдэрч байгаа байх. Тийм ээ.

Тийм учраас бид энэ асуудлыг хэрвээ дэмжээд ингээд явчихвал нухацтай хандах ёстой. Иргэддээ, олон түмэндээ цаашдаа урт хугацаанд яах. Үнэхээр энэ шүгэл үлээгч гэдэг тэр үнэний дуу хоолой болсон хүмүүсээ хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх. Энэ нь өөрөө эргээд авлигатай тэмцэхэд. Улс орон зөв зам руугаа голдирол руу ороход үнэхээр эрх зүйн акт нь болж чадах үндсээр энэ хууль маань гарах учиртай гэсэн байр сууриа илэрхийлье гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Үг хэлсэн үү? Сандагийн Бямбацогт гишүүн. Нэрээ татлаа.



Цэндийн Мөнх-Оргил гишүүн нэрээ татлаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

**О.Цогтгэрэл:** Баярлалаа. Шүгэл үлээх, мэдээлэл гаргах тухай гээд энэ зарчмын хувьд ер нь их тийм зөв зүйтэй хууль орж ирж байна. Зарчмын хувьд.

Далд, нуугдмал хэлбэрт байгаа тэр болохгүй бүтэхгүй зүйлийг илчлэн гаргана гэдэг өөрөө маш чухал. Энэ нээлттэй нийгмийн үзэл санаатай маш ихээр нийцнэл гэж үзэж байгаа юм.

Зүгээр энэ дээр хэд хэдэн тодруулах болоод анхаарах хэд хэдэн зүйлүүд байгаад байгаа юм. Тэр шүгэл үлээгч гэж байгаа мэдээлэл гаргаж байгаа нөхөр заавал төрийн байгууллагад өөрийнхөө бүх мэдээллээ гаргах юм байна л даа. Заавал. Тэрийгээ яах вэ, ил далд гэж байна. Тэгэхдээ манай төрийн байгууллагууд төрийн албанд нууцыг хэрхэн яаж хадгалж хамгаалдаг билээ.

Тэгэхээр тэр хэвлэлийн эрх чөлөөний хууль дээр байгаа билүү? Байхгүй билүү? Эх сурвалжаа нууцлах гэдэг нэг заалт байгаа билүү? Байхгүй байлгүй?

Тэгэхээр тухайн шүгэл үлээх гэж байгаа, мэдээлэл илчлэх гэж байгаа иргэн өөрөө аль нэг хуульчдаа юм уу, аль эсвэл нэг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаад тэд нар нь мэдээллээ нууцлаад ингээд цаашаагаа явах энэ хуулийн зүйл заалт, боломжийг харин бүр илүү өргөтгөж өгөх ёстой юм биш үү.

Нэг гаалийн байгууллага дээр, татварын байгууллага дээр, шударга өрсөлдөөний газар дээр гээд л очоод би тэгж байна, ингэж байна. Бүх зүйлээ мэдээллээ өгөөд явах юм уу? Энэ дээр нэг тийм. Харин энэ хуулийн энэ үзэл санааг илүү өргөтгөх болоод илүү үр дүнтэй

болгох дээр энэ тал дээр ямар санаа бодол, байр сууриуд байж болох юм.

Тэр хууль чинь бараг миний бодлоор мэдээллийн эх сурвалжаа нууцлах гэдэг чинь хуульд байхгүй байх даа? Тийм ээ.

Хоёрдугаарт нь, тэр төрийн болоод албаны тухай нууц гээд зүйл яригдаад байна. Тэр дээр бас нэг хариулт.

Ер нь энэ хууль чинь өөрөө үүнтэй заавал холбоо хамааралтай болж байна. Тэр тусмаа тэр албаны тухай гэдэг заалт. Төрийг нь орхиё гэхэд албаны тухай гээд асар олон байгууллагууд нууцын тамга тэмдэг зарчихдаг. Тэгээд тэр нь өөрөө хуулиар хаалттай болоод явчихдаг. Энэ хуулийн үйлчлэх хүрээ, цар хүрээ чинь өөрөө хумигдах. Хоёрдугаарт нь.

Гуравдугаарт нь, тэр гаалийн байгууллага, шударга өрсөлдөөн гээд энэ байгууллагууд чинь хүмүүст процессын дагуу саяын гомдлыг хүлээж аваад тэрбум төгрөг хүртэлх шийтгэвэр болоод хохирлын урамшууллыг тооцож шийдээд. Тэрийг тэгээд төсөвт суулгаад явчих юм уу? Энэ чинь өөрөө дахиад Монгол Улсын тэр шүүн таслах эрх мэдэл, шүүх тогтолцоо руу чинь халдаж. Халдахаасаа гадна тийм өргөн хэмжээний эрх мэдэл энэ хуулиар олгогдоод энэ чинь амьдрал дээр хэрэгжих юм уу? Дахиад татварын байгууллага нэг мэдээллийн дагуу тэрбум төгрөг иргэнд урамшуулалд нь олгох нь л дээ. Энэ нь өөрөө тийм хууль эрх зүйн хувьд болоод бараг энэ Үндсэн хуулийн үзэл санаанд ч гэсэн хэрэгжих боломж боллоцоотой юу?

Тэгээд төгсгөлд нь гишүүд, бас их олон гишүүн. Би энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа гэдгээ хэлсэн. Зарим олон гишүүд ярьж байна л даа. Энэ чинь өөрөө нэг их тийм, бид нар зөв зүйтэй зүйлийг буруу хэрэгжүүлдэг, нугалаа

гүтгэлэг гарах. Жишээ нь, нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагдана гэдэг эрх байдаг. Энэ хуулийн ард нуугдаад буруу зөрүүгээр ашиглах боломж бололцоо ерөнхийдөө ихээр нээгдэнэ.

Тэгэхээр үүн дээр бас тодорхой хэмжээний хязгаарлалт болоод ёс зүй, сахилга хариуцлагын юу байж, яаж үүнээс нөгөө талаас нь сэргийлэх юм. Бас нэг хүний эрхийг нөгөө хүний эрхээр хязгаарлагдана. Энэ дээр дураараа зөрчиж болохгүй. Сайн хуулийг буруугаар ашиглах, үзэл санааг буруугаар ашиглагдах нөхцөл байдал үүсэх вий гэж. Эдгээр дээр нь хариулт өгөөч.

**Г.Занданшатар:** Пүрэвжавын Сайнзориг. Төрийн нарийн бичгийн дарга.

**П.Сайнзориг:** О.Цогтгэрэл гишүүн асуултад хариулъя.

Бас чухал санаануудыг хөндөж байна. Мэдээж тодорхой мэдээллийг ил тавьж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой болгох ямар процедурын дагуу гаргах вэ гэдэг асуудлыг хэд хэдэн хувилбартайгаар зохицуулалт оруулж өгсөн. Өөрөө болон төлөөний хүнээр гаргаж болох.

Хоёрдугаарт нь, нэр усаа нууцлах асуудал байгаа. Эргээд мэдээлэл гаргасан энэ асуудлаараа хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажиллах асуудлыг нээлттэй болгож өгч байгаа. Өөрөөр хэлэх юм хэвлэл мэдээллийн байгууллага үүнийг дамжуулж яг ямар этгээд үүнийг гаргаж тавьж байгаа вэ гэдгийг нууцлах, эх сурвалжаа нууцлах асуудал яг энэ дээр орж өгч байгаа.

Ер нь манайд өнөөдөр хэвлэл мэдээллийн салбар дахь асуудлууд байгаа. Гол асуудал юу вэ гэхээр редакцын хараат бус байдлаас гадна тодорхой эх сурвалжаа нууцлах асуудал манай мэргэжлийн

сэтгүүл зүйд байхгүй байгаа. Тодорхой хамгаалалт, эрх зүйн орчин байхгүй.

Тэгэхээр үүнтэйгээ холбоотойгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх юу гэдэг юм, хууль хяналтын байгууллагаас мэдээлэгчээ хэлэхийг шаардах. Энэ нь өөрөө эргээд тодорхой этгээдүүд хэлмэгдэх гэдэг юм уу, мэдээлэл гаргасныхаа дагуу нөгөө ажил, албан тушаал дээрээ шахагдах, хавчигдах, цалин хөлс нь буурах гэдэг ч юм уу ийм олон сөрөг үр дагаврууд гардаг.

Тэгэхээр бид хэд ч гэсэн бас Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийж байгаа.

Нэгдүгээрт, энэ хэвлэлийн эрх чөлөөний хуулийн энэ асуудал юу вэ гэхээр энэ редакцын хараат бус байдлыг бий болгоё.

Хоёрдугаарт, энэ ёс зүйн асуудалтай холбоотойгоор өөрийн удирдлагын байгууллагаараа шийддэг тэр хэвлэл мэдээллийн арбитр байдаг юм уу, хэвлэл мэдээллийн зөвлөлийг хуульчлан чиг үүргийг нь тодорхой болгож өгье ч гэдэг юм уу. Дээрээс нь эх сурвалжаа нууцлах асуудлыг оруулж өгч байгаа юм.

Тэгээд бас энэ хуулиудыг тодорхой хэмжээнд хэлэлцүүлгүүд явж байна. Бид нар бас сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьцаа эзэмшигч эздийн төлөөллүүдтэй уулзах ийм олон талын уулзалтууд хийгээд явж байгаа. Бас бололцоо байдаг бол ойрын хугацаанд үүнийг ойлголцож нэгдсэн санал, дүгнэлтэд хүрвэл Улсын Их Хуралд хэвлэлийн эрх чөлөөний хуулийг оруулж өгнө.

Бас энэ хууль байж энэ шүгэл хүлээгчийн асуудал илүү их дэмтэй, хэрэгжих байдал дээрээ чухал нөлөө үзүүлнэ гэдэгтэй таны санал нэг байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр явж байна. Түрүүн олон гишүүд үүнийг хөндөж байгаа.

Тэгээд Улсын Их Хурал хавар баталж өгсөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль болон цахим багц хуулиудтай уялдуулж энэ асуудлыг ойрын хугацаанд нэмэлт, өөрчлөлтийг оруулах үүргийг хүлээж байгаа. Энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хуультайгаа ч уялдуулж бас энэ асуудлыг шуурхайлах талаас нь анхааръя гэж бодож байна.

Хоёрдугаарт, татварын асуудал энэ шүгэл үлээх асуудал дээр орж ирээгүй.

Ер нь бусад орнуудад энэ татварын хяналт шалгалтыг төрийн байгууллага гэхээсээ илүүтэйгээр энэ нээлттэй татварын тайлан мэдээтэй танилцаж, тодорхой яг энэ чиглэлээр шүгэл хүлээдэг энэ мэргэжлийн этгээдүүд гарчихсан байдаг юм байна. Америкт үүгээр маш олон юу гэдэг юм иргэний нийгмийн байгууллагууд байдаг. Жилдээ 7.8 тэрбум төгрөгийг жишээ нь шүгэл үлээснийх нь төлөө буцааж урамшууллыг олгодог байх жишээтэй. Бүгд Найрамдах Солонгос Улсын үндэсний.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Тэр төрийн болоод албаны нууцын тухай хуулийн хэрэгжилт. Энэ албаны нууц гэдэгт одоо яг хэчнээн байгууллагууд, хэчнээн хэмжээний баримт материал албаны нууц гэдэгт орчихсон байдаг юм. Ер нь.

Хойшдоо хуулийн зүйл, заалт болоод энэ дээр түрүүн хууль өргөн барих гэж байгаа гээд л байна. Энэ дээр энэ тоог бууруулах гэх юм уу даа. Тийм зорилго,

зорилттойгоор хандлага явж байна уу? Одоо маш их хэмжээний мэдээлэл ингээд яригдаж байхад албаны нууц гэдэг дардас дарчихсан байдаг учраас болдоггүй. Тэгээд төрийн нууцад юу юу ч орчихдог гэнэ вэ.

Тэгэхээр энэ дээр ер нь тэр тооны тухай нэг мэдээлэл өгөөч.

Хоёрдугаарт нь, сая тэр мэдээлэл илчилж байгаа, шүгэл үлээж байгаа иргэдийг дөрвөөс таван байгууллага авч хүлээж авахаар харагдсан. Хууль дээр.

Тэгэхээр энэ мэдээллүүд хаанаа нэгтгэгдэх юм? Байгууллага, байгууллагуудаар ингээд яваад байх юм уу? Энэ ингээд нэгдсэн нэг ийм зохион байгуулалт, мэдээллийн сан, энэ дээр дүгнэлт шинжилгээ, олон зүйлүүд хаанаа хийгдэж явах юм?

**Г.Занданшатар:** Пүрэвжавын Сайнзориг.

**П.Сайнзориг:** Чухал асуудал байна.

Тэгээд ер нь мэдээж түрүүн татвар дээрээ нэмээд хэлэхэд Солонгос ч, Канад ч гэдэг юм уу маш олон ийм байгууллагууд татварын асуудлаа шүгэл үлээх асуудлыг илүү их нээлттэй болгож, тэр компаниудын нээлттэй тайлангуудтай танилцаж, үүнээсээ бас татвараас зайлсхийхсэн байна шүү дээ гэдэг зүйлийг нь гаргаж ирдэг. Эргээд татварын байгууллагатай хамтарч ажиллаад бас тодорхой хэмжээний ийм хамтын ажиллагаа өрнүүлдэг ийм зүйлүүд байна.

Дээрээс нь таны асууж байгаа чухал асуудал. Албаны нууц өнөөдөр маш өргөн хүрээтэй байна. Энэ тоог нь гаргах гэж бас хүндрэлтэй. Энэ өөрөө эргээд үндсэндээ байгууллага нь бараг өөрөө тогтоож байгаа учраас маш хүндрэлтэй байгаа.

Тэгэхээр бид хэд яг иргэд өөрөө мэдээлэлтэй байж байж зөв шийдвэр гаргана. Иргэд мэдээлэлтэй байж төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, төрийн үйл ажиллагаанд оролцоно.

Тэгэхээр энэ эрхийг хангахын тулд Үндсэн хуульд заасан мэдээлэл авах эрхийг хангах үүднээс бид хэд энэ дээр ямар цензурээр тогтоох юм бэ? Мэдээж энэ мэдээллийн аюулгүй байдал болон ер нь улс үндэстнийхээ мэдээж эрх ашгуудыг бодно. Энэ балансыг зохистой хэмжээнд оруулж ирнэ гэдэг зүйлийг танд хэлье.

Хоёрдугаарт, дундын мэдээллийн сан үүсгээд явна. Үүнийг Авлигатай тэмцэх газар дээр мэдээллийн сан бүрдүүлж явна. Энэ тайлан мэдээнүүдээ хүний эрх талаас нь ер нь авсан арга хэмжээ болон бүх зүйлүүдээ жил бүр Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мэдээллээ ирүүлж байх ийм зохицуулалтаар энэ зохицуулалтуудыг тусгасан байгаа гэдэг зүйлийг танд хэлье.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

**Б.Энхбаяр:** Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэлэлцэхийг нь дэмжиж байгаа.

Тэгэхдээ яг энэ агуулгаар нь дэмжихгүй байгаа. Хэрвээ хэлэлцэх эсэхийг нь дэмжээд яг цаашаа явлаа гэхэд энэ олон гишүүд бас санаа зовниж үг хэлж байна.

Миний хувьд Байнгын хороон дээр хоёр асуудлыг хэн тавьсан.

Нэгдүгээрт, энэ татварынхны талаар шүгэл үлээж болохгүй гэдэг заалтыг хасаж татварынхны талаар харин шүүхэд хүлээх ёстой. Ард иргэд. Ямар татварын байцаагч акт тавьж, дарамталж, авлига авч байгаа

талаар яагаад татварынхан хэнд ч мэдүүлэхгүй тэндээ юм яриад байдаг юм.

Тэгээд энэ Зөрчлийн хуулийн хяналтаас бас одоо энэ Х.Нямбаатар сайд уг нь оруулаад баталсан чинь Сангийн сайд энэ татварынхыг нь хасаж байдаг. Тэгээд энэ асуудлыг шийдэх ёстой. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ гэж Хууль зүйн сайдаас нэгдүгээрт асууж байгаа юм.

Хоёрдугаарх асуудал нь, энэ нууц гэдгээр халхавчилж. Гол асуудал бол ер нь улсын нууц дээр байгаад байгаа юм. Албаны нууц. Ил байгаа мэдээлэл дээр шүгэл үлээнэ гэж. Тэр дотроо мөнгө өгнө гэдэг энэ зарчим бол би бол явахгүй байх гэж бодож байна.

Одоо энэ сургаар манай зарим сайтынхан би их мөнгөтэй болох юм байна, хэдэн төгрөгтэй болох юм байна гээд тоо тавьчихсан байна лээ.

Энэ бол худлаа шүү. Та нар тийм юм авахгүй. Ил байгаа гарчихсан мэдээллийг сайт дээрээ тавиад тэгээд мөнгөө авна гэж ийм логик байж таарахгүй.

Ард иргэд ямар байдлаар энэ шүгэл үлээгээд байна вэ гэхээр зүрх сэтгэлээрээ улс орныхоо энэ аюулгүй байдал, энэ идэж ууж байгаа юмтай тэмцэх гэсэн тэр сэтгэл зүрхээрээ шүгэл үлээх. Энэ нь бол шүгэл үлээгч. Түүнээс биш мөнгө бодож, мөнгө авах зорилгоор янз бүрийн хүн амьтны тухай бичиж байгаа бол энэ шантаажчин. Шүгэл үлээгч биш. Шантаажчин. Шантаажилж байгаа авлигачнаасаа ер дээрдэх юм байхгүй. Ер дээрдэх юм байхгүй. Авлигачнаасаа илүү. Нөгөө авлигыг нь давсан мөнгөнөөс нь хэдэн төгрөг хуваалцах гэж шантаажилж байгаа учраас энэ бол авлигачин гэсэн үг. Өөрөө.

Тийм учраас үүний зааг ялгааг гаргаж, тэр мөнгө өгдөг юмыг нэлээн учир начиртай хийх ёстой.

Гуравдугаарх асуудал. Энэ бол улсын нууц дээр. Одоо жишээлбэл дэлхийд хамгийн том шүгэл үлээгчид бол **Жулиан Ассанж** байна, **Эдуард Сноуден** байна. Энэ бол шүгэл үлээгчид гэж байгаа.

Тэгэхдээ энэ хүмүүс тухайн улс орныхоо хувьд эх орноосоо урвагчид, нууц мэдээллийг задлагчид байгаа.

Тэгэхээр Б.Энх-Амгалан гишүүн түрүүн хөндөж байна лээ. Энэ үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс улсын нууцтай харьцаж байгаа энэ албан тушаалтнууд хэрвээ ингээд нууц мэдээллээр шүгэл үлээж болно гээд ерөнхий тавьчихвал энэ чинь төрийн хар хайрцгийн бодлого бас алдагдах нягуур байгаад байгаа юм.

Тийм учраас ямар асуудал дээр жишээлбэл улсын нууц болон албаны нууцтай харьцаж байгаа этгээд шүгэл үлээх вэ, тэрийг хамгаалах вэ гэдгийг тодорхой болгох ёстой.

Англид бол ийм кэйс боссон. Тони Блэйрийн Засгийн газрын үед. Тони Блэйр Английн татвар төлөгчид болон цэрэг эрсийг Ирак руу дайнд явуулахдаа “**Эм Ай-5**” /Military Intelligence, Section 5<sup>2</sup>/ буюу тагнуулын байгууллагад химийн зэвсэг Иракт байхгүй гээд мэдээлээд байхад чинь дайн руу оруулсан. Үүнийг тэр тагнуул илчилсэн. Ерөнхий сайд худлаа.../минут дуусав/

---

<sup>2</sup> **MI5** (Цэргийн тагнуул, 5-р хэсэг) гэдэг нь Нэгдсэн Вант Улсын дотоодын сөрөг тагнуул, аюулгүй байдлын агентлаг бөгөөд Нууц Тагнуулын алба (MI6), Засгийн газрын Харилцаа холбооны төв байртай хамт тагнуулын механизмын нэг хэсэг болдог.

**Г.Занданшатар:** Хишгээгийн Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Энэ анх хуулийн төслийг боловсруулахдаа бид энэ санхүүгийн салбарын шүгэл үлээлтийг уг нь оруулж төслөө бичсэн юм.

Тэгээд нөгөө яамдаас санал авах явцад Сангийн яамнаас энэ татварын асуудалтай холбоотой шүгэл үлээлтийг энэ хуулийн үйлчлэлд хамруулахгүй гэдэг санал ирүүлсэн. Тэгээд энэ нь тусгагдаад өнөөдөр ингээд өргөн баригдаад явж байна.

Би дахиад хэлье. Энэ анхдагч хуулийн төсөл. Яг тань шиг хүн энэ хуулийн төслийг би ахлаасай гэж бодож байгаа. Хэлэлцэх эсэх нь шийдэгдсэн тохиолдолд. Тэгж байж бид шүгэл үлээгчдийн энэ эрх зүйн байдлыг хамгаалж, энэ хуулийг хүчин төгөлдөр хурдан үйлчлүүлж байж бид үр хүүхдүүддээ илүү авлигагүй нийгмийг, хүнд сурталгүй нийгмийг, илүү хууль үйлчилдэг нийгмийг бий болгохын төлөөх хамгийн том тогтолцооны өөрчлөлт юм.

Б.Энхбаяр гишүүн энэ дээр би ерөөсөө яг ийм одоо өнөөдрийн төрж байгаа сэтгэгдлээр таныг энэ хуулийг ахлаасай гэж хэлээгүй. Та бид хоёр бас олон жил бие биеийгээ мэднэ. Нэг л зүйлийн төлөө зорилго чиглэлтэй явдаг. Зарим зүйл дээр зөрж барьдаг. Гэхдээ та бид хоёр яг огтлолцдог сэдэв бол яг л энэ шүгэл үлээх харилцааг өнөөдөр бүх нийтийн хяналт болгож хэвшүүлэх л энэ зүйл.

Бид төрийн болон орон нутгийн өмчит компанийнхаа хуулийн харилцааг хуульчилъя гэж байна. Засаглалаа сайжруулъя гэж байна. Улс төрийн

намынхаа хуулийн санхүүжилтийг нь ил тод болгоё гэж байна. Тэгвэл нөгөө талдаа бид олон нийтийн хяналтыг бий болгож байж. Энэ гурван зүйл яг цогцоороо хэрэгжиж байж өнөөдөр энэ авлига, албан тушаал өнөөдөр Трансперенсигийн 111 дүгээр байранд байгаа гэдэг зүйлүүд бүгд ард үлдэж, бид илүү урагшаа ахих ёстой.

Тийм учраас өнөөдөр энэ хуулийн хэлэлцэх хэсгийг би нийт гишүүдийг дэмжиж өгөөсэй гэж чин сэтгэлээсээ дахин дахин өсөж байна.

Хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа Хууль зүйн байнгын хороон дээр би Б.Энхбаяр гишүүнийг энэ хуулийн төслийг ахлаасай гэж бодож байна.

Тэгээд болдог бол бид энэ хуулийн төслийг маш богино хугацаанд хэлэлцүүлэгт бэлдээд батлуулмаар байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Би асуултаа гүйцээж асууя.

Сүүлийн хоёр кэйсийг би зүгээр зориуд хэлье гэж үзэж байна.

Нэгдүгээрт нь, сая хэлсэн тэр Английн Засгийн газрыг Иракт химийн зэвсэгтэй байгаа гэдэг худал мэдээллээр. Тагнуулын байгууллагад бол Иракт химийн зэвсэг байхгүй гэдэг мэдээлэл байсан.

Тэгээд английн тагнуулын байгууллагын дүн шинжилгээний газрын тэр эмэгтэй мэргэжилтэн бол шүгэл үлээсэн. Ерөнхий сайд нь тагнуул нь байхгүй гээд байхад байгаа гэж худлаа ярьж дайнд оролцсон гэж.

Тэгээд улсын нууц задалсан гээд Английн шүүхээр ороод тэр эмэгтэйг цагаатгасан байгаа юм. Яагаад гэхээр энэ бол Английн ард түмний эрх ашгийн зорилгоор бодож улсын нууц задалсан учраас энд ял шийтгэл оногдуулахгүй гэдэг ийм шийдвэрийг Английн шүүх гаргаж байсан юм.

Тэгэхээр энэ нюансуудыг сайн хуулийн төсөл дээр шигтгэх шаардлагатай байгаа.

**Г.Занданшатар:** Үг хэлчихлээ. 81. Л.Төр-Од хариулъя.

**Л.Төр-Од:** Б.Энхбаяр гишүүний асуулт, тодруулгад нэмэлт хариулт өгье.

**“Трансперенси интернэшнл-Монгол”** төрийн бус байгууллагын тэргүүн Л.Төр-Од.

Түрүүн Х.Нямбаатар сайд дурдсан. Гурван үндсэн асуудал байгаа. Үүний нэг нь энэ олон нийтийн хяналт, оролцоог энэ авлигал, албан тушаал, ашиг сонирхлын зөрчилдөөнтэй зөрчил, гэмт үйлдэл, эс үйлдэлд хуульчлах асуудал, эрх зүйн орчны асуудал.

Тэгээд үүн дээр би хэдэн зүйл хэлье.

Арван жилийн өмнө “Трансперенси интернэшнл” байгууллагаас бид арваад олон улсын байгууллага, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигалын эсрэг конвенцод нэгдсэн улс орнуудын сайн жишиг стандартуудыг нэгтгээд 30 ийм зөвлөмж гаргасан байгаа. Үүнд саяын энэ агуулгын талаар Б.Энхбаяр гишүүн хэллээ.

Энэ дээр бид гурван төрлийн өөрчлөлтийг энэ төсөл дээр заавал оруулж өгөөч ээ гэж санал гаргасан байгаа.

Нэгдүгээрт, энэ үйлчлэлийг хязгаарлахгүй байх. Тийм ээ. Өөрөөр хэлбэл өмнө нь зөвхөн олон улсад төдийгүй манай бүс нутагт. Жишээлбэл, Өмнөд Солонгос ч гэсэн зөвхөн авлига, албан тушаалын гэмт хэргийг шүгэл үлээсэн асуудал гэж авч үзэж байсан бол хэрэгжүүлэх явцдаа ер нь энэ нийтийн ашиг сонирхлын төлөө бүх салбарт энэ шүгэл үлээх явдал, өөрөөр хэлбэл мэдээлэл өгөх, авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэл өгөх асуудлыг хөхиүлэн дэмжсэн.

Хоёрдугаарт, хувийн хэвшилд ч гэсэн авлигал байдаг. Үүнийг зохицуулах ёстой.

Гуравдугаарт, хэрвээ эрх бүхий байгууллага нь. Тухайлбал, АТГ тэр мэдээллийг хүлээж аваагүй дарсан тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагад мэдээлэх энэ сувгийг бас нээж өгөөч өгөөч ээ гэсэн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Б.Энхбаяр гишүүний ярьж байгаад их олон нюанс байгаа шүү. Бас. Олон хуулийн зөрчил, хүний эрхийн асуудлаа ч гэсэн бодолцоод энэ процессыг нь л их сайн анхаарахгүй бол. Аливаа юм чинь яг процесс дотроо л их сайн. Процессын хуулиар л зохицуулахгүй бол.

Шүгэл үлээж олны анхаарлыг татаж, тэр ялзрал, болохгүй байгаа юмыг дэлгэх асуудал нэг хэрэг. Тэр зарчимдаа л нийцүүлэх л гол асуудал байгаа шүү дээ. Тийм ээ.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

**Ж.Чинбүрэн:** Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 сард өргөн мэдүүлсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн

байдлын тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байна.

Нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсвэл хохироож болзошгүй үйлдэл, эс үйлдэхүй, нөхцөл байдал зэргийг мэдээлж шүгэл үлээж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлж байгаагаараа онцлогтой гэж үзэж байна.

Гурван асуулт байна. Шүгэл хүлээгчийг хэрхэн бодитой хамгаалах талаар салбар хуулиудад тусгалаа олж байгаа вэ? Жишээ нь, шүгэл үлээгч болсных нь төлөө ажил, албан тушаалаас нь шахан зайлуулах, дарамтлах, шагнал урамшууллыг нь бууруулах зэрэг асуудлууд бодитой бий болно. Энэ зөрчлийг бий болгосон дээд шатны албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг хэрхэн зохицуулж байгаа вэ? Энэ хуульдаа.

Хоёрт. Шүгэл үлээгчийн нууцыг хэрхэн хамгаалж байгаа вэ?

Гуравт. Шүгэл үлээгчид ямар урамшууллыг хаанаас олох гэсэн асуултуудад тодорхой хариулт авахыг хүсэж байна.

**Г.Занданшатар:** Ажлын хэсэг. Пүрэвжавын Сайнзориг. Төрийн нарийн бичгийн дарга.

**П.Сайнзориг:** Мэдээж энэ бодитой. Бид хэд анхаарч тал талыг нь л чимхэж, илүү дутуу зүйлгүйгээр аливаа этгээдийг хэлмэгдүүлэхгүй. Тэгэхдээ хууль бус зүйлийг хамгаалахгүй ийм л хууль гараасай гэж хүсэж байгаа.

Тэгээд ер нь хамгаалалтын асуудлыг зөвхөн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хуулиар харж болохгүй. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хууль дээр шүгэл үлээсэнтэй нь холбогдуулж албан тушаалыг нь бууруулах, албан тушаал дэвшүүлэхийг нь хязгаарлах,

сахилгын шийтгэл оногдуулах гэдэг юм уу ажлаас халах, ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотой шаардах ч гэдэг юм уу энэ зүй бус харилцаануудыг үндсэндээ хөдөлмөрийн эрх зүй талаас нь хамгаалж өгч байна.

Аж ахуйн нэгжүүд үлээсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл ч байдаг юм уу, тэрийг нь цуцлах, янз бүрийн байдлаар төрийн хяналт шалгалт оруулж дарамтлах ч гэдэг юм уу энэ зүйлүүдээс бас хориглож өгч байгаа.

Нөгөөтэйгүүр яг хүн байх юм бол Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль дээр заасан хамгаалалтын арга хэмжээнүүдийг хэрэглэх бүрэн боломжтой байж байгаа. Гэрч, хохирогчийг хамгаалах хууль дээр маш олон төрлийн хамгаалалтын арга хэмжээ байдаг. Урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг нь хязгаарлах. Биечилсэн хамгаалалт буюу хүн дагуулж яг биечилж хамгаалж өгөх, мэдээллийн нууцыг нь хангах, нэг бүрийн тусгай хэрэгслээр хангаж өгөх, аюулгүй газар түр байрлуулах, эсвэл нүүлгэн шилжүүлэх буюу улс дотроо болон гадаад улс руу нүүлгэн шилжүүлэх асуудал байдаг. Баримт бичгийг нь, тодорхой мэдээллийг нь сольж олгох асуудал байдаг. Гадаад төрхийг өөрчлөх зэрэг маш олон юу гэдэг юм тухайн тэр шүгэл үлээсэн нөхцөл байдал болон хамгаалалтын зэрэглэл, эрсдэлээс нь шалтгаалж бас энэ олон арга хэмжээнүүдийг гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх явцад хэрэгжүүлэх бүрэн боломжтой байхаар оруулж өгсөн байж байгаа.

Дээрээс нь нууцлалын асуудал байгаа. Нууцлалын асуудал дээр дундын мэдээллийн сан үүсгэж явна. АТГ дээр нууцлалыг илүү их хангах. Энэ байгууллагын энэ үйл ажиллагаанд нь хяналт тавих чиглэлийн прокурорын байгууллага болон Хүний эрхийн Үндэсний Комиссын төлөөлөл бас энэ

дундын мэдээллийн санд хяналт тавих бололцоо бүрдэж байгаа.

Хоёрдугаарт, энэ тайлан мэдээллийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, ялангуяа Хүний эрхийн хороонд хүргүүлдэг байх энэ асуудал бас орж байгаа.

Тэгэхээр бид цаашдаа аливаа шүгэл үлээснийхээ төлөө энэ нууцлалын асуудал алдагдаж эргээд эрсдэлд ордог энэ зүйлийг хязгаарлаж байгаа. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагад ч гэсэн энэ зүйлийг нь дэмжиж оролцсон тохиолдолд эх сурвалжаа нууцлах асуудлыг тусгаж өгсөн гэдэг зүйлийг хэлье.

Урамшууллын асуудал байгаа. Урамшуулал дээр шууд юу юугүй мөнгө өгөх гээд байгаа зүйл ерөөсөө байхгүй. Тухайн тэр мэдээллийг шалган шийдвэрлээд Авлигын эсрэг хуулийн 33.2-т заасны дагуу улсад хохирол учруулсан этгээдийн эд хөрөнгийг хуваасан бол. Дээрээс нь хуульд заасны дагуу зохих торгох ял, торгох шийтгэл оногдуулаад, энэ нь бас улсад орсны дараа тухайн мэдээлэл гаргасан этгээд маань хүсэлт гаргавал энэ урамшууллыг олгогдох зөвлөл хуралдаад улсад орсон тэр хууль бус.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, Төмөрбаатарын Аюурсайхан, Жамьянхорлоогийн Сүхбаатар нарын урилгаар Чингэлтэй дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, сувилагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ эмч, сувилагч нартаа хүн ардынхаа эрүүл мэндийг хамгаалах ариун үйлсэд нь хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе. Эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/



Одоо Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууна.

**Х.Булгантуяа:** Авлигатай тэмцэх энэ том ажлын нэг хэсэг болгож Шүгэл үлээгчийн тухай хуулийг оруулж байгаад дэмжиж байгаа.

Гэхдээ би энэ Олон улсын хуульчдын ассоциацийн тайлангаас энэ Шүгэл үлээгчийн хууль ер нь авлигалыг бууруулахад, шүгэл үлээгчийг хамгаалахад хэр үр дүнтэй байдаг юм бэ гэдэг 2021 оны тайланг уншсан юм.

Тэгээд энэ дээр ингэж байна. Одоо Олон улсын авлигатай тэмцэх конвенцод нэгдсэн 140 орноос 59 орон шүгэл үлээх хуультай. Тэгээд эдгээр орнууд нь ихэнхдээ л Европын, Америк, Англи гээд эдгээр улсууд байна.

Хамгийн олон шүгэл үлээх, хамгийн олон гомдол гаргадаг, шүүхэд ханддаг ийм улс бол Англи, Америк хоёр байдаг юм байна. Гэхдээ үнэнийг хэлэхэд шүгэл үлээгчийн нь талд шийдвэрлэгдсэн нь маш бага байдаг юм байна. Англид гэхэд жилд 224 гомдол гаргалаа, шүүхэд очлоо гэхэд түүнээс 31 нь л шийдэгддэг юм байна. 13.8 хувьтай. Японд 4.5 хувьтай.

Тэгээд би зүгээр юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр үүнээс гадна дээрээс нь нэмээд энэ шүгэл үлээгчигийг хамгаалах асуудал эдгээр улс орнуудад хүртэл их дутмаг байдаг.

Тийм учраас шүгэл үлээлээ гэхэд түрүүний хэлээд байгаа нэр төрөө, өмч хөрөнгөө. Дээрээс нь нэмээд өөрийнх нь эсрэг ахиад нэр төрийг нь гутаасан гэж шүүхэд ханддаггүй байх. Тэр битгий хэл зарим хүмүүсийнх нь эсрэг эрүүгийн хэрэг үүсгэдэг гэж байгаа юм.

Тэгэхээр үүнийг хамгаалах явдал эдгээр хөгжчихсөн улс орнуудад хүртэл тодорхойгүй байна. Хуулиуд дээрээ тодорхойгүй байна. Хамгаалагдаж чадахгүй байна гэж ярьдаг юм байна.

Тэгэхээр би Монголд нэг хууль гаргаад энэ нь хамгаалагдах болов уу даа гэдэг дээр нэгдүгээрт үнэхээр эргэлзэж байна. Эргэлзэж байна. Монгол чинь одоо ямар бие биеийгээ танихгүй биш. Нэг банкны салбарын ажилтан жишээлбэл манай банкны захирлууд ингэж төрийн мөнгийг идэж ууж байна ч гэдэг юм уу, хууль зөрчиж байна гэхэд дараа нь тэр хүнийг банкны салбарт хэн ч ажилд авахгүй байх.

Төрийн байгууллагад нэг ажил хийж байсан хүн жишээлбэл бас ингээд л дарга, цэргийнхээ эсрэг ч байдаг юм уу шүгэл үлээлээ гэхэд дараа нь тэр хүн хаана ч очоод ажилд орохын аргагүй болтол дарамталдаг ийм эрх зүйн орчин үүсчих юм биш биз дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ бол ингээд эцсийн эцэст явсаар байгаад л шүүхийн байгууллага дээр очих юм билээ.

Тэгэхээр шүүгчид маань шударга байж чадаж байгаа юу? Би түүн дээр бүр Трансперенси Интернэшнлээс бүр тусгайлан асуумаар байна.

Ер нь Монгол Улс энэ авлигын индексээр ийм тааруухан байгаа дээр шүгэл үлээгч гэдэг хүн байхгүй болоод байгаа учраас манайх ингээд байгаа юм уу? Эсвэл өөр ямар үзүүлэлтүүдээр Монголыг ингэж дүгнээд байгаа юм бэ?

Олон нийтээс нэг санал асуулга авдаг гэж байгаа юм. Би тэгж л уншсан. Би нэлээн судлах гэж үзсэн.

Тэгээд энэ хуулийг баталчихвал манайх авлигын индексээрээ хэдэн анги

оноо аваад яаж урагшлах юм бэ? Ингээд энэ батлагдлаа гэхэд Та бүхэн үүнийг дагаж өөр ямар хуулиуд, ямар эрх зүйн орчинг бид бий болгох ёстой гэж үзэж байгаа юм бэ?

Дээрээс нь сүүлийн он жилүүдэд ер нь төрийн нууц нь нэмэгдээд л, хувь хүний нууц хасагдаж л эхэлсэн. Хувь хүний нууц гэж ерөөсөө байхаа байсан. Сошиалаар дүүрэн эхнэр хүүхэд, үр хүүхэд. Бодвол саяын энэ хүн хүүхэд мөргөсөн. Баахан машин мөргөсөн гэсэн эмэгтэй бодвол үүнийг санаатайгаар л лав хийгээгүй байх. Гэхдээ тэр хүний зураг хөргийг сошиалаар нэг явуулаад ингээд түрүүлээд шүүчихдэг. Тэр хувь хүний. Бараг тун удахгүй ээж нь, аав нь хэн бэ гээд аягүй ингээд явах байх.

Тэгэхээр энэ хувь хүний нууц энэ тэр гэдэг энэ асуудал байхгүй байгаа цагт энэ шүтэл үлээх хууль чинь ингэж хүчтэйгээр орж ирэх нь бас зөв юм уу? Нөгөө шүтэл үлээсэн хүнээ ахиад сошиалаар нэг бид барьж аваад шүүчих юм биш биз дээ. Өө.., нөгөө сая шүтэл үлээсэн хүн чинь энэ юм байна. Эцэг, эх нь энэ юм байна гээд ингээд. Тэгэх юм бол ганцхан шүтэл үлээсэн хүний асуудал битгий хэл дээрээс нь нөгөө шүтэл үлээлгэсэн хүмүүсийн гэр бүл, эцэг эх, ойр дотны бүх хүмүүс нь хамтдаа хохирчих юм биш биз дээ? Үүн дээр энэ Трансперенси интернэшнл, Хууль зүй, дотоод хэргийн яамныхан юу гэж үзэж.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Ажлын хэсэг хариулъя.

**Л.Төр-Од:** Х.Булгантуяа гишүүний асуултад хариулж тодруулга өгье.

Трансперенси Интернэшнл байгууллагаас ерөнхийдөө гурван төрлийн судалгаа индекс гаргаж байгаа. Нэг нь, бидний хамгийн сайн мэддэг **Corruption Perceptions Index** буюу Авлигын

төсөөллийн буюу түвшний индекс жил бүр гаргадаг.

Мөн 2-оос 3 жил бүр **Global Corruption Barometer** буюу авлигын барометр судалгаа гаргадаг. Энд олон нийтийн иргэдийн саналыг авдаг.

Мөн гурав дахь нь авлига өгөгч нарын **Bribe Payers Index** гэж гаргаж байгаа. Ялангуяа хөгжингүй орнуудад.

Авлигалын төсөөллийн буюу түвшний индексийг бид нийтдээ 16 хүртэл эх сурвалжаас. Тийм ээ. Дэлхийн банк. Юу гэдэг юм, **Economist** сэтгүүл. Тийм ээ. **Rule of Law** буюу нөгөө хуулийн засаглалын индекс төсөл зэргээс нэгтгэж гаргадгаараа онцлогтой.

Тэгээд түрүүн дурдаж байна. Ямар асуудал энэ дээр чухал вэ. Түрүүн Х.Нямбаатар сайд үндсэн гурван асуудлыг дурдчихсан байгаа. Ялангуяа бид төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудад. Зөвхөн албаны гэхгүй байгууллагын нууц гэдэг байдлаар төрийн болон орон нутгийн өмчийг шамшигдуулдаг, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэж авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчил гаргадаг хэргүүд түгээмэл байгаа.

Мөн Х.Булгантуяа гишүүн дурдаж байна. Ялангуяа энэ шүүгч, прокурорын байгууллага. Тийм ээ. Өөрөөр хэлбэл шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудад эргээд дотор нь энэ авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчилдөөнтэй асуудлууд байна.

Бид тийм ч учраас 2019 онд Авлигатай тэмцэх газарт нийт үйл ажиллагаанд нь хөндлөнгийн анхны үнэлгээг хийж өгсөн.

Энэ үнэлгээнд манай судлаачид ямар дүгнэлт гаргасан гэвэл нэгдүгээрт энэ

шүүх, прокурор, өмгөөлөгч, хуульч нарыг эргээд өөрсдөө өндөр ёс зүйтэй. Энэ авлига, албан тушаалын хэргээр мэргэшүүлсэн дагнуулах шаардлагатай байна. Шаардлагатай бол нийт шүүгч, прокурорыг дахин сонгон шалгаруулалтад оруулж үнэхээр шударга, энэ чиглэлээрээ мэргэшээд явах ийм төрийн албан хаагчдыг бэлтгэх талаар онцгой анхаараач гэж бид зөвлөмждөө гаргасан байгаа.

Энэ дээр зөвхөн хууль гаргаад зогсохгүй хуулийн хэрэгжилт сайн байж энэ авлигын түвшний индекс манай улсын хувьд буурна. Одоохондоо манай улс сүүлийн 30 хувьд явж байгаа.

Тийм учраас үүнийг хэрэгжүүлж байж, батлаад сайн агуулгатай хуулийн төсөл батлаад.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Х.Булгантуяа гишүүнд 1 минут нэмж өгье.

**Х.Булгантуяа:** Америкт миний уншсанаар хамгийн их шүгэл үлээдэг салбарууд бол санхүүгийн салбар. Эрүүл мэнд, байгаль орчны эсрэг компаниуд хэрэг үйлдсэн байх юм бол. Эмнэлгийн салбарт эмийн эмийн хэрэглээний талаар “Файзер” гэдэг компани бол 2.3 тэрбум долларыг төлсөн байх. Эмийг буруу сурталчилсан. Олон нийгэд худлаа үнэн таниулсан гэдэг хэргээр.

Тэгэхээр үүн шиг ийм юм явлаа гэхэд энэ хувь хүний нууцын асуудал олон улсад бас ингэж яаж давхар тавигддаг юм бэ? Одоо нөгөө худлаа шүгэл үлээвэл яах вэ? Өөрийнхөө өрсөлдөгч компанийг агнаад худлаа шүгэл үлээвэл яах вэ? Эсвэл өөрийнхөө улс төрийн ч байдаг юм уу, өрсөлдөгчийн эсрэг худлаа шүгэл үлээвэл яах вэ? Дараа нь тэр хүний нэр хүндээ сэргээлгэх асуудал хэрхэн яаж тусаж байгаа юм бэ гэдэг дээр Хууль зүй, дотоод хэргийн яамныхан нэг л сайн хариулт өгч чадахгүй байна л даа.

Ер нь түрүүн С.Чинзориг гишүүн ч гэсэн хэлж байна лээ.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Ажлын хэсэг нэмж хариулья.

**П.Сайнзориг:** Ер нь энэ авлига, ашиг сонирхлын гэмт хэрэгтэй тэмцэх асуудал, мэдээлэгчийг л дэмжих асуудал байгаа.

Энэ мэдээлэл үнэн үү, худал уу гэдэг асуудлыг зааг, ялгаатай авч үзнэ. Үнэхээр илтэд худал мэдээллээр шүгэл үлээсэн. Өмнө нь шалгуулж, үр дүн нь нэгэнт шийдэгдчихсэн асуудлаар ч гэдэг юм уу, цахим орчин, олон нийтийн хэвлэл мэдээллээр явж байгаа асуудлаа шүгэл үлээх асуудал дээр үүнийг шүгэл үлээсэнд тооцохгүй байдлаар байж байгаа.

Ер нь сая Х.Нямбаатар сайд таны өмнөх гишүүний асуултад хариулсан байгаа. Бид хэд өөрсдөө эргээд иргэдийнхээ эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх, эргээд яг албан ёсны шийдвэр гараагүй байж байхад олон нийтийн гэдэг юм уу хэрэгслээр аливаа этгээдийг буруутгах ч гэдэг юм уу энэ зүйлүүд дээр иргэдийнхээ л боловсролыг дээшлүүлж, соён гэгээрүүлдэг шийднэ.

Хоёрдугаарт, бид хэд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж байгаа нэг хууль нь цахим орчинд хүний эрхийг хангах хуулийн төслийг боловсруулж байгаа. Үүнтэйгээ уялдуулж энэ асуудлыг авч үзнэ.

Дээрээс нь бид Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль батлагдсан. Энэ хүрээндээ.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуулт асууна.

**С.Ганбаатар:** Энэ хуулийн тухай байр сууриа хэлье.

19 жил архаг шүгэл үлээгчээр ажиллаж байгаа би энэ дээр хэдэн зүйл асуулт асууя. Гурван асуулт байна.

Рио Тинто гэж 600 тэрбум долларын баялаг манайхаас авчхаад 23 тэрбум долларын өрөнд оруулчихаад энэ зүйлийн талаар 20-иод жил шүгэл үлээлээ. Зөрүүлээд Рио Тинто жилд 18 тэрбум төгрөгийг зарцуулж. Одоо Пи Ар-ын зардал гэж нэрлэж байгаа юм л даа. Нөгөө жинхэнэ үнэн шүгэл үлээгчийг доромжлуулдаг, гутаадаг ийм шүгэл үлээх ажлыг нийгэм даяар явуулдаг. Үүнийг яаж сэргийлж байгаа вэ?

Хамгийн өндөр үнийн дүнтэй контракт хийдэг, хамгийн алдартай манай нийтлэлч “Энэ С.Ганбаатар ичдэггүй, цуцдаггүй.” гэж хэлж байсан. Хүнийг ичээх, цуцаах, амьдралгүй болтол нь шүгэл үлээдэг. Тэд нар. Хамгийн их мөнгөтэй, эрх мэдэлт албан тушаалд ойрхон улсууд захиалгат шүглийг үлээдэг. Үүнийг яаж ялгаж байгаа вэ?

Хоёрдугаарт, мань мэт яах вэ. Үлээлгээд. Одоо үлээх ч юм байхгүй болчихсон улсууд. Энэ хуулийг би дэмжиж байгаа. Яагаад гэвэл түрүүн. Х.Нямбаатар дарга аа, та хэлэх ёстой. Одоо нөхцөл байдал 1937 оны хэлмэгдүүлэлтийн үеийнх шиг аймшигтай үе явж байгаа шүү дээ. Энэ хуультай хуульгүй аймшигтайгаар шүгэл үлээж хүн авч байгаа. Ядаж үүнийг нэг зохион байгуулж, ядаж үүнийг нэг хуульчлах гэж оролдож байгаа гэж би харж байна.

Хоёрдугаар миний асуулт. Яг сонгуулийн үеэр өрсөлдөгчөө алах шүгэл үлээлтийг Монгол даяар явуулдаг. Албан тушаалтай, мөнгөтэй, эрх мэдэлд ойрхон.

Бүр тагнуулын газраас явуулдаг. Үүнийг яаж шийдэх вэ?

Би хэзээ ч гомдол гаргаж байгаагүй. Надад шүгэл үлээж, худлаа ярьж байсан нэг муу охин одоо албан тушаалд оччихсон, амьдрал нь болчихсон явж байгаа.

Манай залуучууд тагнуулын газар өгсөн. Яах ч үгүй. Яагаад гэвэл ард нь арыг нь даадаг том эрх мэдэлтнүүд байгаа учраас. Үүнийг ялгаж байгаа юу? Миний хоёрдугаар асуулт.

Миний гуравдугаар асуулт. Ер нь Израилийн **Comptroller**<sup>3</sup> гэж яриад байгаа шүү дээ. *Compte, controller* гэдэг хоёр үгийн холимог л доо. **Comptroller** гэж.

Нийгэмд шүгэл үлээгч шуугихаас нь өмнө хүлээж аваад бас нэг **омбудсмен** маягаар зохицуулдаг энэ механизмыг судалсан уу? Энэ бол одоо манайх шиг улсад их таараад байдаг юм шиг надад санагддаг. Гуравдугаар асуулт.

Дөрөвдүгээр асуулт. Яах вэ, Монгол Улс тэр 2005 онд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орсноороо бараг энэ хийхээс өөр аргагүй ажил.

Тэгээд хуулийн үзэл баримтлалын шүгэл үлээгчийн тухай мөнгөн урамшуулал гэдэг талаар ер дурдаагүй байх юм. Энэ яагаад. Үзэл баримтлал дээр байхгүй байна лээ шүү.

Хоёрдугаар миний асуулт. Хуулийн төслийг батлагдсанаар улсын төсвөөс

---

<sup>3</sup> **State Comptroller** нь Израилийн Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг хянана, шалгана, дүн шинжилгээ хийнэ, олон нийтийн санал, гомдлыг хүлээн авна. Кнессетийн доор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд төрийн бүх байгууллагуудад шалгалт хийх бүрэн эрх бүхий байгууллага.

нэмэлт санхүүжилт шаардлагагүй хуудас 4 гэсэн байна. Энэ нэмэлт санхүүжилтгүйгээр хийх гээд байгаа юм уу?

Тайлан 3-ын зөвлөмжийн 19-өөс 21 дүгээр хуудас шүү. Шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах зэрэг зардлын тооцоог хийсэн байна. Зардлын санхүүжилтийг төслийн 19.1-д заахдаа ерөөсөө төсөвт байхгүйгээр л заачихсан байх юм. Үүнийгээ та нар яг хаанаас гаргаж авах гэж байгаа юм бэ? Миний асуулт их тодорхой байх гэж бодож байна.

Дараагийн асуулт бол зөвлөмжид мөнгөн шагнал, урамшуулал, мөнгөн урамшуулал. 16.1-д мөнгөн шагнал, урамшуулал. 17, 16.11 гээд маш их холилдуулсан байна. Урамшуулал шагнал.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Х.Нямбаатар сайд хариулъя.

**Х.Нямбаатар:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Яах аргагүй Сайнхүүгийн Ганбаатар гишүүн бараг. Би андуураагүй бол 2008 оноос хойш Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг шүүмжилж, алдаа оноог нь хэлж, тэмцэж саяын үр дүнд хүрэх хамгийн том алхмыг шүгэл үлээж хийсэн хүн бол яах аргагүй Ганбаа гишүүн.

Бид бас энэ дээр санаа бодол нийлдэг ийм хүмүүс байгаа. Сая бид Монгол Улсын Засгийн газар зээлээр авч байсан өөрийнхөө ногдол хувь хүртэх ёстой 34 хувийг үнэ төлбөргүй авах том хэлэлцээр хийхэд хамгийн том үүргийг С.Ганбаатар гишүүн төдийгүй бусад цуг шүгэл үлээсэн хүмүүсийн том гавьяа. Манай Б.Баттөмөр гишүүн гээд олон хүмүүсийн хамтын бүтээлийн үр дүнд ингээд бид 34 хувиа үнэ төлбөргүй авсан.

Ашиг хүртэх хугацаагаа наашлуулж байгаа.

Тэгэхээр энэ бол өөрөө шүгэл хүлээлтийн хамгийн том давуу тал, хамгийн ойрын жишээ гэж хэлж болохоор байгаа юм.

Тэгэхээр Ганбаа гишүүний хэлж байгаа тэр омбудсменээс энэ арай өөр байгаа юм. Нөгөө Скандинавын хойгоос гаралтай омбудсмены тогтолцооноос манай энэ шүгэл үлээх харилцаа арай өөр. Иргэд, олон нийтийн бүгдийнх нь оролцоог хангасан шүгэл үлээлтийн хэлбэрийг л энэ тогтолцоогоор гаргаж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийн үндсэн агуулга. Түрүүн Их Хурлын дарга ч гэсэн хэлж байна лээ. Ерөөсөө өөрөө процесс юм. Өөрөө шүгэл үлээгч, тэр авлига, албан тушаалын эсрэг, хахуулийн талаарх мэдээ мэдээллүүд, байгаль орчныг бохирдуулж байгаа талаарх мэдээллүүдийг. Магадгүй энэ хэлэлцүүлгийн явцад томоохон корпорацуудын санхүүгээ нуун дарагдуулж байгаа энэ мэдээллүүдийг олж авч мэдмэгцээ мэдээллээ гаргахаас эхэлнэ.

Мэдээллийг гаргаад мэдээллийг шүгэл үлээж мэдээлэл өгөх гэдэг энэ үе шатаар эхэлж байгаа юм. Дараа нь мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, мэдээлэлд хяналт шалгалт явуулах гэх мэт.

Тэгээд шүгэл үлээгч эрхээ хэрэгжүүлэхэд нь баталгааг нь гаргаж өгнө. Бүр шаардлагатай гэж үзвэл оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ. Бүр өөр улсад хүртэл түр хугацаагаар тэр хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор гэр бүлийнх нь хамт нүүлгэн шилжүүлж болно.

Шүгэл үлээгчид хохирол учрах, хохирол учруулж болзошгүй үйлдлүүдийг

бүгдийг нь ингээд бас давхар хориглож өгч байгаа юм.

Шүгэл үлээгчид өөрт нь бас тодорхой тийм өөртөө болон өөрийнхөө хамаарал бүхий этгээдүүдэд давуу байдал үүсгэх зорилгоор шүгэл үлээж байгаа тохиолдлыг бүрмөсөн хориглож байгаа гэдгийг хэлье.

Энэ хуулийн хоёр дахь том зохицуулалт нь урамшуулалтай холбоотой харилцаа байгаа. Урамшууллыг юу гэж тооцож байгаа вэ гэвэл улсын төсөвт дарамт учруулахгүйгээр нөгөө авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас улсын орлого болгож байгаа орлогынх нь хувь хэмжээгээр 100 сая төгрөгөөс 1.5 тэрбум төгрөг хүртэл олгочихё.

Тэгээд энэ хууль дээрээ бүр хувилаад биччихсэн байгаа. Жишээлбэл, 50 сая хүртэл төгрөгийн 15 хувийг, 2 тэрбум, түүнээс дээш төгрөгийн 173 сая төгрөг дээр.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд микрофон нэмж өгье.

**С.Ганбаатар:** Энэ хуулийг. Түрүүн би хэлсэн. Дэмжиж байгаа.

Тэгээд хамгийн гол нь энэ хуулийн эсрэг шүгэл үлээж байгаа жирийн иргэний нийгмийн байгууллагын хүмүүс бол маш их ганцаарддаг. Маш их эвгүй хүнд байдалд, амь нас нь аюултай байдалд ордог. Үүнийг ингээд төрөөс анхаарч хуульчилна. Мэдээж хуулийн зүйл, заалтууд дээр миний оруулах саналууд их байгаа.

Тэгээд миний ойлгосон зүйлүүд гэвэл тэр томоохон үндэстэн дамнасан корпорацуудын тал дээр шинжээч, экспертүүдийн дүгнэлтүүдийг гаргадаг тийм үйл ажиллагаа байгаа юу? Яагаад гэвэл энэ дээр яг шүгэл үлээгч нь зөв үү,

буруу юу гэдгийг тогтоохдоо бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтийг заавал ашигладаг. Одоо би бол тэр **Comptroller** гэж Израилийн юуг л яриад байна л даа.

Бие даасан хөндлөнгийн шинжээчийн.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** 81 дүгээр микрофон дээр ажлын хэсэг хариулъя. 80 дээр. П.Сайнзориг дарга.

**П.Сайнзориг:** Сая Х.Нямбаатар сайд хэлсэн. Түрүүн Г.Занданшатар дарга ч бас үгэндээ хэлж байна лээ. Процессжуулах.

Тэгээд мэдээллийг гаргаад хянан шалгах ажиллагаа явуулж байх юм бол яг тус тусын тэр гэмт хэрэг, зөрчлийнхөө шинжээсээ хамаарч тус тусын процесс руугаа шилжиж байгаа. Өөрөөр хэлэх юм бол эрүүгийн гэмт хэргийн шинжтэй зүйл байвал Эрүүгийн хэрэг хянан шийдэрлэх тухай хууль. Магадгүй зөрчлийн асуудал байвал зөрчил ч байдаг юм уу. Бусад хууль тогтоомжоор шийдэгдэх асуудал байвал холбогдох процессын хууль руугаа шилжинэ.

Тэгэхээр тэр процессын хуулиуд дээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч оролцуулах зохицуулалтууд бүрэн байгаа. Ашиглах боломжтой. Үүнийгээ мэдээж шинжээч гэдэг маань тусгай мэдлэгтэй, хараат бусаар ажиллах чадвартай ийм иргэн, хуулийн этгээдийг хэлж байгаа учраас таны хэлж байгаа энэ асуудлууд дээр бас холбогдох процессын хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бүрэн бололцоо байгаа гэдэг зүйлийг хэлье.

**Т.Аюурсайхан:** С.Амарсайхан гишүүн алга байна. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд асуулт асууна.

**Н.Энхболд:** Юуны өмнө яах вэ, энэ хуулийг хэлэлцэх эхийг нь дэмжинэ. Тэгэхдээ дотор нь анхаарах зүйлүүд их байна.

Сая их олон гишүүд хэллээ. Би заримтай нь санал нэгдэж байна. Ер нь аливаа хууль бол хэрэгждэг л байх хэрэгтэй. Зүгээр гаднаас хуулбарлаж аваад гаднын байгууллагын шахалтаар ч юм уу хийсэн олон хуулиуд эсвэл хэрэгждэггүй, эсвэл хэрэгжихдээ гажуудалтай хэрэгжиж байсныг бид энэ 30 жилийн хугацаанд харсан. Үүнээс болоод хуулийн нэр хүнд унасан. Үүнээс болоод төр, иргэдийн хоорондох итгэлцэл буурсан.

Тэгэхээр энэ хуулийг гаргахдаа өөрийнхөө орны онцлог юмнуудыг харгалзсан, хэрэгжих боломжтой ийм хууль гаргах ёстой гэж ингэж үзэж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцод 2005 онд элссэн. Энэ хуулийн үзэл баримтлал дотор ийм үг байгаа. Конвенцын 33 дугаар зүйлд оролцогч улс бүр энэ конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт, нотолгоог сайн санааны үндэслэлтэйгээр, сайн санааны үүднээс үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж байгаа аливаа этгээдийг шударга бус хандлагаас хамгаална гэсэн. Гол агуулга нь энэ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын.

Энэ ажил сайн санааны үүднээс хийгдсэн байх ёстой. Энэ ажил хийж байгаа хүмүүсийг хамгаалж байх ёстой.

Би бол энэ хүрээндээ л ярих нь чухал гэж бодож байна. Үүнтэй холбогдуулаад тэр төлбөртэйн асуудлыг ярих гэж байгаа юм.

Төлбөр бол үүнийг дагаад нийгмийг хамарсан тийм буруу үзэгдэл бий болох

вий дээ гэж би санаа зовж байгаа. Эдийн засаг хүнд, орлого бага, нийгмийн ёс суртахуун ороо бусгаа байгаа энэ үед, түүхийн энэ зурваст бид энэ шүгэл үлээдэг, мэдээлдэг энэ асуудлыг мөнгөний хэрэгсэл болгож хувиргавал энэ өөрөө аюултай үзэгдэл болно. Би энэ талаас нь их санаа зовж харж байгаа. Хэлэлцэх үеэр саналуудаа хэлнэ. Болж өгвөл тэр “урамшуулалтай” гэдэг хэсгийг нь хасах хэрэгтэй байгаа юм.

Бусад орнуудын жишээ манай хууль санаачлагчид их ярьж байна. Тэр орнуудад чинь энэ нийгмийн сэтгэлгээ, элдэв янзын асуудлууд нь их өөрөө. Өөр шатанд гарчихсан ийм улсууд байгаа. Алхам алхмаар тийшээ дөхөх л байх л даа. Бид нэгэнт нийтлэг үнэт зүйлээрээ бусад орнуудтай, олон ардчилсан орнуудтай ойрхон явж байгаа болохоор. Тэгэхдээ яг өнөөдөр энэ байдлаар ингэж орж ирвэл энэ дэмий юм болох болов уу гэж бодож байна. Зүгээр хуучин нийгмээс үлдсэн манай сэтгэлгээний онцлогууд юмнууд бий шүү дээ. Бодож үзэх ёстой юм бий.

Төрсөн эцгийгээ матаад. Тэр үеийн хэллэгээр шүү. Түүнээсээ болоод улсдаа баатар болж байсан хүүхдийн тухай зохиол хүртэл өөр улс орны жишээгээр байж байгаа. Тиймэрхүү байдал руу улс орноо, иргэдээ, нийгмээ чирч байсан, түлхэж байсан гашуун туршлага байгаа.

Тэгэхээр би энэ мөнгө бол тэр лүү чирдэг нэг хэрэгсэл болчих вий дээ гэж бодож байна. Үүнийг бид хэлэлцэх үеэрээ заавал ярих ёстой гэж бодож байгаа.

Энэ 5.1.4 гэдэг заалт байна. Би үүнийг ерөөсөө ойлгосонгүй. Шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална гээд 5.1.4 дээр нь “хүртээмжтэй, байнгын сүлжээ бий болгоно.” гэж байгаа юм. Энэ юу гэсэн үг вэ? Мэдээлэгчдийн системийг хуулиар бий болгоно гэсэн үг үү?

Нөгөө манай хуучин нийгэмд мэдээллийн бүхэл бүтэн улс орныг хамарсан, иргэдийн маш том хэмжээг хамарсан ийм систем байсан шүү дээ. Тэрийг сэргээх тухай асуудал арай биш биз дээ?

Үүнийгээ зөв тайлбарлахгүй бол. Надад тэгж ойлгож байна. Мэдээлэгчдийн ийм.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Н.Энхболд гишүүнд 1 минут нэмж өгье.

**Н.Энхболд:** Мэдээлэгчдийн хүртээмжтэй ийм байнгын сүлжээ бий болгоно гэж. Энэ нь байж болохгүй зүйл гэж миний итгэл үнэмшил тийм байна.

Үүнийгээ зөв тайлбарла. Эсвэл энэ хуулийнхаа заалтаас хас.

Буруу, худлаа шүгэл үлээснээс болоод хохирсон асуудлыг маш олон гишүүд ярьсан.

Тэгэхээр үүнийг бид заавал бодолцох ёстой ийм сэдэв байгаа. Хэлэлцэх үеэрээ.

Нууцтай холбоотой асуудлыг ярьсан. Үүнийг бид заавал энэ хуультай хамтатгаж авах, хэлэлцэх ёстой ийм сэдэв болно. Энэ зүйлүүд дээр. Саяын хоёр асуултдаа би хариулт авъя. Тэгээд давхардсан олон зүйлүүдийг орхиё доо. Шаардлага гарвал тодруулаад л нэг асуучихъя.

**Г.Занданшатар:** 80 дугаар микрофон дээр П.Сайнзориг дарга хариулъя.

**П.Сайнзориг:** Нямаагийн Энхболд гишүүний асуултад хариулъя.

Урамшуулалтай холбоотой асуудлууд яах вэ, олон улсын жишиг, бусад орны хууль тогтоомжид байдаг ийм зохицуулалтыг бид судалж оруулж ирсэн. Тэгээд яг юу юугүй мөнгөний хэрэгсэл болгох гэдэг асуудал байхгүй болов уу. Тодорхой хэрэг маргаан шийдэгдсэний дараа хүсэлт гаргахаар нь шийдэж байгаа.

Тэгэхдээ үүнийг хэлэлцүүлгийн үед тал талаас ярилцах бүрэн боломжтой гэдэг зүйлийг танд хэлье. Тэгээд мэдээж энэ хуулийн төсөл маань дэмжигдсэн тохиолдолд.

Хоёрдугаарт, 5.1.4 дэх буюу “хүртээмжтэй, байнгын сүлжээг бий болгох.” гэдэг асуудлыг та асууж байна.

Энэ зарчмын хувьд шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд. Түүнээс биш яг мэдээлэл гаргагчийн ийм сүлжээ гаргах гээд, бий болгох гээд байгаа зүйл биш. Яг нэгэнт үлээчихсэн энэ хүмүүсийг дэмжиж юм уу, хамгаалах асуудал дээр “хүртээмжтэй, байнгын сүлжээг бий болгох” гэдэг ийм зарчим байгаа.

Энэ нь юу гэж тайлбарлагдаж байгаа вэ гэхээр мэдээлэл гаргах тэр төрийн байгууллагуудын мэдээлэл хүлээж авч байгаа этгээд маань байнгын энэ мэдээллийг хүлээж авах. Магадгүй утас. Одоо энэ дээр Авлигатай тэмцэх газар маань мэдээллийг хүлээж авдаг байнгын тогтолцоо бүрдүүлсэн байгаа. Засгийн газар дээр ч гэсэн байнгын иргэдээс өргөдөл, гомдол авдаг, мэдээллийг хүлээж авдаг сүлжээг бий болгосон байгаа.

Дээрээс нь яах вэ, яг аюулгүй байдлыг хангах асуудал яг энэ дээр хүргэгдээд ирж байгаа юм. Энэ мэдээллийн санг дундын мэдээллийн сан бүрдүүлж ажиллах, үүний аюулгүй байдлаа хангах, энэ нь тогтмол байх. Түүнээс биш ингээд мэдээллүүд ирээд бас



хэн нэг даргын ширээний доор ингээд үлдчихдэг. Мэдээллүүд нь нэгтгэгддэггүй, харилцан солилцогддоггүй ийм байдлууд байж болохгүй шүү гэдэг зүйл байгаа.

Хоёрдугаарт яах вэ, Гэрч, хохирогчийг хамгаалах хуульд заасан тэр арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг. Магадгүй шүгэл үлээж байгаа энэ дээр гарна.

Тэгэхээр үүнийгээ юу гэдэг юм хүртээмжтэй, илүү их байнгын найдвартай байлгах. Магадгүй тэр хамгаалалтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх дэд бүтэц, хүний нөөц, төсөв, санхүүгээ бид байнгын бий болгох, тогтмол байлгах ёстой шүү гэдэг энэ санаагаар орсон юм. Тэгээд эргээд асуудлуудыг илүү их тодруулж ярья.

Нууцын асуудал дээр ганц л зүйлээр төрийн нууц задруулсанд тооцохгүй байгаа. Энэ нь төрийн нууцтай харьцах явцад авлига, ашиг сонирхлын гэмт хэргийн шинжтэй мэдээлэл гараад ирэх юм бол үүнийг илчилсэн төрийн нууцыг задруулсанд тооцохгүй гэдэг л заалт байгаа. Бусдаар бол одоо яг төрийн нууцыг бас хэтэрхий хавтгайд нь задлах ч гэдэг юм уу, үндэсний аюулгүй байдал руу хэт хазайлгах ийм зүйл, заалт одоогоор ороогүй. Мэдээж гишүүд тал талын саналууд хэлж байна. Үүнийг илүү их цаашдаа боловсронгуй болгож, ямар нэгэн ан цав гаргах гэдэг юм уу, нүх сүв үлдээхгүй байх талаас нь хуулийг боловсруулж гаргахад нь анхаарах зайлшгүй шаардлага байна гэж таны хэлж байгаа саналыг хүлээж авч байна. Бид хэд ч гэсэн бас анхааралдаа авъя.

**Т.Аюурсайхан:** Н.Энхболд гишүүнд 1 минут нь нэмж өгье.

**Н.Энхболд:** Би дахиад энэ хуулийг яах вэ, хэлэлцэхийг нь дэмжинэ. Тэгээд хэлэлцээд гаргахдаа бид ямар зарчим

барих ёстой вэ гэдэг дээр өөрийнхөө санаа бодлыг давтаад хэлчихье гэж бодсон юм.

Нэгдүгээрт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцынхоо гол үзэл санааны хүрээнд үүнийгээ хийх хэрэгтэй байна.

Тэр сайн санааны үүднээс ийм ажил хийж байгаа хүмүүсийг шударга бус хандлагаас хамгаалах тал дээр нь. Түүнээс ямар нэгэн байдлаар. Зориуд ямар нэгэн байдлаар гэж байгаа юм. Урамшуулах, хөхүүлэн дэмжих энэ асуудал дээр маш туйлын болгоомжтой хандах хэрэгтэй.

Яагаад гэвэл одоо болтол манайд ингээд хоёр нийгмийн завсрын энэ үеийн оюун санаа, үзэл суртлын хувьд нийтлэг гэж үзэж болохоор тийм тавцан бүгдээрээ гарч чадаагүй байгаа. Хоёр нийгмийн хоорондох энэ үед хоёр сандал дээр зэрэг суучихсан.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил асуулт асууна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Манай ажлын хэсгийнхэн гишүүдийн саналуудад тайлбар хийхээс гадна сайн шингээж авахыг бодоорой. Амьдрал дээр хэрэгтэй, амьдралаас ургасан юмнууд л яриад байгаа шүү.

Би хэлэлцэх эсэхийг нь дэмжээд нэлээн засвар өөрчлөлт оруулаад хуулиа батлах тал дээр байгаа юм.

Тэгээд энэ дээр яах вэ, нэг талаас байна шүү дээ бид ингээд нөгөө нийгмийн хөгжлийн явцад хүссэн хүсээгүй арай өөр төрлийн. Өндөр зэрэглэлийн гэх юм уу даа. Арай өндөр шаардлага тавьсан хууль баталж эхэлж байна л даа.

Өндөр зэрэглэлийн гэдэг нь юуг нь хэлээд байна вэ гэхээр ингээд улаан шугам

татчихсан биш. Яг л ийм байна. Эсвэл ийм байна гэсэн шугам татчихсан биш. Жишээ нь, энэ хуульд нөгөө шүгэл үлээгчийн дотоод сэтгэл санаа, үзэл бодол, сэдэл. Эд нарыг нарийн тогтоож гаргах шаардлагатай болж байгаа байхгүй юу. Энэ хуулийг жинхэнэ ёсоор нь хэрэгжүүлж гэвэл.

Энэ бол өөрөө маш нарийн, шүүгчийн мэдрэмжийн, мэдлэгийн асуудал. Прокуроруудын мэдлэг, мэдрэмжийн асуудал. Төрийн байгууллагуудын мэдрэмжийн асуудал.

Тэгээд энэ дээр ер нь бэлэн байгаа юм уу, үгүй юу? Манай энэ ажлын хэсгийнхэн хариулна биз.

Би үүнийг яагаад асуугаад байгаа юм гэхээр энэ хуулийг хэлэлцэх эсэхийг судлаад үзэхэд бусад улс орнуудад хэрэгжилтийн явцад гарсан үндсэндээ ерөөсөө хоёр том проблем байна. Хоёр том проблем.

Нэг нь, одоо жишээ нь тэр мэдээлэл тавих шаардлага. Одоо манай энд бол ерөөсөө нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсвэл хохироосон байж болзошгүй л гээд байгаа байхгүй юу. Гэтэл энэ чинь маш өргөн цар хүрээтэй байна шүү дээ. Дэндүү олон материал орж ирж магадгүй байхгүй юу.

Тэгэхээр энэ дотор чинь жишээ нь оригинал байх ёстой. Өөр хэн ч мэдээгүй, хаана ч мэдэгдээгүй. Төрийн байгууллага энэ тухай сонсоогүй, энэ талаар мөрдөн байцаах юм уу, гүйцэтгэх ажиллагаа явуулаагүй, эхлээгүй, цоо шинэ байх ёстой гэдэг ч юм уу.

Тэгээд энэ хуулиа эхлээд хэрэгжүүлэхдээ ганц нэг тийм хязгаартай хэрэгжүүлж үзмээр байгаа юм. Энэ их чухал. Энэ хууль дээрээ тусгагдаагүй үлдчихээд байгаа юм.

Хоёр дахь юм бол энэ ийм юм байгаа байхгүй юу. Нөгөө шүгэл үлээгч энэ бол яг нийтийн ашиг сонирхлыг зөрчиж байна, хохироож байна гэж өөрөө яг итгэл үнэмшил болох ёстой байгаа юм. Тийм ээ. Гэтэл энэ Америк, Английн хуульд шүүхийн шийдвэрүүдэд **reasonable belief** гээд байгаа байхгүй юу. Одоо тийм “хүлээн зөвшөөрч болохуйц хэмжээний итгэл үнэмшил болсон байх ёстой.” гэж.

Тэгэхдээ тэр нь 100 хувь гэсэн үг бас биш. Тэрийг нь шүүх тогтоох ёстой болчихоод байгаа байхгүй юу.

Мэдээж улаан цагаан худлаа яриад хүн гүтгээд байвал өөр хэрэг. Гэтэл нөгөөдөх нь жинхэнээсээ бодчихсон. Яг ийм байна гээд **reasonable belief** буюу одоо “итгэл үнэмшилтэй болох” хэмжээнд хүрсэн. Тэгсэн тэр нь худлаа байдаг. Тийм ээ. Үүнээс болоод нөгөө байгууллага, төр, хувь хүний алдар нэр, бизнес, эрх ашигт хохирол учирчихдаг.

Энэ хоёрын зааг, ялгааг яаж гаргах юм бэ? Энэ дээр бид бэлдчихсэн. Жишээ нь, манай Иргэний хуулийн, Компанийн хуулийн хэрэгжилт дээр энэ талаар шүүхийн нарийн шийдвэрүүд гараад, шүүгч нар зааг, ялгааг нь тогтоочихсон. Та бол 100 хувь итгэлгүй ч гэсэн дотоод итгэл үнэмшил чинь хангалттай хэмжээнд хүрэхээр ийм материал тань дээр байсан байна. Та итгэл үнэмшилд хүрсэн байна.

Тийм учраас таныг энэ хуулийг зөрчөөгүй гаргасан гэж бид итгэх үндэслэл байна гэж шүүгч үүнийг ялгах ёстой болчихоод байгаа байхгүй юу. Аягүй зовлонтой хууль байгаа байхгүй юу.

Одоо өөрөө хуулиуд болохоор зарсан, зараагүй л гэдэг асуудал байна шүү дээ. Бараа шилжсэн үү, шилжээгүй юу. Мөнгө шилжсэн үү, шилжээгүй юу. Энэ бол шүүх шийдэж чадаад байгаа юм.

Гэтэл нөгөө шүгэл үлээгч маань өөрөө дотоод итгэл үнэмшил нь ийм байсан гэдгийг тогтооно гэдэг чинь аягүй нарийн, өндөр түвшний ажил байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бэлэн үү? Үүнийг нэг хэлээдхээч. Тэгээд эцэст нь нэг нөхцөлд.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Ажлын хэсэг 80 дугаар микрофон.

**П.Сайнзориг:** Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

Таны хэлж байгаа санаануудыг бид маш анхааралтай судалж, энэ хуулийн төслийг чамбайруулах тал дээр анхаарч ажиллая.

Хоёр асуудлыг хөндөж байна. Мэдээлэл тавих шаардлагын асуудал байгаа. Хуулийн төсөл дээр ч гэсэн яах вэ, 8.3 дахь хэсэг дээр эрх бүхий байгууллага дараах тохиолдолд мэдээлэл, хяналт шалгалт явуулахгүй. гээд заачихсан байгаа.

Нэгдүгээрт, илтэд худал мэдээллээр шүгэл үлээсэн.

Хоёрт, өмнө нь шалгуулж, үр дүнг нь мэдээ мэдэгдсэн асуудлаар дахин шүгэл үлээсэн.

Гуравдугаарт, цахим орчинд, эсвэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд ил болгосон баримтаас өөр шинэ баримтгүйгээр шүгэл үлээсэн буюу таны хэлж байгаа санааг бид эсрэг утгаар нь энэ дээрээ эсрэг талаас нь бичээд ингээд оруулчихсан гэсэн үг. Өөрөөр хэлэх юм бол яг их баримт байхгүй. эсвэл өмнө нь дэлгэгдээгүй баримтаа шүгэл үлээгээгүй бол үлээгээгүй шүү гэдгийг энэ хууль дээр туссан.

Дөрөв дэх асуудал нь, шүгэл үлээсэн мэдээллийг хүлээж авахаас өмнө нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсвэл хохироож болзошгүй нөхцөл байдал үүссэн үйлдэл, эс үйлдэхгүйгээр аль хэдийн хууль шүүхийн хяналт шалгалт яваад эхэлчихсэн бол бас энэ шүгэл үлээсэнд тооцохгүй гэсэн ийм асуудал байгаад байгаа юм.

Мэдээж үүнийг илүү их, таны хэлж байгаа нь нюансуудыг анхаарч авч үзэх нь чухал гэдэг зүйлтэй санал нэгдэж байна.

Хоёрдугаарт, энэ дээрээс зөвхөн шүүгч гэлтгүй ер нь энэ мэдээллийг аваад шалгаж авч үзэж байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч гэдэг юм уу оролцох энэ алба хаагчдын ур чадварын асуудлыг та илүү их хөндөж байна. Энэ нюансыг ойлгох.

Тэгэхээр бид ч гэсэн ер нь зүгээр цаашдаа бас яг энэ гомдол мэдээллийг шалгах асуудал дээр ажиллах алба хаагчдыг илүү их, мэргэшүүлэх. Үнэхээр 2005 оныг олон улсын гэрээ конвенцод заасан тэр “**сайн санааны үүднээс**” буюу “**нийтийн эрх ашгийн төлөө**” гэдэг энэ итгэл үнэмшил дээр хэр байгаа энэ асуудлыг шалгах, энэ юун дээрээ албан хаагчдынхаа ур чадвар, тэр асуудлыг анхаарах ёстой.

Хоёрдугаарт, тогтолцооны асуудал ч байгаа. Мэдээж энэ Авлигатай тэмцэх газрыг сайжруулах, чадавхжуулах асуудал. Прокуроруудаа бид энэ чиглэлдээ мэргэшүүлэх асуудал. Дээрээс нь сүүлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дээр ч гэсэн авлига, албан тушаалын гэмт хэргийг анхан шатны журмаар давж заалдах шатны шүүхээс оруулж ирье. Өөрөөр хэлэх юм бол энд нюанстай асуудлууд яригддаг учраас илүү их **experience**<sub>[туршлагатай]</sub> болсон ийм шүүгч нараар хэрэг маргааныг шийдүүлж байх гэсэн ийм санаагаар Засгийн газраас өргөн

барьсан боловч хуулийн төсөл маань дэмжигдээгүй.

Тэгэхдээ бид хэд өөр бусад хувилбаруудыг судалж, энэ чиглэлдээ анхаарах зайлшгүй шаардлагатай гэдэг таны энэ саналыг хүлээж авч байна.

Тэгээд хоёрдугаарт иргэдийнхээ эрх зүйн боловсрол, ухамсар, эргээд юу гэдэг юм өнгөц мэдээлэл дээрээс бусдын эрх ашгийг хөндөх, бусдыг хохироох, бусдыг олон нийтийн өмнө буруу байдлаар харагдуулах ч гэдэг юм уу, эсвэл бизнесийнх нь хэвийн үйл ажиллагааг доголдуулах ийм нөхцөл байдал орж болзошгүй учраас өөрт байгаа энэ мэдээ.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Ц.Мөнх-Оргил гишүүнд микрофон нэмж өгье.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Би 8.3-ыг харсан л даа. П.Сайнзориг оо.

Тэнд ийм юмыг шалгахгүй гээд эсрэг талаас нь негатив талаас нь яриад байгаа байхгүй юу. Гэтэл 4 ийм заалттай.

Үүний чинь цаана асар их мэдээлэл үлдчих байхгүй юу. П.Сайнзориг оо.

Нөгөө талаасаа позитив буюу одоо яг иймийг шалгана гэдэг шалгуур тавьчих юм бол тэрэнд чинь хүрч байгаа нь харьцангуй цөөхөн байх байхгүй юу. Тэгэхгүй та нар энэ хуулиа хэрэгжүүлэх гээд бодоод үз л дээ. Ингээд л байгууллага байгуулагдлаа. Өчнөөн материал ороод ирнэ.

Тэгээд л энэ 4-т байгаагүй л бол бүгдийг нь шалгахаас өөр аргагүй болчихоод байгаа байхгүй юу. Тэр утгаар нь. Нөгөө хэрэгжихэд ямар байх вэ гэдгийг нь та нар сайн бод оо.

Тэгээд энэ нууцын асуудал. Энэ төрийн нууц, хувийн нууц, байгууллагын нууцын хуулиуд янзлагдаагүй байхад сэтгэл санааны хохирлыг бид шүүхээр барагдуулж чаддаггүй одоогийн нөхцөл хэвээр байхад энэ хууль хэрэгжинэ гэж байхгүй шүү. Бүр замбараагүй юм болно шүү.

**Т.Аюурсайхан:** Х.Нямбаатар сайд хариулъя. Нэмж хариулъя.

**Х.Нямбаатар:** Би Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хоёр зүйл хэлье.

Сүүлийнх нь асуудал дээр болохоор бид Шүүх шинжилгээний байгууллагын хуулийг анхны хэлэлцүүлгийг хийхээр бэлдэж байгаа. Энэ хууль дээр бид анх удаагаа сэтгэл санааны хохирлыг үнэлдэг ийм аргачлалыг бас давхар батлах гэж байгаа.

Хоёрдугаарт, амь насыг бас үнэлдэг ийм аргачлал анх удаагаа оруулж ирж байгаа.

Хоёрт нь хэлэх гэж байгаа зүйл юу вэ гэхээр бид энэ тодорхой хүрээ хязгаар тавиад хумьчихаар энэ нөгөө шүгэл үлээгчийн шүгэл үлээх хүрээ хязгаарыг хэт хумьсан ийм агуулга харагдах гээд байгаа юм.

Эцэст нь та яаж үнэлэх вэ. Энэ яг анхдагч мэдээлэл мөн үү, биш үү гээд олон шалгуур ярьж байна. Тийм ээ. Үүнийг шүүх эцэслэж шийдье л гэж байгаа юм. Шүүх дээр уг асуудал шийдэгдэхэд энэ шүгэл үлээгчид олгох урамшуулал болон шүгэл үлээгчийн тэр эрх зүйн хамгаалалт тогтоосон хамгаалалтын арга хэмжээ.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Ч.Хүрэлбаатар гишүүн алга байна.

Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан асуулт асууна.

**Ц.Туваан:** Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дэмжиж байгаа. Энэ зөв зүйтэй хууль гэж ингэж үзэж байгаа юм. Энэ бол нийгмийг авлигагүй, эрүүл болгох, шударга нийгмийн төлөө явж байгаа нөхцөлд энэ зайлшгүй байх ёстой. Олон улсад ч гэсэн энэ жишгээр явдаг. Монгол Улс ч гэсэн олон улсын энэ чиглэлээр конвенцод нэгдсэн, үүрэг үлээсэн ийм улс гэж ингэж харж байгаа. Энэ утгаараа дэмжиж байгаа.

Тэгэхдээ бас асуудлууд байгаа. Гишүүд нэлээн ярьчихлаа. Монголчууд өөрөө тийм нүүдэлчин ард түмэн. Цөөхүүлхнээ. Гуравхан сая гаран хүн амтай.

Тэгээд ер нь мэдээлэл их тийм аман байдлаар их явдаг. Одоо энэ сошиал дээрх мэдээлэл энэ тэр гэдэг чинь үүний л нэг улбаа яваад байна шүү дээ. Одоо ерөөсөө дагаад шуурдаг.

Тэгээд ер нь хүний муу үзэх дургүй гэж их ярьдаг. Тийм ээ. Нүүдэлчдийн менталитет<sup>[сэтгэлгээ]</sup> юм даа.

Тэгэхээр энэ дээр энэ хуулийг бас зөв талаас нь нэлээн сайн тайлбарлаж өгөх нь зөв болов уу гэж ингэж бодож байгаа юм. Цөөхүүлхнээ учраас бие биеэ одоо ерөөсөө маш амархан таньж мэддэг. Нэг иргэн хүсэх юм бол хамгийн холдоо л гурван хүнтэй уулзаад л Ерөнхийлөгчтэй ч уулзаж чадна, хэнтэй ч уулзаж чадна.

Тэгэхээр цөөхүүлхнээ байгаа энэ нөхцөлд энэ хуулийг нэлээн зохицуулж, өөрөөр хэлбэл мэдээлэл дамжих гэдэг талаас нь, нууцлал гэдэг талаас нь нэлээн ярих нь зөв байх гэж бодож байгаа юм.

Дээрээс нь хүмүүс ярьдаг шүү дээ. Энэ хууль хүчний байгууллагад өргөдөл

өгөөд нууцаа л гэдэг. Хувийн нууц хадгална л гэдэг. Тэгээд нөгөөдөх нь мөрдөн байцаалтын шатандаа ч юм уу. Эсхүл шалгагдах шатандаа тэгээд л ил болчихдог. Тэгээд л нөгөө үнэн зөв мэдээлэл өгсөн хүн хүний муу үзэж, мууг нь үзэх гэсэн хүн болоод л ингээд тэр хавиараа л ингээд л жигшээд л, тэднийх нь тэгдэг, ингэдэг гээд ингээд яваад өгдөг.

Тэгэхээр энэ нийтийн ашиг сонирхлын төлөө явж байгаа энэ зүйл дээрээ бас манай энэ хууль санаачилж оруулж ирж байгаа хүмүүс, ажлын хэсэг, мөн хэлэлцүүлгийн шатанд нэлээн сайн чамбай болгоод усыг нь шахаад ингээд гаргачих нь зөв байх гэж ингэж бодож байна.

Тодруулах зүйл маань бол одоо энэ өгсөн мэдээллийг урамшуулдаг, үнэлдэг ямар нэгэн тогтолцоо юм ер нь ямар ямар хууль дээр, ямар ямар зүйл заалтууд дээр байгаа вэ?

Хоёрдугаарт, мэдээж хууль орж ирж байгаа. Засгийн газар дээр бусад Сангийн яам энэ тэр нь ч саналуудаа авсан байх. Энэ санхүүжилт тал дээрээ одоо юм гарахгүй л гэж байна. Тэгээд энэ дээр Сангийн яам жишээлбэл ямар санал өгсөн байдаг юм бол? Тийм.

Сүүлд нь би түрүүн хэлсэн. Энэ хуулийнхаа сурталчилгааны тал дээр, олон нийтэд зөв таниулах тал дээр ямар арга хэмжээ авах. Энэ талаар энэ хууль дотор орсон зүйл, заалт байна уу гэсэн ийм гурван асуултыг асууя.

**Г.Занданшатар:** Х.Нямбаатар сайд хариулъя.

**Х.Нямбаатар:** Би Ц.Туваан гишүүний саяын эхний асуусан асуултыг бол яг хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг урамшуулдаг тогтолцоо ер нь

ямар байна гэдгийг асууж байгаа гэж ойлгосон.

Тэгэхээр одоо бол 6 хуулиар урамшууллын тогтолцоотой. Гэхдээ үүнийхээ 2-ыг нь хүчингүй болгочихсон. Энэ урамшуулдаг тогтолцоо бол нөгөө урьдчилсан мэдээлэл аваад урамшуулдаг тогтолцоо.

Өнөөдрийн бидний ярьж байгаа энэ хууль дээр уг шүгэл үлээсэн асуудлаар шүүх эцсийн шийдвэр гаргаад гэмт хэрэг, зөрчлийн улмаас олсон орлогоос нь урамшуулдаг тогтолцоо. Энэ үүгээрээ ялгаатай.

Би хэлье. Товчхон. Сонгуулийн тухай хуульд сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан этгээд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээсэн бол тухайн зөрчлийг мэдээлсэн иргэнд сонгуулийн төв байгууллага тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ гэсэн ийм зохицуулалт байсан. Энэ хүчингүй болсон.

Одоо хүчин төгөлдөр байгаа Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ мэдээллийг иргэдээс төлбөртэй авна. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн мэдээллийн талаарх гэмт хэрэг, зөрчлийг шалгах эрх бүхий байгууллага, иргэдээс төлбөртэй мэдээлэл авч болно гээд ингээд ийм юутай байгаа. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль дээр байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг гээд байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн,

түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодит туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид оногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно гэж байгаа юм.

Мөн Амьтны тухай хуульд яг ийм урамшуулал байгаа. 15 хувьтай.

Цагдаагийн байгууллагын тухай хуульд мэдээллийг төлбөртөө авах зохицуулалтыг тусгаж өгсөн. Гэмт хэргийн талаарх эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн талаарх төлбөртэй мэдээлэл авах тухай зарлаагүй боловч ийм хүсэлт тавьсан тохиолдолд цагдаагийн байгууллага тэр мэдээлэл өгсөн этгээдэд бас төлбөр төлөх ийм зохицуулалтыг хийж өгсөн байгаа.

Мөн Татварын ерөнхий хуульд уг нь энэ татварын орлоготой холбоотой татвараа нуусан, бууруулан тайлагнасан тохиолдолд ийм урамшуулалтай байсан чинь энэ хуулийг хүчингүй болгочихсон.

Одоо ингээд 4 хуулиар гэмт хэрэг, зөрчлийн талаарх төлбөртэй мэдээллийг урьдчилсан байдлаар олгож байгаа.

Үлдсэн асуултад ажлын хэсэг 80 дугаар микрофоноос хариулах уу.

**Т.Аюурсайхан:** 80 дээр Төрийн нарийн хариулъя.

**П.Сайнзориг:** Ц.Туваан гишүүний асуудал чухал асуудал.

Яах вэ, хууль гаргаад батлаад орхих ерөөсөө байж болохгүй. Хуулиа байнгын тордож зөв хэрэгжиж байна уу, хууль хэрэгжилттэй холбоотой алдаа оноо, мэдээллээ цуглуулж, үүнийгээ улам яаж сайжруулах вэ. Эргээд одоо юу гэдэг юм хуулийн нийгэм, эдийн засагт үзүүлж

байгаа үр нөлөөг бид тогтмол үнэлж байх асуудлыг та ярилаа.

Үүнийг хуулийн дагуу тодорхой эрх зүйн харилцаанд оролцогч иргэд энэ хуулиа өөрөө зөв мэдээлж байна уу, хэрэглэж чадаж байна уу гэдэг асуудлыг соён гэгээрүүлэх, ойлгуулах асуудал чухал байгаа.

Тэгэхээр ер нь зүгээр үүнийг бид бас яамнаас ч гэсэн яриад байгаа. Манай сайдын бодлого. Бид хэд бас тал талын л яамуудтай ярьж байна. Ер нь одоо юу гэдэг юм насанд хүрсэн хүнтэй энэ хуулийг анхнаас нь зөв буруу гэдэг энэ ойлголтыг суулгах гэж бид хэд явж байгаа бол хүүхэд байхаас нь эхлээд аливаа энэ шударга бус зүйлтэй эвлэрдэггүй байх, зөв бурууг ялгаж салгадаг тэр мотивац, тэр хүмүүжлийг бид боловсрол, гэр бүлийн түвшинд нь анхааруулахад нь тал талын буюу нийгмийн бүх талын оролцоог л хангасан, үүнийг чиглэсэн боловсролын болоод энэ гэр бүлийн орчин дахь эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлагын оролцоог нэмэгдүүлэх чиглэл дээр анхаарах ёстой юм байна. Энэ дээрээ төр засаг нь ч гэсэн тодорхой бодлогоор ойлгуулах, соён гэгээрүүлэх ийм чиглэлтэй байхгүй бол нэгэнт нас бие төлөвшчихсөн хүмүүстээ эргээд асуудлуудыг ойлгуулна гэдэг маш бэрхшээлтэй бөгөөд цаг хугацаа, зардалтай асуудал байна гэдэгтэй таны хэлж байгаа энэ саналтай 100 хувь санал нэг байгаа.

Тэгэхээр бид хэд боломжит бүх хэлбэрээр иргэдэд энэ мэдээллийг хүргэх, иргэдийнхээ энэ хууль эрх зүйн ойлголтыг нэмэгдүүлэх. Эргээд энэ буруу мэдээллээс бусдыг хохироочих вий гэдэг ч гэсэн энэ ойлголтыг нь зөв өгч байж бас энэ хууль хэрэглээний одоо зөв хэрэгжүүлэх нөхцөл болж бүрдэнэ гэдэгтэй санал нийлж байна. Тантай.

Сангийн яам мэдээж энэ асуудлыг тодорхой зарчмын хувьд дэмжиж байгаа.

Бид хэд тодорхой эд хөрөнгө хураагдаад улсын төсөвт орж ирсний.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Одоо Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэд асуулт асууна.

**Ш.Раднаасэд:** Хоёр, гурван тодруулах зүйл байна.

Нэгдүгээрт, өнөөдөр яг Авлигатай тэмцэх газарт ард иргэдээс утсаар болон бичгээр жилд ер нь ойролцоогоор хэчнээн гомдол, мэдээлэл авч байна. Тэрний яг хэдэн хувь нь хэрэг болж үүсэж шалгагдаж, хэдэн хүн шүүхээр шийтгэгдэж байна.

Одоо бол гэмт хэргийн мэдээллийг худалдаж авах. Сая Х.Нямбаатар сайд хэллээ. Тогтолцоо бол байгаа. Тэгээд эргүүлээд мэдээлэх, хариу мэдээлэх тийм тогтолцоо байдаггүй. Энэ хуулиар жоохон хаалтууд хийсэн байна.

Одоо энэ дотор чинь зөвхөн албан тушаалын асуудал биш болчихоод байна шүү дээ. Одоо энэ зөвлөл гэж байгуулагдах юм байна. Мөнгөн урамшуулал олгох, хуваарилах. Энэ дотроос чинь харахад гаалийн байгууллага, бусад байгууллагууд ороод эхэлж байна.

Тэгээд наадах чинь гэмт хэргийн талаарх мэдээлэл. Энэ дотор нь албан тушаалтны авлига, хээл хахууль, албан тушаалаа урвуулсан, хэтрүүлсэн. Дээрээс нь татварын асуудал явах юм байна. Гаалийн асуудал явах юм байна. Гэх мэтчилэнгээр олон асуудал явах юм байна.

Тэгээд яг энэ бусад байгууллагууд дээр чинь ийм тогтолцоо байна уу? Тогтолцоо байна уу? Энэ бусад байгууллагууд дээр. Энэ 6.1-д заасан байгууллага зөвхөн гомдол гаргана гээд байгаа юм. 6.1-ийг нь харахаар бараг бүх төрлийн төрийн байгууллага гомдол

авахаар болчхоод байна. Энэ дээр чинь дахиад цаана нь явах юм бол албан хаагчийн ёс зүйн асуудал, шан харамжийн асуудал. Тэгээд их олон бэлэг сэлт юу байдаг юм. Бүх зүйлийн талаар гомдол, мэдээлэл юм явах гээд байна л даа.

Дараагийн нэг зүйл бол өнөөдөр Авлигатай тэмцэх газар 280 гаруй хүн ажиллаж байгаа. Энэ мэдээлэлтэй холбоотойгоор нийгэмд явж байгаа бүх зүйлийг тодорхой мөнгөн урамшуулал авах зорилгоор маш олон хүн бичиж өгнө. Энэ бүх мэдээллийг шалгах бүрэлдэхүүн чинь хүрэх үү? Бэлтгэл ажил чинь байна уу? Одоо нийгэм чинь үгээр үг хийдэг болчхоод байна шүү дээ. Үйлдлүүдээ шалгаж чадахгүй байгааг энэ гишүүд яриад байгаа юм. Гэмт үйлдлүүдийг нь шалгаж чадахгүй байхад үгээр үг хийж явдаг болчихлоо шүү дээ.

Одоо энэ П.Сайнзоригийн тэр нэг жүжигчдийг алиалагч гээд хэлсний төлөө жагсаал цуглаан ч хийж байх шиг. Гэх мэтчилэнгээр энэ хэвлэл мэдээлэл. Ер нь ялангуяа энэ сошиал орчинд явж байгаа мэдээллүүдийг чинь бүх хүн аваачиж өгнө. Үүнийг шалгуулна гээд. Энэ хууль дээр тэрийг чинь авахгүй тоохгүй л гэсэн байна. Шалгах үүрэгтэй учраас. Ямар нэгэн байдлаар энэ дээр эргэж хариу өгөх ёстой болно. Тэгээд ийм бүтэц, орон тоо, зохион байгуулалтын хувьд үүнийг чинь ингээд орон тооны бус комисс байдлаар гараад үүнийг чинь хийж дийлэх үү, үгүй юу?

Гурав дахь асуулт. Энэ мөнгөн урамшуулал чинь шүүхийн шийдвэр гарсны ар дээр явах юм уу? Эсвэл хохирол гэдэг юм уу? Одоо тэр этгээдээс гэмт хэргийн улмаас олсон орлогыг нь хураасны дараа, эсхүл тэр торгууль, төлбөр төлөгдсөний дараа олгогдох юм уу? Энэ чинь энэ хууль дотор ойлгомжгүй болчхоод байна л даа. Зөвлөл хуваарилна, өргөдлийг нь авна гээд ингээд нэг давхар давхар шат үүсгээд ингээд хийчихсэн.

Үүнийг чинь яг ингээд харахаар, уншихаар яг өнөөдөр үүнийг бариад ингээд хууль хэрэглэе гээд тэгэхэд л энд аягүй их бэрхшээлтэй юмнууд маш их байна л даа. Ийм хэдэн асуулт байна.

**Т.Аюурсайхан:** 84 дүгээр микрофон дээр ажлын хэсэг хариулъя.

**Д.Дуламсүрэн:** Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Авлигатай тэмцэх газар дээр сүүлийн 3 жилийн байдлаар ирсэн өргөдөл, гомдлыг авч үзэх юм бол үндсэндээ 2022 оны 9 сарын 30-н буюу 3 дугаар улирлаар таслаад тоо статистик мэдээ гаргахад 5512 өргөдөл, гомдлыг иргэдээс гомдол, мэдээллийг хүлээж авсан байгаа. Яах вэ, жилээр дунджаар 1500 ч гэж хэлж болохоор ийм хэмжээний өргөдөл, гомдол хүлээж авч байна.

Үүнээсээ манай гэмт хэргийн шинжтэй буюу манай Мөрдөн шалгах хэлтсийн шалгасан хэрэг 4000 орчим, 2020 онд 1331, 2021 онд 1307, одоо 2022 оны 9 сарын 30-ны байдлаар 1278 ийм гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг Мөрдөн шалгах хэлтэс шалгасан байна.

Үүнээсээ 2227 орчим хэргийг нь шийдвэрлэсэн байна буюу нийт шалгасан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийнхээ 58 хувийг шийдвэрлэсэн гэсэн ийм статистик тоон мэдээг манай байгууллага 9 сарын 30-ны байдлаар гаргачхаад байж байгаа.

Тэгэхээр ер нь 60-аас 70 хувь нь гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол байдаг юм байна. Түүнийхээ 58 орчим хувийг шийдвэрлэж байгаа гэсэн мэдээ байгаа.

Ачааллын хувьд Авлигатай тэмцэх газрын 280 гаруй хүн бүгдээрээ мөрдөн



шалгах ажиллагаа хийдэггүй шүү дээ. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр. Мөн хяналт шалгалтын буюу хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулах, түүний хяналт шалгалтыг хийх гээд бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ийм албан хаагчид хамаардаг.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл хэрвээ батлагдах тохиолдолд мэдээж энэ байгууллагын бүтэц, орон тоо, бусад манай байгууллага ч гэлтгүй зөвхөн Авлигатай тэмцэх газар биш, энэ Улсын Ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комисс, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гээд одоогоор 6 байгууллагын хүн хүч, нөөцийн асуудал тодорхой түвшинд хөндөгдөж, үүнийхээ үндсэн дээр нөгөө албан хаагчдыг чадавхжуулах энэ асуудлуудыг сая Ц.Туваан гишүүний ярьж байсантай холбогдуулж энэ ард иргэдийг ойлгуулах, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, ойлгуулах энэ ажил зэрэгцэж явах ёстой.

Ачааллын хувьд АТГ-ын мөрдөгчид өндөр ачаалалтай ажилладаг гэдгийг бид тогтмол тийм ээ эрх бүхий байгууллага, холбогдох байгууллагуудад.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** 80 дээр нэмээд тодруулчих. Ажлын хэсэг. П.Сайнзориг.

**П.Сайнзориг:** Ш.Раднаасад гишүүний гурав дахь асуултад хариулья.

Ерөнхийдөө хуулийн төслийн 16 дугаар зүйл дээр дараах тохиолдолд шүгэл үлээгч эрх бүхий байгууллагад мөнгөн урамшуулал авах өргөдлөө буюу хүсэлтээ гаргаж болно гэж байгаа юм.

Нэгдүгээрт, Авлигын эсрэг хуулийн 33.2-г заасны дагуу улсад хохирол учруулсан этгээдийн эд хөрөнгө, орлогыг хураасан.

Хоёр дахь нь, хуульд заасны дагуу зохих торгох, ял торгох шийтгэл оногдуулсны дүнд төлөх ёстой байсан төлбөрийг улсын төсөвт төлөвлөсөн гэдэг ийм нөхцөлүүд бүрдсэний дараа буюу шүүхээр тэр тухайн мэдээллийн дагуу шалган шийдвэрлэх ажиллагаа явж яг эцэслэгдсэний дараа энэ урамшууллын асуудал яригдах юм. Түүнээс биш юу гэдэг юм эцэслэгдээгүй, эсвэл нэгэнт хэрэгсэхгүй болсон, гомдол, мэдээллийг шалгаад буруугүй байна гэдгийг нь тогтоосон ч гэдэг юм уу ийм зүйлүүд дээр урамшуулал олгох асуудал байхгүй.

Тэгэхээр аливаа зүйлийг яг эцсийн шийдвэр гарсны дараа энэ тал талын байгууллагууд буюу бүрэлдэхүүнд нь прокурорын байгууллага, авлигатай тэмцэх, Хүний эрхийн Үндэсний Комисс, цагдаа, гааль, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөлөл бүхий ийм мөнгөн урамшууллын зөвлөл хуралдаж тодорхой шийдвэрүүдийг гаргах юм.

**Т.Аюурсайхан:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо үг хэлэх гишүүд нэрээ өгье. Б.Баттөмөр гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдийн Адьшаа үг хэлнэ.

**Ш.Адьяшаа:** Энэ Засгийн газраас Шүгэл үлээгчийн тухай хуулийг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэх үед өөрийн байр сууриа илэрхийлсэн.

Энэ хуулийн үзэл баримтлалын талаар Хууль зүйн байнгын хороо хойш хэлэлцсэнээс хойш олон судалгааны байгууллагууд, хуульчид, иргэдтэй уулзаж тодорхой санал, хүсэлтүүдийг авлаа.

Энэ дээр энэ хуулийг батлан гаргах асуудал Монгол Улсын тухайд олон улсын өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, өнөөдөр

нийгэмд үүсээд байгаа нөхцөл байдал, авлигын индексийг бууруулах, авлигатай тэмцэх энэ асуудалд иргэд, олон түмний оролцоог оролцуулах энэ асуудал Монголын төр хуулиар дамжуулж шийдвэр гаргах гэдэг зөв гэсэн ийм бодолтой явж байсан.

Би Хууль зүйн байнгын хороонд энэ хуулийг хэлэлцэхийг дэмжиж байсан юм. Тэгээд өнөөдөр энэ олон түмэнтэй уулзаад хэвлэл мэдээлэл, бусад газраас судалгаа авахаар энэ хуулийг ер нь буцааж дахиж боловсруулж орж ирэх ийм шаардлага байна гэсэн ийм бодолтой байна. Бодолтой байна.

Энд хоёр их болгоомжлол байна. Нэгдүгээрт нь, шүгэл үлээгчид олгох мөнгөн урамшууллын асуудал хэрэгжүүлэх ийм эрх зүйн үндэс, эдийн засгийн боломж нь их хомс юм гэсэн ийм ойлголттой байгаа.

Энд энэ мөнгөн урамшууллыг торгуулиас гаргасан торгуулийн шийтгэврийн 10 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөөр л санхүүжүүлнэ гэсэн нэг ийм ойлголт байгаа учраас аливаа мөнгөн урамшууллыг энэ торгууль тавьж, шийтгэвэр гаргаж байж ингэж орлогын эх үүсвэрийг олно гэдэг энэ асуудал байж болохгүй асуудал.

Дээр нь өнөөдөр энэ төрийн тусгай чиг үүргийн байгууллага олж авсан мэдээллээ, албаны шугамаар олж авсан мэдээллээ нийтийн эрх ашгийн төлөө нийтэд ил тод болгож одоо шүгэл үлээнэ гэж ингэж ойлгож байгаа.

Энэ бол яав ч байж болохгүй асуудал. Өнөөдөр хүчний байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх талаар бусдыг чагнадаг, тагнадаг хуулийн эрх хэмжээтэй хүмүүс байна шүү дээ. Тэгээд өнөөдөр энэ эрх хэмжээнийхээ хүрээнд олж авсан мэдээллээ нийт иргэдийн эрх ашгийн

төлөө гэдэг ийм үндэслэлээр олон нийтэд шүгэл үлээнэ гэсэн энэ зохицуулалт чинь эргээд бусад органик хуультайгаа зөрчилдөж байна. Зөрчилдөж байна. Жишээлэхэд, Авлигатай тэмцэх газрын ажилтан өөрийнхөө гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан мэдээллээ нийт улсын ашиг сонирхлын төлөө, нийтийн төлөө гээд олон нийтэд зарлаад илрүүлээ гэж бодъё. Гэтэл тэр мөнгөн урамшуулал авах ажлыг гол зохион байгуулах комиссын гол асуудал нь Авлигатай тэмцэх газар, прокурор, бусад байгууллагууд байна.

Ийм зөрчилтэй нь асуудлаа эргэж оруулж ирье ээ. Ингээд өнөөдөр олон улсын өмнө хүлээсэн үүрэг ч гэдэг юм уу, үүнийг нийгэмд өнөөдөр анхаарал татаж байгаа асуудал ч гэдэг юм уу, ийм үндэслэлээр өнөөдөр хөрсөнд буугаагүй, дээр нь биелэгдэх боломжгүй ийм хуулийг бид баталж гаргаад, олон нийтийг талцуулаад, бүр нөгөө нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохолно гэгч ийм байдал бий болно.

Бид авлигатай тэмцэх ёстой. Олон нийтийг энд оролцуулах ёстой. Тэр үнэн мэдээлэл өгсөн хүмүүсийг урамшуулах ёстой. Гэхдээ үүнийг тооцоо, судалгаатай бусад органик хуультайгаа зөрчилдөхгүйгээр хүний эрх, бусад нөхцөл байдал дээр дүгнэлт хийж өнөөдөр энэ хуулийг боловсруулж гаргавал жинхэнэ өнөөдөр нийгэмд хэрэгцээтэй байгаа, нийгэмд шаардагдаад байгаа өнөөдөр тэр мэдээллийг олон нийтийн төлөө, улсын ашиг сонирхлын төлөө үнэхээр шийдэх ийм шаардлагыг л энэ хуулиар шийдэх ийм хөрс чинь бүрдэх юм гэдгийг. Ийм ойлголттой байгааг энд тэмдэглэж хэлье.

**Т.Аюурсайхан:** Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр үг хэлнэ.

**Б.Энхбаяр:** Миний хувьд шүгэл үлээгчийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаа.

Яагаад гэхээр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ энэ авлигатай тэмцэх асуудлыг нэлээн анхаарч, энэ хуулийн төслийг Улсын Их Хуралд бас өөрийн биеэр өргөн барьсан улс төрийн манлайлал үзүүлж байгаа.

Энэ улс төрийн зориг, манлайллыг дэмжих Улсын Их Хурал үүрэгтэй. Энэ хүрээндээ бас гишүүдийн хэлж, болгоомжлуулж, сануулж байгаа асуудлыг хэлэлцүүлгийн шатанд нэлээн анхаарч байж шийдэхгүй бол бас болгож болохгүй.

Ялангуяа жишээлбэл сая Ш.Адьяа гишүүн хэлж байна. Энэ улсын нууцтай холбоотой гүйцэтгэх ажлын мэдээ баримтыг энэ Шүтэл үлээгчийн хууль гэдгээр далимдуулж төрийн нууц арга хэрэгсэл, ийм бүрэн эрхээр олж авсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж ил гаргаад ашиг хонжоо олох зорилгоор мөнгөө хувааж авдаг ийм үүд хаалгыг нээвэл энэ эсрэгээрээ Монголын төрийн хар хайрцгийн бодлого, тусгай албадын үйл ажиллагаанд нэн хохиролтой ийм үүд хаалгыг нээнэ.

Одоо Улсын Их Хурал, Засгийн газар сүүлийн үед энэ албан тушаалтнууд зарим сайтаас энэ төрийн нууц мэдээллийг олж авдаг шүү дээ. Бид нар. Юу болох гэж байгаа юм бол, яасан юм бол. Тэр сэтгүүлч юу байна вэ гэхээр цаад хууль хяналт болон гүйцэтгэх ажилтай харьцдаг албан тушаалтнуудтай холбоотой байна гэсэн үг. Ийм байдлаар мэдээ мэдээллийг эхлээд олон нийтэд сэтгүүлчээр гаргуулж байгаад тэгээд буруутан болгож олны өмнө зарлаж байгаад ажил хийдэг хуулийн ийм сүлжээ байгаа. Үүнийг бид нэг их яриад байхгүй олон жишээ байгаа.

Тэгэхээр одоо энэ гүйцэтгэх ажилтнууд маань юу болох вэ гэхээр нэг сэтгүүлчтэй юм уу, нэг хөндлөнгийн нөхөртэй хуйвалдаад нөгөө олж авсан

утасны яриа, мэдээллээ дээд удирдлагатай танилцуулж хууль ёсны дагуу шийдвэрлэх гэхээсээ илүүтэй ашиг олох, мөнгө олох зорилгоор зориуд гадагш нь өөр хүнээр гаргаж сүвлэж байгаад тэгээд нөгөө мөнгөө. Нөгөө сэтгүүлч нь шантаажаа хийнэ. Тэнд хаалтын гэрээ хийгдэнэ. Тэгэнгүүт нь олж авсан мөнгөө хувааж авдаг ийм сүлжээ рүү орно.

Энэ сүлжээ бол одоо бидний тэр хүссэн үр дүнд хүрэхгүй. Хэрэг дээрээ энэ мэргэжсэн тусгай албадын хүчийг нэлээн суллана шүү. Үүнийг бодох ёстой.

Ямар тохиолдолд энэ гүйцэтгэх ажилтнуудын мэдээллийг хамгаалах вэ гэдэг асуудал маш нарийн заагтайгаар хуульчлагдах ёстой. Маш нарийн заагтайгаар. Тухайлбал, Америкийн сенат дээр сонсгол болж байгаа нэг асуудал бол Д.Трамп Ерөнхийлөгч Украины ерөнхийлөгч В.Зеленскийтэй утсаар ярилцахдаа миний өрсөлдөгч Байдены хүүгийн талаарх Украинтай холбоотой бизнесийн талаар мэдээллийг надад өгчих өө. Та хэд олоод өгчих. Надад өгчих. Тэгвэл дэмжлэг үзүүлье гэдэг утсаар ярьсан яриаг ил болгосон. Үүнийг хэн ил болгосон бэ гэхээр Тагнуулын төв газрын ажилтан ил болгосон. Өөрөө тэр утасны яриаг хариуцаж байсан ажилтан. Яагаад гэхээр манай улсын төрийн тэргүүн өөр улсын төрийн тэргүүнтэй улс төрийн өрсөлдөгчөө намнах зорилгоор, улс үндэсний эрх ашгаас урвасан ийм яриа хэлцэл хийлээ гэдэг байдлаар олон нийтэд гаргаж шүтэл үлээсэн.

Тэр ажилтан хэзээ ч энэ улсын нууцыг задлахгүй гэдэг тангараг өргөчихсөн ийм тусгай албан хаагч. Ийм тохиолдлууд дээр шүтэл үлээж байгаа хүнийг яах юм тэгвэл. Үүнийг хамгаалах ямар эрх зүйн хөшүүрэг, хамгаалалт байна вэ? Улсын нууц задалсан гэдгээр тэр хүнийг шоронд явуулчихгүй, явуулах

нөхцөл байдал одоо ч байна. Ийм тохиолдолд хэн ч шүгэл үлээхгүй.

Тийм учраас би хэлээд байгаа юм. Улсын нууц, албаны нууц дээр шүгэл үлээх асуудлыг маш нарийн тодорхой болгохгүй бол энэ бол эсрэгээрээ Монголын төрийн дархлаа, хар хайрцгийн бодлогыг алдагдуулна. Нөгөө талаараа мөн хулгайчид албаны нууц гэдгээр завшиж үлдэх ийм нигууртай.../минут дуусав/

**Т.Аюурсайхан:** Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр үг хэлнэ.

**Б.Баттөмөр:** Энэ Шүлэг үлээгчийн тухай хууль орж ирж байгаа нь зөв зүйтэй. Засгийн газраас өргөн барьсан байна.

Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцод энэ талаар бид үүрэг хүлээчихсэн байгаа. “Алсын хараа-2050” болон Засгийн газрын мөрийн хөтөлбөр, авлигатай тэмцэх хөтөлбөрүүдэд энэ талаар орчихсон байгаа.

Ер нь энэ шүгэл үлээнэ гэдэг асуудал Монголд байсан. Эрх зүйн зохицуулалт байгаагүй. Одоо өнөөдрийн эрх зүйн зохицуулалт нь л бий болох гээд л одоо бид ингээд ярьж байна л даа.

Энэ Монгол Улсын авлигын индекс улам хойшоо яваад байгаа шүү дээ. Улам ихсээд байна гэсэн үг. Хаана хөгжил сул байна тэнд амьсгал их байдаг. Хаана хүнд суртал байна тэнд авлига их байдаг. Авлига дээрээсээ доошоогоо чиглэлтэй байна. Бид хэлдэг шүү дээ. Шатыг доороос нь цэвэрлэдэггүй, дээрээс нь цэвэрлэдэг гэж. Үнэхээр Монголд энэ авлига, хүнд суртал энэ хууль бусыг үнэхээр газар авчихсан байгаа шүү дээ.

Тийм учраас энэ хууль бол үнэхээр их ач холбогдолтой ийм хууль байгаа юм. Манай зарим гишүүдийн ярьж байгаа энэ

болгоомжлолтой санал нэг байна. Маш сайн дахиж үзэх хэрэгтэй. Одоо энд ер нь дэлхийн их олон орны юуг судалж үзлээ л дээ. Энд Шведийн, Мексикийн, Италийн гээд их олон орны хуулиудад үүнийг маш тодорхой заачихсан.

Америкийн Нэгдсэн Улсын Эрүүгийн хуулийн 18 дугаар хэсэгт шүгэл үлээгчид өс хонзонгийн сэдлээр хандах нь эрүүгийн гэмт хэрэг гээд ингээд заачихсан байж байгаа. Япон, Өмнөд Солонгосын энэ шүгэл үлээгчийн хуулиуд маш тодорхой, тодорхой ингэж зааж өгсөн ийм байдаг. Энэ нэг жишээ хэлэхэд Нидерланд Улсын хуулиар 2016 оны 07 дугаар сарын 01-нээс эхэлж байгууллага, компани 50 буюу түүнээс дээш ажиллагсадтай бол заавал дотроо шүгэл үлээгчийн орон тооны нэгж буюу албатай байхаар хуульчилсан байгаа.

Олон улсын хэмжээнд юу вэ гэхээр энэ бол үнэхээр бас байдаг. Үүнийг дэмждэг. Үүний үр дүн гардаг ийм л юм байна л даа.

Тэгэхээр манайд юу гэхээр энд болгоомжилсон юмнууд байна л даа. Тодорхой мэдээлэлтэй хүмүүс тэр мэдээллээ зардаг. Өөрийн холбоотон улсууддаа өгч шүгэл үлээлгээд ашиг орлогоо хуваадаг. Өс хонзонгийн сэдэлтээр хийдэг. Ажлаас халагдчихаад тэгээд тэрнээсээ болоод юм уу, хариуцлагагүй байдлаасаа болоод ямар нэгэн хариуцлага хүлээх тэрнийхээ хариу болгож шүгэл үлээдэг. Маш их ийм ийм зүйлүүд байна л даа.

Японы, Солонгосынх гэхээр зэрэг бас байгаль орчны байдал, аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүн, эрүүл мэнд гээд. Японых бол ингээд энэ чиглэлд их түлхүү оруулсан.

Солонгосын болохоор зэрэг мөн ялгаа байхгүй эрүүл мэнд, байгаль орчин, нийгмийн аюулгүй байдал, хэрэглэгчийн

ашиг сонирхолд нийцээгүй, шударга өрсөлдөөнтэй холбоотой гээд ингээд их тодорхой, тодорхой чиглэлүүдээр ингээд үлээдэг л юм байна л даа.

Тийм учраас бид энэ чиглэлээр их сайн бодож хийх ёстой. Энэ хуулийн төсөлд нэг хэдхэн байгууллагын нэрийг заачихсан байгаа юм л даа. Энэ юу гэхээр зэрэг заавал хохирол материаллаг байх албагүй. Материаллаг бус хохирлууд байна шүү дээ. Хүний оюун санаатай холбоотой, гүтгэсэн, доромжилсон. Тэгэхээр үүнийг их сайн ялгаж салгах ийм шаардлагууд байна.

Энэ 1.5 тэрбум хүртэл төгрөгийн урамшуулал байх юм байна л даа. Би үүнийг ямар тооцоогоор хийсэн юм бол доо. Үүнийгээ дахиж тооцооч. Тухайлбал, Өмнөд Солонгос гэхэд дэлхийн 10 дахь эдийн засаг шүү дээ. Энд 200 сая вон байна. Дээд хэмжээ. 200 сая гэдэг чинь монгол төгрөгөөр 500 сая төгрөг шүү дээ.

Тэгэхээр 1.5 гээд заачихсан. Солонгосын эдийн засаг юу билээ. Монголын эдийн засаг чинь 15 тэрбум доллар шүү дээ.

## ЗАВСАРЛАГА

**Т.Аюурсайхан:** Гишүүд танхимдаа яаралтай цуглаарай. Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Тэгээд энэ тооцоо энэ тэрээ их сайн хийхгүй бол ерөөсөө болохгүй. Ийм юмнууд байгаа.

Тэгээд жишээлбэл, Америкийн Нэгдсэн Улсад гээд ингэтэл 1 сая доллароос дээш бол 10 хувь хүртэл. Шаардлагатай бол 30 хувь хүртэл гээд ингээд бүр интервалтай ингээд заачихсан байгаа.

Гэх мэтийн асуудлуудыг олон талаас нь үзэж, ингэж хийх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Энэ бол үнэхээр зүйтэй. Одоо тэр хэлэлцэх явцад нь ажлын хэсгүүдийг нь байгуулаад, мэргэжлийн улсуудыг нь яагаад, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаад, үүнийг олон талаас маш сайн шүүж байж гарах шаардлагатай. Хэлэлцэхийг дэмжиж байна.

**Т.Аюурсайхан:** Гишүүд үг хэлж дууслаа. 13.00 цаг өнгөрсөн байна.

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулж байна. Үдээс хойших нэгдсэн хуралдаан 14.00 цагаас санал хураалтаар эхэлнэ.

Ажлын хэсгийг оруулъя. Гишүүд байраа эзлээрэй. Одоо санал хураалт явуулахад бэлэн болсон байна. Үгээ хэл дээ, таны зардлыг төлье за,

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гишүүд асуулт асууж, хариулт авч дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Ер нь Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулиа дэмжээд. Ер нь тэгээд бас процессыг нь. Хэлэлцэх эсэхийг нь дэмжчихээд дараа нь процесс энэ тэрийг нь тодорхой болгох энэ тэр асуудлуудаа.

Ажлын хэсэг байгуулж байгаа. Ажлын хэсгийн гишүүдэд Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Г.Амартүвшин гишүүд нар ороод тэгээд процесс энэ тэрийг нь нарийвчлаад юмнуудыг нь яая.

Одоо санал хураалт явуулна. Санал хураалт. Бүртгэлийн санал хураалт. Өнөөдрийн анхны санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт явуулж байгаа шүү.

Энэ эсрэг бүртгэлд орохгүй байгаа улсууд орж ирж санал хураалтад оролцоорой. Х.Нямбаатар сайд ажилтай байсан. Бусад нь Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль дээр санал хураалтад оролцоно шүү.

Одоо санал хураалт явуулна. Ингээд Байнгын хорооны саналаар Шүгэл

үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

26 гишүүн дэмжиж, 59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Үзэл баримтлалын хүрээнд гэж хэлсэнгүй шүү. Хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон. Анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд.

Энэ процесс нь эрх зүйн байдал, процесс хоёрыг нь хамт л хийхгүй бол манайх байна шүү дээ. Б.Энхбаяр гишүүн ээ. Тэр процессуудыг нь хийж өгөхгүй бол дандаа хуулиуд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх процессыг хуультай адил хийхгүй бол болохгүй.

Дараагийн асуудалд орно.

*Хоёр.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж  
2022.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
хэлэлцэх эсэх/*

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэнэ. Хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Бөхчулууны Пүрэвдорж гишүүн танилцуулна.

Түр хүлээж байгаарай. Зочид танилцуулаадахъя. Тэгээд дараа нь төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

Ингээд зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа, Хишгээгийн Нямбаатар нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд улсынхаа сан хөмрөгийг арвижуулах үйлст нь өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүнийг индэрт дурдаж байна. Хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Миний бие Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан.

2017 оны 01 сарын 01-нээс Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Энэ хуульд “гүтгэх” гэдэг заалт байсныг олон нийтийн эсэргүүцлийн үр дүнд, ялангуяа хэвлэл мэдээллийн байгууллагад энэ “гүтгэх” гэдэг заалтаар маш их олон удаа прокурорын хяналт, шүүхийн шийдвэргүйгээр зөрчлийн хэрэг үүсгэж торгож, эхний удаа 100, дараагийн удаа 500, түүнчлэн дахин давтал баривчлах ялыг оноож байсан.

Тийм учраас олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарч энэ Зөрчлийн

хуулиас 2020 оны 01 сарын 10-нд батлагдсан хуулиар энэ “гүтгэх” гэдэг заалтыг Зөрчлийн хуулиас авч хаясан юм.

Гэвч энэ “гүтгэх” гэдэг заалтыг авахын зэрэгцээгээр зэрэгцүүлээд тухайн үед Хууль зүйн сайд байсан Ц.Нямдорж Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр хүндэд халдах гэдэг заалтыг оруулан, үүнийгээ зөрчих юм бол Зөрчлийн тухай хуулийн 5.9-д заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол 100 мянган төгрөгөөр торгох, давтан үйлдвэл 500 мянган төгрөгөөр торгох. Хэрвээ дахин давтан үйлдвэл баривчлах ийм заалтыг оруулсан.

Энэ нь иргэдийн үг хэлэх эрх чөлөөг боогдуулсан. Мөн түүнчлэн аливаа дарга албан тушаалтны гэмт үйлдлийг олон нийтийн хэвлэлийн сошиал платформ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлснийхээ төлөө хариуцлага хүлээдэг ийм зүйлийг нийгэмд бий болгосон юм.

Тэгэхээр энэ хуулийг өргөн барьснаараа аливаа нэгэн бусдын нэр хүндэд халдах тэр заалтыг огт зохицуулалтгүй үлдээхгүй байгаа. Өөрөөр хэлбэл хэрвээ аливаа нэгэн албан тушаалтан болон иргэн хүн миний нэр хүндэд онц ноцтойгоор халдлаа гэж үзэх юм бол Эрүүгийн хуулиар шийдүүлээд тэр хүнийгээ эрүүгийн ял шийтгэл оногдуулах ийм боломж байгаа.

Хэрвээ миний нэр хүндэд халдлаа гэдгийг Иргэний хуулиар тодорхой хэмжээгээр шийдээд Иргэний хуулийн дагуу нэр төрд нь халдсан гэж шүүх тогтоох юм бол буцаагаад өөрийн нэр хүнд тэдэн төгрөг гэж үнэлээд буцаагаад алдар хүндээ сэргээх ийм боломжийг бүрдүүлж байгаа юм.

Тийм учраас энэ иргэдийн үг хэлэх эрх чөлөөг ингэж хааж боох нь нийт нийтийн бухимдлыг илүү өргөн хүрээнд бий болгох ийм нөхцөл байдал руу аваачиж байгаа тул. Мөн түүнчлэн прокурорын хяналт, шүүхийн шийдвэргүйгээр хүний эрхэнд халдаж байгаа тул Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1 дэх заалт буюу үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр хүндэд халдах энэ заалтыг хассанаар иргэд илүү чөлөөтэй үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх ийм боломжийг бүрдүүлэх юм.

Ийм учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг миний өргөн барьсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг дэмжиж өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Энэ Татварын албаныхандаа шинэ үеийн татварын алба үүсэж хөгжсөний 30 жилийн ой 2021 онд тохиосон.

Тэгээд энэ жил 31 жилийн ой тохиож байна. Монгол Улсад татварын алба 800 гаруй жилийн тэртээ үүссэнийг гадаад улсуудын архив, бичиг баримтаас олдож байгаа “их засаг, татвар, гувчуур” гэсэн гурван үгээр тодорхойлж болно. 800 жилийн түүхтэй ийм татварын алба үүссэн юм билээ.

Ингээд Та бүхэндээ ойн мэндчилгээ бас өргөн дэвшүүлье. /алга ташив/

Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Энхтайван Бат-Амгалан танилцуулна.

**Э.Бат-Амгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд иргэн өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандана гэж заасан нь иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан төдийгүй олон иргэд хариуцлага хүлээж байгаа учраас тус зохицуулалтыг хасах шаардлагатай гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж тооцоолсон байна.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар иргэн олон төрлийн үүрэг хүлээдэг бөгөөд хүний нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах гэсэн заалтын дагуу хэдэн хүнд торгууль оногдуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн энэ зохицуулалтыг хасах хууль зүйн үндэслэлийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хүний нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үүрэг



учраас тус зохицуулалтыг хасахыг дэмжихгүй байгаагаа илэрхийлж, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн төсөлд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчих зөрчлийн талаарх хэт ерөнхий томъёоллыг засаж, зөвхөн гуравхан үйлдлийг зөрчилд тооцохоор тусгасан нь энэ хуулийн төсөлтэй үзэл баримтлалын хувьд адил төдийгүй уг асуудлыг шийдвэрлэхээр байгаа тул Зөрчлийн тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Зөрчлийн тухай хуульд хүнийг үзэл бодлоо илэрхийлсний төлөө торгох шийтгэл байхгүй бөгөөд хууль хяналтын байгууллагын албан хаагчид хуулийг гажуудуулсан байж болзошгүйг онцолж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн үүргийг бататгасан зохицуулалтыг хасах хуулийн төслийг дэмжихгүй байгаа талаар тус тус санал хэлсэн болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд

байна уу? Хишгээгийн Нямбаатар гишүүнээр тасаллаа.

Эрхэм гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуулт асууна.

**С.Ганбаатар:** Би маш товчхон нэг асуулт асуучихъя.

Ер нь энэ хуулийг Засгийн газрын хуралдааны тэмдэглэл дотор Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1 дэх энэ заалтыг үзэл баримтлалыг бол нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах гэснийг дэмжиж байгаа хэдий ч гэсэн дээ яагаад энэ үзэл баримтлалд бүрэн нийцнэ гэсэн мөртлөө хуулийн 31.1-ийг хүчингүй болгох шаардлагагүй гэжээ гэж нэг Засгийн газрын хуралдааны тэмдэглэл дээр заачихсан байна.

Тэгээд ямар үндэслэлээр ингэсэн юм? Үүнийг хоёрдмол утгагүйгээр яаж ойлгох ёстой вэ?

**Г.Занданшатар:** Хууль санаачлагч Бөхчулууны Пүрэвдорж асуултад хариулна.

**Б.Пүрэвдорж:** С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр миний бие ард түмний 10 хууль гэж санаачлаад батлуулахын төлөө явж байгаа.

Тэгэхээр энэ хуулиуд дээр ихэвчлэн Засгийн газар ер нь үнэнд гүйцэгдэж дэмждэг мөртлөө тодорхой зарим хэсгийг нь үгүйсгэх ийм хандлага, дэмжихгүй байх саналыг заавал ирүүлдэг.

Гэсэн ч энэ Засгийн газрын санал миний хууль өргөн барих тэр үйл явцад хэдийгээр санал авах эрхтэй боловч тодорхой хэмжээгээр саад болох ийм боломжгүй.

Тэгэхээр урьд нь хэд хэдэн хууль дээр тэртээ тэргүй батлагдах нь тодорхой, ард түмний дэмжлэгийг хүлээчихсэн ийм хуулиуд дээр зэрэгцүүлж Монгол Ардын намын бүлгийнхэн зарим нэгэн гишүүд дээр хууль өргөн бариулах замаар энэ хамтдаа өргөн шийдсэн байдлаар явуулдаг.

Тэгэхээр жишээ нь энэ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль бол ялангуяа ямарваа нэгэн прокурорын хяналт байхгүй, шүүхийн шийдвэр байхгүй, хүмүүсийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх энэ эрхэнд халдаж байгаа. Өөрөөр хэлбэл сошиал платформ дээр аливаа нэгэн даргыг гаргаж байгаа тэр үйлдлийнх нь төлөө, шүүмжилснийх нь төлөө тодорхой хэмжээгээр гомдлуудыг иргэн хүн гаргадаг. Тэр нь буцаагаад нөгөө албан тушаалтан, тэр иргэн хүнийг цагдаад өгөх замаар амыг нь дуугүй болгох ийм нөхцөл байдал руу шилжиж байгаа.

Тэр иргэн хүн ямарваа нэгэн асуудлыг шүүмжилж байна гэдэг чинь тэр даргын зөрчлийг аливаа нэгэн гэмт хэргийг л ил болгож хэлж байгаа. Гэтэл энэ дарга нь буцаагаад тэр хүнийг энэ хуулийн дагуу торгуулж байна гэдэг чинь тэр зөрчлөө нуун дарагдуулах ийм нөхцөл байдал руу. Дээрээс нь иргэдийг ийм нийтийн бухимдал руу хүргэх ийм нөхцөл байдал руу хүргээд байгаа юм.

Тийм учраас өнөөдрийн энэ миний өргөн барьсан энэ хууль Их Хурлаар хэлэлцэгдээд дэмжигдэх нь нэн тодорхой болсон үед Засгийн газраас яг энэ агуулга бүхий заалтыг өргөн барьсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хамтад нь оруулж ирээд ингээд жилийн дараа оруулж ирээд хамтдаа хэлэлцээд явж байна.

Тэгэхээр энэ Засгийн газрын үзэл баримтлалынх нь хувьд дэмжихээд, тэгээд тэр үзэл бодлоо илэрхийлэхдээ

бусдын нэр хүнд халдах энэ заалтыг дэмжихгүй байна гэдэг бол одоо яг сөрөг хүчний хувьд эрх баригчдын Засгийн газраас ирдэг жижүүрийн үг ээ гэж ойлгож болно.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ нарын урилгаар Хэнтий аймгийн музейн ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан ажлын амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

**Б.Энхбаяр:** Энэ хуулийг санаачилж, энэ асуудлыг тойрч Улсын Их Хурал дээр ярих боломж олгосон Б.Пүрэвдорж гишүүндээ баярлалаа.

Би яагаад баярлалаа гэж хэлж байгаа вэ гэхээр уг нь Улсын Их Хурал Зөрчлийн хуулийг гаргахдаа иргэнийг үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө торгоно, шийтгэнэ гэдэг хууль огт гаргаагүй. Ийм заалт байхгүй.

Бид Нэгдсэн Үндэстний Байгууллагын өмнө хүлээсэн үүрэгтэй. Ардчилсан улс орон.

Тэр ч утгаараа хүний үзэл бодлыг шоронжуулахгүй гэдэг дээр Ардчилсан нам ч тэр, Монгол Ардын нам ч тэр аль аль нь манлайлж зогсдог. Ийм шинжийн аливаа өөрчлөлт орохыг бас улдан эсэргүүцэж таслан зогсоодог. Тухайлбал, хаврын чуулганаар доромжлохыг эрүүгийн хэрэгт гэмт хэрэгт тооцёо гэдэг заалтыг

манай парламентын гишүүд нам үл харгалзан таслан зогсоосон.

Гэтэл бид ийм шийтгэл Зөрчлийн хуульд байхгүй байна гэхэд хаанаас яаж. Б.Пүрэвдорж гишүүн судалгаа бид нарт тараасан. Энэ 300 гаруй иргэдийг Зөрчлийн хууль ишилж байгаад торгочихож ээ.

Энэ хэзээ торгочихсон юм бэ гээд энэ судалгааг үзсэн чинь нөгөө КОВИД-ын үеэр торгоод хаячихсан. Хатуу хөл хорио. Иргэдийнхээ амыг үдсэн байна.

Энэ тараасан судалгаанаас бүр нэг гайхал төрүүлсэн юм нь энэ 300 гаруй иргэд хаана ямар цагдаа торгочихов оо гээд үзсэн чинь хамгийн их нь Дорноговь аймгийн цагдаагийн газар 157. Тал нь. Ерөөсөө энэ шийтгэлийн тал нь Дорноговь аймаг торгочихсон байгаад байна л даа.

Дараа нь Баянхонгор аймаг. Дараа нь Сонгинохайрхан дүүрэг. Тэгээд зарим нь болохоор ерөөсөө огт торгоогүй байгаа юм. Зарим аймаг, зарим дүүрэг ерөөсөө огт торгоогүй.

Тэгэхээр энэ асуудал хуульд байна уу, хуулийг хэрэгжүүлэгчдэд байна уу? Тэр дотроо тэр хуулийг хэрэгжүүлж байгаа цагдаагийн даргад байна уу? Энэ хаана ийм нугалаа, завхрал гарчихав аа? Улсын Их Хурлаас баталсан хуулийг мушгин гуйвуулж энэ иргэдийн үзэл бодлоо илэрхийлснийг шийтгэх вэ? Энд харин нухацтай дүгнэлт хийх ёстой.

Ийм боломжийг харин Б.Пүрэвдорж гишүүн энэ хуулийг санаачилснаараа хууль тогтоогчдод олголоо. Хууль тогтоогч бид хууль гаргахдаа алдаа гаргав уу, эсвэл хууль хэрэгжүүлэх явцад алдаа гарав уу? Яалт ч байхгүй энд ар талд нь шийтгүүлчихсэн иргэд байгаад байна. Үүнийг харин илрүүлж гаргаж ирлээ. Энд нь би

Б.Пүрэвдорж гишүүнд баярлалаа гэж хэлж байгаа юм.

Тийм учраас энэ дээр хууль санаачлагч Б.Пүрэвдорж гишүүн бас ямар санал, дүгнэлттэй байгаа юм бол гэсэн ийм асуулт байгаа юм.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулъя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр танд гаргаж өгсөн наадах судалгаа чинь бол Цагдаагийн ерөнхий газраас албан ёсоор надад ирүүлсэн судалгаа.

Хуулийг боловсруулах явцад 2020, 2021 оны Цагдаагийн ерөнхий газрын нийт гаргасан судалгааны дагуу энэ судалгааг албан ёсоор танд хүргүүлсэн. Бүх гишүүдэд хүргүүлсэн байгаа.

Тэгэхээр Дорноговь аймаг 300 гаруй иргэдийн талыг нь торгочихсон байгаа энэ үйл явц бол мэдээж энэ КОВИД-ын үеийн, ялангуяа иргэдийн бухимдалтай холбоотой. Дээрээс нь Замын-Үүдийн бас нэлээн томоохон боомт газар байдаг. Үүнтэй холбоотой нэлээн өндөр торгуулсан. Өөрөөр хэлбэл Замын-Үүдийн төрийн байгууллагын албан хаагчдын нэр хүндэд халдсан. Иймэрхүү, өөрөөр хэлбэл дэг журмыг зөрчсөн энэ асуудлаар нь албан тушаалтнууд гомдол гаргаад үүний дагуу торгуулсан ийм зүйлүүд байгаа.

Нэг сайн зүйл бол Баянзүрх дүүрэг. Таны сонгогдож гарсан Баянзүрх дүүрэг энэ өнгөрсөн хоёр жилийн судалгаан дээр нийтдээ 20 орчим хүнийг торгосон. Өөрөөр хэлбэл энэ торгож шийтгэсэн ийм шийтгэл гаргасан байгаа. Тэгэхээр тэнд иргэдийн эрхийг хамгаалах талаар илүү сайн түвшинд байна гэж үзэж болно.

Та жишээ нь эргүүлээд харах юм бол Сүхбаатар дүүрэг маш их өндөр

хэмжээгээр торгосон байж байгаа. Шийтгэсэн байж байгаа. Тэр хаана хүмүүсийн иргэдийн үг хэлэх, үзэл бодлыг илэрхийлэхийн эсрэг хаана их торгож байна тэнд хүний эрхийн зөрчил маш их явж байна гэсэн ийм тоо статистикийг албан ёсоор харуулж байгаа юм.

Тийм учраас Б.Энхбаяр гишүүний ялангуяа хүний эрхийг дээдлэх, хүний эрхийг хамгаалах тал дээр бас нэлээн хэд хэдэн хуулийг өргөн бариад энэ дээрээ ажиллаж байгаа. Тэгээд энэ хуулийг хэлэлцэх явцад яг энэ асуудлын гүнд ороод хүний эрхийг дээдлэх талаар илүү сайн таныг ажиллаж чадна гэж үзэж байна.

Тийм учраас манай Их Хурлын дарга нар, Байнгын хорооны дарга нар Б.Энхбаярыг энэ ажлын хэсгийн ахлагчаар томилж өгөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хишигээгийн Х.Нямбаатар гишүүн.

**Х.Нямбаатар:** Бид Хууль зүйн байнгын хороон дээр ярьсан.

Тэгээд энэ яах вэ Улсын Их Хуралд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр энэ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчих зөрчил гэдэг тодорхойгүй зохицуулалтыг Засгаас өргөн барьсан төсөлд тодорхой болгоод орж ирж байгаа юм.

Тэгээд бид юу гэж ярьсан бэ гэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа Засгаас барьсан төсөлтэй хамтатгаад хэлэлцээд явъя гэдэг ийм байр суурьтай байгаа.

Тэгээд би Б.Пүрэвдорж гишүүнд Байнгын хорооны хуралдаан дээр хэлсэн.

Хоёр талаасаа ажлын хэсгээ нэгтгэж байгуулаад хоёр хуулийн төслөө нэгтгэж хэлэлцээд явах бүрэн боломжтой.

Тийм учраас өнөөдөр Их Хурлын гишүүд Б.Пүрэвдорж гишүүний өргөн барьсан энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явъя гэдэг би ийм саналыг гаргаж байна.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Х.Нямбаатар сайдад баярлалаа.

Тэгэхээр ер нь миний өргөн бариад байгаа тэр ард түмний 10 хууль гэдэг дотор энэ хууль бол хүний эрхийг дээдэлсэн маш чухал хуулиудын нэг байгаа.

Тэгэхээр Монгол Улсын Засгийн газар бас яг энэ асуудлаар яг энэ хуультай, миний өргөн барьсан хуультай агуулга бүхий хуулийг маш яаралтайгаар оруулж ирсэн үндсэн шалтгаан бол энэ хууль олон нийтийн дэмжлэг авч батлагдах нь тодорхой болсон учраас бас миний өргөн барьсан хуулийг бас нэг хоёрдуулах санаачилгыг Засгийн газар луу авах ийм зорилгоор орж ирсэн гэдгийг бас хүлээн зөвшөөрч байна.

Тэгээд та бүхний энэ хүний эрхийг дээдэлсэн санаачлагад талархаж байна. Тэгээд хамтран хэлэлцэхэд буруутах юм байхгүй ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй гурав хүртэлх гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байна уу?

Тэгэхдээ хууль хэрэглээний асуудал юм уу? Дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор тайлбар

хийгээд шийдэх ёстой асуудал юм уу? Аан. Үг хэлж болно. Үг хэлэх гишүүд.

Баттөмөр Энхбаяр гишүүнээр тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Б.Пүрэвдорж гишүүний санаачилсан хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг дэмжсэн тохиолдолд хэд хэдэн анхаарах асуудал байгаа юм. Яг тэр хөндсөн заалтыг нэлээн анхаарах ёстой.

Тэр нь ямар заалт байна вэ гэхээр бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэх үүрэгтэй гэдэг заалтыг хасах гээд байгаа юм.

Тэгэхээр чинь үүрэггүй болчихно шүү дээ. Тэгэхээр чинь тэр Үндсэн хуульд заачихсан Монгол Улсын иргэний үндсэн үүрэг байгаа юм.

Тэгэхээр Монгол Улсын иргэний үндсэн үүргийг үүрэг биш болгож хувиргана гэхээр бид бараг Үндсэн хуулийнхаа асуудалд орох нягуур байгаа. Тэгэхдээ дэмжээд яг ямар тодотгол.

Хэрвээ би байсан яах байсан бэ гэхээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх гэж торгож байгаа тэр зөрчлийг харин янзлах байсан. Ийм ерөнхий том уут байж болохгүй. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй гэдэг бол бүр маш том уут шүү дээ. Энэ бол харин бүр хэнийг ч шийтгэж байж магадгүй уут байгаад байгаа юм.

Энэ том уутыг янзлах ёстой гэдэг том сануулгыг харин Б.Пүрэвдорж гишүүн хэлээд байгаа нь зөв байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас би нөгөө хэлэлцэхийг нь дэмжээд, одоо Засгийн газраас өргөн барьж байгаа тэр хуулийн төсөлтэй нь нэгтгээд Үндсэн хуулийнхаа тэр үзэл

санаанд нийцүүлж үндсэн иргэдийн үүргийг бид арай нухаж болохгүй шүү дээ. Бид бүх хүний нэр төрд хүндэтгэлтэй хандах үүрэгтэй. Хэнбуйгай ч гэсэн.

Энэ асуудлаа ч гэсэн Засгийн газар бас манлайлж ажиллаж байгаа. Хэний ч болов нэр төрд халдаж байгаа ийм үйлдлийг өөгшүүлж болохгүй. Тэгэхдээ үүнийг хууль сахиулагч өөрөөр хуулийг тайлбарлаад, тэр дургүй хүрсэн хүмүүсээ торгож шийтгэдэг ийм хавтгайрсан юм байж болохгүй.

Сая энэ хавтгайрсан гэдэг харагдаж байна шүү дээ. Нийслэлийн хоёр дүүрэг гэхэд л ялгаатай байж байна шүү дээ. Нийслэлийн хоёр дүүрэг. Одоо манай Баянзүрх дүүрэг бол ерөөсөө хүний эрхэд хамгийн мэдрэмжтэй, манай цагдаа, прокурорынхон бага шийтгэсэн байна. Нэг, хоёр л байна шүү дээ. Тэгэхэд тэр хамгийн захын баруун дүүрэг бол одоо яасан байх нь вэ. Хамгийн хүний эрхийн мэдрэмжгүй шийтгэсэн байна.

Тэгэхээр энэ хуулиасаа биш бас хүнээсээ болоод байна уу, үгүй юу гэдэг асуудлыг ч гэсэн бид дүгнэлт хийх шаардлагатай байна л гэсэн үг шүү дээ.

Тийм учраас хэлэлцэх эсэх асуудлыг шийдчихээд. Ер нь тэр Дорноговь аймгийн цагдаад сануулга өгөх ёстой юм байна шүү. Х.Нямбаатар сайд аа. Тэр чинь улсын хэмжээний торгосон торгуулийн тал нь нэг аймгийн цагдаа байна гэдэг бол энэ сануулга шүү. Харин. Энэ бараг Замын-Үүдийнх юм байх даа.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Ер нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор тайлбарлах шаардлагатай байж магадгүй юм байна. Яагаад гэвэл өөр өөр аймаг өөр өөрөөр хэрэглээд байна шүү дээ. Зарим аймаг

байхгүй. Тэгэхдээ энэ чинь нийтлэг хэрэглэгдэж чадахгүй байна. Дээд шүүх тайлбарлаж болно. Үндсэн хуулийн 17.1 дээр хүний үндсэн дөрвөн үүрэг байгаа. Хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх гэж.

Тэгэхээр Үндсэн хуулийг үгүйсгэж болохгүй. Үндсэн хуулиа дагаж ишлэн мөрдөх ёстой. Тэгээд тангараг өргөчихсөн. Тэгээд хэлэлцэх эсэхийг нь дэмжчихээд тэрний хууль хэрэглээнийх нь байдлыг нь тайлбарла энэ тэр гэх ямар арга замаар шийдэх ёстой юм.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналаар гишүүдийн олонх нь дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

**Бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ**  
**ШИНЖЭЭЧ**

Дараагийн асуудалд орно.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлнэ.

Хууль санаачлагч алга байгаа учраас энэ хуулийг хойшлууллаа. /алх цохив/

Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Илтгэл тавих ёстой. Х.Ганхуяг гишүүн татах санал ирсэн гэсэн. Тэр нь ирэхээр л. Энэ асуудлыг хойшлууллаа.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөн мэдэгдье. /алх цохив/

Үдээс хойш Төсвийн байнгын хорооны ажлын хэсэг, ажлын хэсгүүд хуралд.

Ц.АЛТАН-ОД